



European
Union



European Bank
for Reconstruction and Development

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ИРГЭНИЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТ/

Гүйцэтгэсэн: Содномдаржаа

Улаанбаатар хот

2025 он

Удиртгал

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1. 1 Үнэлгээ хийх шалтгаан
1. 2 Үнэлгээ хийх хүрээ
1. 3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт
1. 4 Үнэлгээний харьцуулах хэлбэр
1. 5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох
1. 6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3. 1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
3. 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5. 1 Дүгнэлт
5. 2 Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ 1

ХАВСРАЛТ 2

Удиртгал

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны тенхикийн хамтын ажиллагааны “Монгол Улсад арилжааны шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлтийг бэхжүүлэх нь” төслийн захиалгаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн¹ хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Ийнхүү судалгааг гүйцэтгэхдээ Хууль зүй, дотоод хэргийн яамны иргэний шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Ажлын хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангадаг гол байгууллага болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас мэдээлэл авч, санал солилцож хамтран ажиллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн иргэний шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой зарим зохицуулалтын хэрэгжилтийн явц дахь хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.²

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

² Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 2 дахь заалт.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. **Үүнд:**

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- Харьцуулах хэлбэрийг сонгох
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /цаашид “ШШГТХ” гэх/ нь 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, 2018, 2020, 2021, 2022, 2023, 2024 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон³ бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажиллагаа хийгдэж байсан хэдий ч дийлэнх нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал ажиглагдаж байна.⁴

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр зааагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох хүрээнд “Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна” гэж, “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж тус тус тусгаснаас гадна Шүүх засаглалыг бэхжүүлэх хүрээнд “Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын сайн жишигт хүргэнэ” гэж заасан.⁵

Мөн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, 2025 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан байна.⁶

Иймд дээрх шалтгаануудын үүднээс ШШГТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэн энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12701>

⁴ Дотоод хэргийн их сургуулийн хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ 2022.

⁵ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”.

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Тодруулбал, аргачлалын 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан.

Иймд захиалагч тал болон ХЗДХЯ-тай урьдчилан мэдэгдэж, тохирлцсоны дагуу үнэлгээ хийлгэх ач холбогдолтой зохицуулалтыг тодорхойлсон тул дараах зохицуулалтуудад үнэлгээ хийнэ. Үүнд:

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Зохицуулалтын агуулга
1.	Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх зохицуулалт болон дээрх хугацаанд ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтууд	
	27 дугаар зүйлийн 27.2.5 дахь заалт	27.2.5.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл хугацаагаар ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг түдгэлзүүлэх талаар
	44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг	44.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.
	44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг	44.4.Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.
2.	Үнэлгээ хийлгэх, үнэлгээнд гомдол гаргах талаарх зохицуулалт	
	27 дугаар 27.1.4 дэх заалт	27.1.Шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараах үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлж болно:

		27.1.4.гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөрт хураан авах хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол;
	55 дугаар зүйлийн 55.7 дахь хэсэг	55.7.Талууд эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо энэ хуулийн 55.3-т заасны дагуу мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.
3.	Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах ажиллагааны үе шатуудад хамаарах зохицуулалт болон үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх зохицуулалт	
	60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг	60.1.Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар төлбөр төлөгчийн хүсэлтэд заасан үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлж болно.
	63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг	63.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 64.5-д зааснаас бусад хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор, төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.
	68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг	68.1.Дуудлага худалдааг битүүмжилсэн, эсхүл барьцаалсан хөрөнгийг хураан авсны дараа явуулна.
	71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэг	71.14.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.
4.	Төлбөртэй этгээдийн бүртгэл ба эд хөрөнгийн мэдүүлгийн талаарх зохицуулалт	
	47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг	47.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.
	44 дүгээр зүйлийн 44.2.3 дахь заалт	44.2.3.төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
	46 дугаар зүйл	46 дугаар зүйл.Хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулах 46.1.Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр төлөгчөөс түүний хөрөнгийн тухай бичгээр мэдүүлэг авах бөгөөд мэдүүлэг гаргахын өмнө мэдүүлгийг худал гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна. 46.2.Хөрөнгийн тухай мэдүүлэгт төлбөр төлөгч дараахь мэдээллийг тусгана: 46.2.1.банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, бусад хөрөнгө; 46.2.2.бусдын эзэмшилд байгаа өөрийн өмчлөлийн хөрөнгө, ирээдүйд бий болох бусад хөрөнгө;

		46.2.3.ирээдүйд үүсэх орлого, түүнийг шаардах эрх. 46.3.Төлбөр төлөгч хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. 46.4.Төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн байдалд орсон өөрчлөлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, өөрчлөлтийг хөрөнгийн мэдүүлэгт тусгана. 46.5.Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд түүний хөрөнгийг эрэн сурвалжилна.
5.	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зөрчил, эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэхтэй холбоотой зохицуулалтууд буюу төлбөр төлөгчийн хариуцлага болон эрүү, зөрчлийн хууль дахь хариуцлагын талаарх зохицуулалт	
	9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг	9.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
	91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг	91.2.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, хөдөлмөр эрхлэх чадвартай бөгөөд хөдөлмөр эрхлээгүй үндэслэлээр тогтоосон тэтгэлгийг төлөхөөс зориуд зайлсхийсэн, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан хүн, хуулийн этгээд, төлбөр төлөгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
	120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэг	120.1.Тухайн хуулийн этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалан төлбөр төлөгчид олгуулахаар тогтоосон хугацаанд суутгал хийгээгүй бол хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
	49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсэг	49.8.Битүүмжилсэн, барьцаалсан хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах тухай шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг төлбөр төлөгч зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.
6.	Шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс ба урамшуулалтай болон урамшуулалгүй үеийн зохицуулалт	
	Шийдвэр гүйцэтгэгч төрийн тусгай албан хаагч үүнд хамаарах зохицуулалт болон урамшуулалгүй болсон 2017 оноос хойшхи болон урамшуулалтай буюу 2002-2017 он дуусталх үеийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, статистик мэдээлэлтэй уялдуулан судална.	
7.	Ахлах ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт	
	Ахлах шийдвэр гүйцэтгэгч хувийн хэрэг нээх, ажиллагаа үүсгэх тогтоол гаргах /21.1/, ажиллагааг түдгэлзүүлэх, ажиллагааны талаарх гомдлыг хянах /44.3, 44.6/, түдгэлзүүлсэн хугацаанд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн ажиллагааг сэргээх /27.2, 27.2.5, 27.6, 27.7/, ажиллагааг дуусгавар болгож хувийн	

хэрэг хаах /29.1/, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх /44.2.7, 48.8/, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргах, ахлан шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэх /59.3/, ахлах шийдвэр гүйцэтгэгч дуудлага худалдаа явуулах тогтоол гаргах /69.1/

1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Өмнөх үе шатанд үнэлгээ хийхээр сонгосон зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг тогтооход туслах Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

Д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Зохицуулалтын агуулга	Шалгуур үзүүлэлт
1.	Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх зохицуулалт болон дээрх хугацаанд ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтууд		Практикт нийцэж байгаа байдал
	27 дугаар зүйлийн 27.2.5 дахь заалт	27.2.5.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг түдгэлзүүлэх талаарх зохицуулалт.	
	44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг	44.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.	
	44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг	44.4.Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.	
2.	Үнэлгээ хийлгэх, үнэлгээнд гомдол гаргах талаарх зохицуулалт		

	27 дугаар 27.1.4 дэх заалт	27.1.Шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараахь үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлж болно: 27.1.4.гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөрт хураан авах хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол;	Практикт нийцэж байгаа байдал
	55 дугаар зүйлийн 55.7 дахь хэсэг	55.7.Талууд эд хөрөнгийн үнэлгээний талаархи гомдлоо энэ хуулийн 55.3-т заасны дагуу мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.	
3.	Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах ажиллагааны үе шатуудад хамаарах зохицуулалт болон үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх зохицуулалт		Практикт нийцэж байгаа байдал
	60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг	60 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх 60.1.Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар төлбөр төлөгчийн хүсэлтэд заасан үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлж болно.	
	63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг	63.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 64.5-д зааснаас бусад хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор, төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.	
	68 дугаар зүйл	68.1.Дуудлага худалдааг битүүмжилсэн, эсхүл барьцаалсан хөрөнгийг хураан авсны дараа явуулна. 68.2.Дуудлага худалдааг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор явуулна.	
	71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэг	71.14.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.	
4.	Төлбөртэй этгээдийн бүртгэл ба эд хөрөнгийн мэдүүлгийн талаарх зохицуулалт		Практикт нийцэж байгаа байдал
	47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг	47 дугаар зүйл.Төлбөртэй этгээдийн бүртгэл 47.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаархи мэдээллийг	

		цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.	
	44 дүгээр зүйлийн 44.2.3 дахь заалт	44.2.3.төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;	
	46 дугаар зүйл	46 дугаар зүйл.Хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулах 46.1.Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр төлөгчөөс түүний хөрөнгийн тухай бичгээр мэдүүлэг авах бөгөөд мэдүүлэг гаргахын өмнө мэдүүлгийг худал гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна. 46.2.Хөрөнгийн тухай мэдүүлэгт төлбөр төлөгч дараахь мэдээллийг тусгана: 46.2.1.банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, бусад хөрөнгө; 46.2.2.бусдын эзэмшилд байгаа өөрийн өмчлөлийн хөрөнгө, ирээдүйд бий болох бусад хөрөнгө; 46.2.3.ирээдүйд үүсэх орлого, түүнийг шаардах эрх. 46.3.Төлбөр төлөгч хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. 46.4.Төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн байдалд орсон өөрчлөлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, өөрчлөлтийг хөрөнгийн мэдүүлэгт тусгана. 46.5.Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд түүний хөрөнгийг эрэн сурвалжилна. 46.6.Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус гуравдагч этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн байдлын талаар бичгээр мэдүүлэг авч болно. 46.7.Энэ хуулийн 46.6-д заасны дагуу мэдүүлэг гаргахад энэ хуулийн 46.2, 46.3-т заасан журам нэгэн адил хамаарна.	
5.	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зөрчил, эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэхтэй холбоотой зохицуулалтууд буюу төлбөр төлөгчийн хариуцлага болон эрүү, зөрчлийн хууль дахь хариуцлагын талаарх зохицуулалт		Практикт нийцэж байгаа байдал

	9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг	9.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	
	91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг	91.2.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, хөдөлмөр эрхлэх чадвартай бөгөөд хөдөлмөр эрхлээгүй үндэслэлээр тогтоосон тэтгэлгийг төлөхөөс зориуд зайлсхийсэн, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан хүн, хуулийн этгээд, төлбөр төлөгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	
	120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэг	120.1.Тухайн хуулийн этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалан төлбөр төлөгчид олгуулахаар тогтоосон хугацаанд суутгал хийгээгүй бол хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	
	49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсэг	49.8.Битүүмжилсэн, барьцаалсан хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах тухай шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг төлбөр төлөгч зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.	
6.	Шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс ба урамшуулалтай болон урамшуулалгүй үеийн зохицуулалт		Практикт нийцэж байгаа байдал
	Шийдвэр гүйцэтгэгч төрийн тусгай албан хаагч үүнд хамаарах зохицуулалт болон урамшуулалгүй болсон 2017 оноос хойшхи болон урамшуулалтай буюу 2002-2017 он дуусталх үеийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, статистик мэдээлэлтэй уялдуулан судална.		
7.	Ахлах ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт		Практикт нийцэж байгаа байдал
	Ахлах шийдвэр гүйцэтгэгч хувийн хэрэг нээх, ажиллагаа үүсгэх тогтоол гаргах/21.1/, ажиллагааг түдгэлзүүлэх, ажиллагааны талаарх гомдлыг хянах /44.3, 44.6/, түдгэлзүүлсэн хугацаанд хяналт тавих , шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн ажиллагааг сэргээх /27.2, 27.2.5, 27.6, 27.7/, ажиллагааг дуусгавар болгож хувийн хэрэг хаах /29.1/, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх /44.2.7, 48.8/, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргах, ахлан шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэх /59.3/, ахлах шийдвэр гүйцэтгэнч дуудлага худалдаа явуулах тогтоол гаргах /69.1/		

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, заалтын хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухай хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1. 4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1 дэх “байх ёстой болон одоо байгаа байдал”,⁷ мөн 3.5.3.4 дэх “тохиолдол судлах”⁸ хэлбэрүүдийг тус тус сонголоо.

Үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтуудын хувьд “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр шалгахаар тогтоосон тул үүнтэй уялдуулан дээрх харьцуулах хэлбэрийг сонгосон болно.

Мөн үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтууд бусад улс орнуудын хувьд хэрхэн хэрэгждэг талаар судлах үүднээс “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгосон болно. Учир нь бусад улс орнуудын хууль эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах нь тус хуулийг сайжруулахад зайлшгүй хийгдэх ёстой судалгаа гэж үзлээ.

Харин “байх ёстой болон одоо байгаа байдал” харьцуулах хэлбэрийг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагаврыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохоор сонгов.

1. 5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Дээр тайлбарласан ёсоор энэхүү үнэлгээг хийхэд практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авсан болно. Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах асуултуудыг боловсрууллаа.

- Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх зохицуулалт болон дээрх хугацаанд ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтууд /27.2.5, 44.4, 44.3/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Үнэлгээ хийлгэх, үнэлгээнд гомдол гаргах талаарх зохицуулалт /27.1.4, 55.7/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах ажиллагааны үе шатуудад хамаарах зохицуулалт болон үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн

⁷ Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

⁸ Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэмж хэмжээ өөр, өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

удирдлагад шилжүүлэх зохицуулалт /60 дугаар зүйл, 63.1, 71.14, 68.1 , 68.2, 22.1/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

- Төлбөртэй этгээдийн бүртгэл ба эд хөрөнгийн мэдүүлгийн талаарх зохицуулалт/47.1, 46 дугаар зүйл, 44.2.3/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зөрчил, эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэхтэй холбоотой зохицуулалтууд буюу төлбөр төлөгчийн хариуцлага болон эрүү, зөрчлийн хууль дахь хариуцлагын талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс ба урамшуулалтай болон урамшуулалгүй үеийн зохицуулалт
- Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны ажил уншиж, судлах, харьцуулалт хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашиглана.**Үүнд:**

- ШШГТХ-тай холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, бусад эрх зүйн баримт бичиг, ном сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланд дүн шинжилгээ хийх;
- Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тайлан, статистикийг ашиглах;
- Практикт тулгарсан тодорхой кэйсүүдэд дүн шинжилгээ хийх;
- Гадаад улсын холбогдох зохицуулалтыг харьцуулан судлах
- Шүүхийн шийдвэрүүдийг судлах замаар үнэлгээг хийхэд ашиглах холбогдох чанарын болон тоон мэдээллийг цуглуулна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ШШГТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ бэлэн байгаа мэдээллийг цуглуулах аргаар холбогдох материалыг цуглуулан үнэлгээг хийсэн болно.

- *Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах*

Хууль, эрх зүйн акт

Монгол Улсын Үндсэн хууль 1992

Монгол Улсын Иргэний хууль 2002

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002

Эрүүгийн хууль 2015

Зөрчлийн тухай хууль 2017

Статистик мэдээ, судалгаа /Хавсралт 1, 2/

Гадаад дотоодын цахим эх сурвалж

Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ <https://shuukh.mn>

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу ШШГТХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

▪ **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх зохицуулалт болон дээрх хугацаанд ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтууд /27.2.5, 44.4, 44.3/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Гомдол гаргах зохицуулалт

ШШГТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсэгт “Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.” гэж тус тус заасан.

Мөн ШШГТХ-ийн 44.3-т Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно гэж, 44.4-т Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, ажиллагаа бүрд төлбөр төлөгч гомдол гаргах боломжтой бөгөөд гомдлыг шууд шүүхэд, эсхүл шүүхээс өмнө ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргасны дараа ч шүүхэд гаргаж болно.

Гомдол гаргасны үр дагавар нь гомдлыг шийдвэрлэж дуустал ажиллагаа түдгэлзэж зогсох юм.

Тиймээс энэхүү зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгааг судлан үзлээ.
Үүнд:

Шүүхээс өмнөх шатны гомдол

Шүүхээс өмнөх шатанд гаргах гомдлын тал орчим хувь нь төлбөр авагчийн гомдол байгаа ч шүүхийн шатанд бол төлбөр төлөгчийн гомдол нийт шүүхэд гаргасан гомдлын 70 гаруй хувь байдаг. Учир нь төлбөр авагчид ажиллагааг түдгэлзүүлж удаашруулах ашиг сонирхол байхгүй тул шүүхэд цөөвтөр гомдол гаргаж байгаа дүр зураг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /цаашид “ШШГЕГ” гэх/-ын статистик⁹ мэдээллээс харахад шүүхээс өмнөх шатанд дээд албан тушаалтанд гаргасан нийт гомдлын тал орчим хувийг төлбөр авагчийн зүгээс ажиллагаа удаашралтай талаар ахлах болон ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргасан гомдол эзэлж байна.

Тухайлбал, ахлах шийдвэр гүйцэтгэгчид 2024 онд нийт гаргасан гомдол 699 байхад үүний 335 нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралтай гэх төлбөр авагчийн гомдол буюу нийт ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргасан гомдлын 47.9 хувь нь төлбөр авагчийн гомдол байна.¹⁰

Ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж, гомдлыг шийдвэрлэснийг эс зөвшөөрвөл ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж шийдвэрлэх үе шатны хугацааг авч үзвэл¹¹ урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хувьд шүүхэд хандахаас өмнө хамгийн багадаа 65 хоногийг гомдлыг дээд шатны албан тушаалтнуудад буюу ахлах болон ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргаж, ажиллагааг энэ хэмжээгээр удаашруулдаг байна.

Дээрх хугацаанд ажиллагаа түдгэлзэж болох ч шүүхэд гомдлыг гаргахад үүнээс ч урт хугацаагаар түдгэлзэхээр тул төлбөр авагч шүүхэд тэр бүр гомдол гаргахгүй, ихэвчлэн төлөгч түдгэлзүүлэх зорилгоор үндэслэлтэй, үндэслэлгүй түгээмэл байдлаар гомдлыг шүүхэд ихэвчлэн гаргаж байна.

Шүүх дэх гомдлын шийдвэрлэлт

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1-д “Шүүх дараах хэргийг гомдлоор авч хэлэлцэнэ” гэж, 156.1.3-т “шүүх шийдвэрлэхээр хуульд заасан бусад гомдол” гэж, мөн зүйлийн 156.2-т “Гомдлоор авч хэлэлцэх хэргийг шүүх энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ.” гэж тус тус заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний хэргийн шүүхэд гомдол гаргадаг бөгөөд ингэснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /enforcement agents and debtors/ дараах иргэний хэрэг хянан шийдвэрлэх /litigation process/-ын талууд болж хувирдаг. **Үүнд:**

- шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүнийг төлөөлж шийдвэр гүйцэтгэгч enforcement agents нь хариуцагч буюу (defendant) болох;
- төлбөр төлөгч debtor нь нэхэмжлэгч буюу (claimant) болж, хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаа (litigation)-ны оролцогчийн эрх, үүргийг эдэлж эхэлдэг.

Статистик мэдээллээс үзэхэд 2023 онд 546, 2024 онд 575 шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэрэгт шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцагч

⁹ Ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргасан өргөдөл гомдлын судалгаа 2024 /Хавсралт 1-ийн статистик 1-ийг үзнэ үү./

¹⁰ Ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргасан өргөдөл гомдлын судалгаа 2024 /Хавсралт 1-ийн статистик 1-ийг үзнэ үү./

¹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44.3, 44.4 дэх хэсэг.

(defendant)- аар татагдан оролцсон байна.¹² Эдгээр тохиолдол бүрд урт удаан хугацааны турш шүүхэд төлөөлж, шүүх хуралд оролцох бэлтгэл хангаж, оролцох байдлаар цаг хугацааг үр ашиггүй өнгөрөөхөөр байдаг буюу ажиллагаа нь түдгэлзэж зогссон байдаг.

Төлбөр төлөгчийн шүүхэд гаргасан гомдлын хувь

Он	Шүүхэд гаргасан гомдол	Төлбөр төлөгчийн нэхэмжлэлтэй гомдол	Нийт шүүхэд гаргасан гомдолд эзлэх төлбөр төлөгчийн гомдлын хувь хэмжээ
2023	546	425	77.8 %
2024	575	444	77.2%

Эх сурвалж: Шийдвэр гүйцэтгэгч хариуцагчаар шүүхэд татагдсан тохиолдлын судалгаа, 2025. /Хавсралт 1-ийн статистик 2-ыг үзнэ үү./

Төлбөр авагчийн шүүхэд гаргасан гомдлын хувь

ШШГЕГ-аас ирүүлсэн 2022 оны статистик мэдээллээс харахад 2022 оны байдлаар ажиллагаатай байсан болон байгаа материалуудаас 786 гүйцэтгэх хуудасны 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг битүүмжлэн хурааснаас 508 гомдлыг шүүхэд гаргасан байна. Эдгээр гомдлын 435 нь төлбөр төлөгчийн гаргасан, харин гуравдагч этгээд буюу өмчлөгчийн гаргасан нь 57 байна.¹³

Харин нийт шүүхэд гаргасан гомдлын ердөө 3 хувь нь төлбөр авагчийн гаргасан гомдол байх тул иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалт нь төлбөр төлөгчийн ажиллагааг удаашруулах буюу түдгэлзүүлэх зохицуулалтыг ашиглах тактик болох боломжийг олгосон гэж үзэхээр байна.¹⁴

Шүүхэд гаргасан гомдол үндэслэлтэй эсэх

Үүнээс гомдол шүүхэд гаргаснаас гомдлыг хангаж шийдвэрлэсэн тохиолдлын тоо, хувийг харуулав. Үүнд:

- 2023 онд 546 гомдол шүүхэд гаргаснаас 28 гомдлыг хангасан буюу нийт гомдлын 5.1 хувь;
- 2024 онд 575 гомдлыг шүүхэд гаргаснаас гомдлыг хангаж шийдвэрлэсэн 43 буюу гомдлыг хангаж шийдвэрлэсэн тохиолдол нийт гомдлын 7.8 хувь.

Харин гомдлыг хангаж шийдвэрлэснээс бусад гомдлын хувьд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл нэхэмжлэлийг буцаасан байна.¹⁵

Шүүхэд гаргасан төлбөр төлөгчийн гомдлыг шийдвэрлэсэн хугацаа

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай гомдлыг шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт нь 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн

¹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2024 он.

¹³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2022 он.

¹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2022 он.

¹⁵ Шийдвэр гүйцэтгэгч хариуцагчаар шүүхэд татагдсан тохиолдлын судалгаа, 2025. /Хавсралт 1-ийн статистик 2-ыг үзнэ үү./

хэрэгжиж эхэлсэн бөгөөд үүний дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлтийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдлыг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75² дугаар зүйлийн 75^{2.3}-т “Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.” гэж, мөн зүйлийн 75^{2.4}-т “Энэ хуулийн 75^{2.3}-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэж тус тус зааснаас үзэхэд шүүхэд гомдол гаргах замаар ажиллагааг хэргийн оролцогч шүүх хуралданыг хойшлуулах, шүүгчээс татгалзах зэрэг зохигчийн эрхээ эдлэхгүй бол хамгийн багадаа 45-59 хоногийн хугацаагаар шийдвэрлэхээр болсон байна.

Гэвч энэ нь мөн л litigation үе шатны гомдол шийдвэрлэлт бөгөөд шүүх хуралдаан хийж мэтгэлцэх зарчим үйлчилж, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болж, төлбөр төлөгч нэхэмжлэгч болсон хэвээр.

Уг хуулийн өөрчлөлт хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул 2024 оны 10 сараас өмнөх гомдол шийдвэрлэлтийн хугацааг авч үзье.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай гомдлыг шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх зохицуулалт хэрэгжиж эхлэхээс өмнө хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн хугацааны хувьд дараах тоо баримтаас үзэхэд дундажаар 1-2 жил шийдвэрлэдэг байдал ажиглагдаж байна. **Үүнд:**

2022 оны байдлаар шүүхэд гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн хугацаагаар нь ангилан авч үзэхэд 1 жилд 142, 1-3 жилд 157, 3 жилээс дээш 34, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаагүй 175 байна.¹⁶

Шигтгээ 1

Төлбөр авагч Х банкинд төлбөр төлөгч М ХХК, И ХК 1.8 их наяд төгрөгийн үүргийн гүйцэтгэлд барьцаа хөрөнгийг албадан худалдах гүйцэтгэх хуудастай хэрэгт 2019 оны 09 сард ажиллагаа үүсгэж, барьцаа хөрөнгийг 2 удаа үнэлүүлсэн. Үнэлгээ бүрд төлбөр төлөгч тус бүр шүүхэд гомдол гарган 2023 оны 3 сарын байдлаар нийт 4 жил ажиллагааг түдгэлзүүлсэн байдалтай байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

Шигтгээ 2

Төлбөр төлөгчөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлын дагуу 2018 онд иргэний хэргийн анхан шатны шүүх иргэний хэрэг үүсгэж, төлбөр төлөгч /иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэгч/-ийн хувиар гаргасан удаа дараа хурал хойшлуулах болон шүүгчээс татгалзах хүсэлт (хэргийн оролцогчийн эрх эдлэн) зэргээс шалтгаалан өнөөдрийг хүртэл иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдээгүй буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой төлбөр төлөгчийн гаргасан гомдол шийдвэрлэгдээгүй удсан, үүнийг дагаад ажиллагаа 5 жил зогссон.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

Дүгнэлт

ШШГТХ-ийн 27.2.5 дахь заалтад “энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл;” ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрээр түдгэлзүүлэхээр заасан.

Тийм учраас гомдол шүүхэд шийдвэрлэх хугацаа урт байдлыг болон ШШГТХ-ийн 27.2.5-ыг ашиглах зорилгоор төлбөр төлөгч нь ажиллагааг түдгэлзүүлэх л гэж шүүхэд гомдол гаргадаг байж болзошгүйг төлбөр төлөгчийн шүүхэд гаргасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол нийт шүүхэд гаргасан гомдлын 70 гаруй хувийг эзэлж буй байдал болон төлбөр төлөгчийн эдгээр гомдлын 90-ээс дээш хувь нь үндэслэлгүй гомдол байгаагаас харж болохоор байна.

ШШГТХ-ийн шүүхэд бүхий л асуудлаар гомдол гаргах боломж олгосон зохицуулалт, гомдлыг шийдвэрлэх хугацаанд ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалт нь практикт сөрөг үр дагавар үүсгэж байгааг илтгэж байна.

Гомдлыг хаана, ямар журмаар, ямар үндэслэлээр гаргаж, ямар хугацаанд шийдвэл зохих, гомдол шийдвэрлэтэл ажиллагааг түдгэлзүүлэх нь гомдол олноор гаргаж удаашрал үүсгэх шалтгаан болж байгаа тул энэхүү зохицуулалт хэрэгцээтэй эсэхийг судлах зорилгоор бусад улсын зохицуулалтыг үзье.

Бусад улсын туршлага

Гомдол гаргах

БНСУ-д нэн даруй гомдол гаргах (**immediate compliant**) буюу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрт зөвхөн хуульд заасан үндэслэлээр нэн даруй гомдол гаргаж болдог.¹⁷ ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэлийн шүүх нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдлыг хянадаг байна.¹⁸

¹⁷ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

¹⁸ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html



Эх сурвалж: ХБНГУ-ын Бавариа мужийн Хууль зүйн яам, Дээд шүүхийн шүүгчдийн илтгэл, 2024.12.01

ХБНГУ-д шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаанд шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч хяналт тавьдаг. Хэрэв талуудаас шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаанд гомдол гаргавал дундажаар 7-14 хоногт шуурхай бөгөөд шүүх хурал хийлгүйгээр шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шийддэг. Энэ нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар мэтгэлцэн, заавал шүүх хурлаар шийддэг ажиллагаа биш зөвхөн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны хавтаст хэргээс холбогдох материалыг харгалзан бичгээр шуурхай шийдвэрлэдэг процессын гомдол болно.¹⁹ ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 793-т зааснаар уг гомдлыг амаар хэлэлцсэн хурал хийлгүй /without a hearing for oral argument being held/, бичгээр богино хугацаанд шийдвэрлэнэ.²⁰

Мөн давж заалдах шатны шүүхэд шийдвэр гүйцэтгэлийн асуудал хариуцсан дээрх шүүгчийн шийдвэрт гомдол гаргаж болох ч мөн л шуурхай 7 хоногоос 1 сарын дотор шүүх хурал хийлгүй, бичгэн нотлох баримтын хүрээнд шийддэг. Үндсэндээ шийдвэр гүйцэтгэл явуулсан ажиллагааны хавтаст хэрэг л нотлох баримт нь болдог. Жилдээ 200 гаруй л гомдол шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор гарсан байна. Үүнээс ихэнх нь төлбөртэй этгээдийн бүртгэлээс гаргуулах тухай гомдол байсан байна.²¹

Дүгнэвэл, дараах нийтлэг үр дүнтэй зохицуулалт байна. **Үүнд:**

- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эсрэг гаргах гомдлыг шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгчид бичгээр гаргах буюу ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргаж удаашруулах шаардлагагүй;

¹⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

²⁰ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

²¹ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол нь litigation үе шатны биш enforcement үе шатны ажиллагаа;
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдлыг гаргах тодорхой үндэслэлийг хуульчлах, одоогийн хуулийн зохицуулалтаар бүхий л тохиолдолд гомдол гаргах боломжтой задгай байгааг хумих;
- гомдлыг гомдол гаргагч тодорхой нотлох баримттай гаргах, харин шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хийсэн бүхий л ажиллагааг ажиллагааны материалаас шийдвэр гүйцэтгэлийн шүүгч цахимаар танилцах боломжтой байдлаар зохицуулах боломжтой байна;
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол нь law suit биш objection, complaint бөгөөд энэ утгаараа шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шуурхай 7-14 хоногт шийдвэрлэдэг буюу аман хуралдаан хийх шаардлагагүй.

Түдгэлзүүлэх асуудлаар

БНСУ-ын хувьд, нэн даруй гомдол гаргах нь гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй. Гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл төлбөр төлөгчийн барьцаатайгаар, эсхүл барьцаагүйгээр шийдвэрийн биелэлтийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх шийдвэр гаргах, эсхүл төлбөр авагчийн барьцаатайгаар гүйцэтгэлийн ажиллагааг үргэлжлүүлэх шийдвэр гаргана. Энэ түдгэлзүүлэх, эсхүл үргэлжлүүлэх шийдвэрт гомдол гаргаж үл болно.²²

Мөн ХБНГУ-ын хувьд, гомдол гаргасан бол шүүх хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг төлбөр төлөгчөөс баталгаа гаргуулан эсхүл, баталгаа гаргуулахгүйгээр түр түдгэлзүүлэх, эсхүл зөвхөн төлбөр авагчаас баталгаа гаргуулсныг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна. Төлбөр авагч баталгаа гаргаж чадахгүй, эсхүл онцгой хүндрэлтэй байгаа бөгөөд хойшлуулах нь төлбөр авагчид нөхөн төлөхөд бэрхшээлтэй байх, эсхүл хохирол учрахаар бол эсхүл, бусад шалтгааны улмаас төлбөр авагч зөвшөөрөхгүй байгаа бол хүсэлтийг ньүндэслэн шүүхийн шийдвэрийг урьдчилсан байдлаар гүйцэтгэх боломжтойд тооцно. Төлбөр авагчийн ашиг сонирхол илт давамгай байх тохиолдолд төлбөр төлөгчийн түдгэлзүүлэх хүсэлтийг хангахгүй зохицуулалттай байна.²³

Дүгнэвэл, дараах нийтлэг үр дүнтэй зохицуулалт байна. **Үүнд:**

- шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргасан нь ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй
- гомдлыг шийдвэрлэх хугацаа ч богино байдаг, хэрэв энэ хугацаанд түдгэлзүүлэх бол төлбөр төлөгч баталгаа гаргаж, төлбөр авагчийн ашиг сонирхолд ноцтой харшлахгүй бол ажиллагааг гомдлыг хэлэлцэх хугацаанд түдгэлзүүлэх шалгуурыг хуульчилсан.
- **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2.** Үнэлгээ хийлгэх, үнэлгээнд гомдол гаргах талаарх зохицуулалт /27.1.4, 55.7/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

²² https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

²³ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

Үл хөдлөх эд хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулахаар ШШГТХ-ийн 63.1-д заасан. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийлгэсний дараа л үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.

Харин ШШГТХ-ийн 55.7-д “Талууд эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн үнэлгээний гомдлыг үнэлгээг зөвшөөрөхгүй л бол шүүхэд гаргахаар зохицуулсан.


ШШГТХ-ийн 27.1.4-д заасны дагуу шүүгч хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол түдгэлзүүлэхээр заасан тул төлбөр төлөгч үнэлгээний талаарх гомдлыг шүүхэд гарган ажиллагааг зориуд удаашруулах, түдгэлзүүлэх зохицуулалтыг ашиглах зорилгоор үндэслэлтэй, үндэслэлтгүй түгээмэл байдлаар үнэлгээний гомдол гаргаж байна.

Иймээс үнэлгээний гомдол гарснаар практикт ямар асуудал үүсч буйг авч үзье.

Үнэлгээний гомдол гаргах нь түдгэлзүүлж, удаашруулах арга хэрэгсэл

2023 онд 229 үнэлгээний гомдлыг шүүхэд гаргаснаас 3 гомдлын хувьд үнэлгээг хүчингүйд тооцсон, 2024 онд гомдлоос 4 үнэлгээг хүчингүйд тооцсоноос үзэхэд,²⁴ үнэлгээний гомдол нийт гомдлын 60.2 хувь нь, мөн ихэнх тохиолдолд үндэслэлгүй гомдол байх бөгөөд нөгөө талаас үнэлгээний гомдол шийдвэрлэгдэхгүй талууд ажиллагааг удаашруулах зорилгоор гаргадаг арга хэрэгсэл болсныг илтгэж байна.

Үнэлгээний гомдлын нийт гомдолд эзлэх хувь дунджаар 60 хувь



Шүүхээс үнэлгээтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал /Хавсралт 1-ийн статистик 8-аас 2024 оны байдлаархыг үзнэ үү./

Үнэлгээний талаар шүүхэд гаргасан гомдол 2023 онд 362 буюу нийт 546 гомдлын 66.3 хувь нь үнэлгээний гомдол байсан бол 2024 онд үнэлгээний гомдол 377

²⁴ Хавсралт 1-ийн статистик 2-ыг үзнэ үү.

буюу нийт 486 гомдлын 77.5 хувь нь үнэлгээний гомдол байсан байна.²⁵ Харин 2023 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 31.5 хувь буюу 172 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн бол 2024 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 35.8 хувь буюу 174 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн байна.²⁶

2023 оны байдлаар 267 тэрбумын 330 төлбөр төлөгчид хамаарах ажиллагаа үнэлгээний гомдол шүүхэд гаргаснаас улбаалан түдгэлзсэн байна.²⁷

Үнэлгээний гомдлыг шүүхээс шийдвэрлэсэн хугацаа

Үнэлгээний үнэлгээ тогтоосон үнэлгээний тайланг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах нь дараах эрсдэлийг авчирч байна.²⁸ **Үүнд:**

- ойролцоогоор 2-4 жил ажиллагаа зогсох;
- төлбөр авагч төлбөрөө барьцаа хөрөнгөөс хүртэл гаргуулах боломжгүй удах.

Шигтгээ 1

2016 оны 4 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн. 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр анхны албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарласан боловч үнийн санал ирээгүй тул хоёр дахь албадан дуудлага худалдаанд 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хийж, хөрөнгө худалдан борлогдож иргэн 3 дуудлага худалдааны ялагчаар тодорсон. Үнэлгээг хүчингүй болгуулахаар 2017 оны 12 дугаар сард иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2019.09 сард УДШ хяналтын гомдлыг хуралдаанаар хэлэлцэхээс татгалзсан. Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхисон үндэслэл нь хуульд заасан үнэлгээний талаарх гомдол гаргах 7 хоногийг хэтрүүлсэн гэх боловч зөвхөн энэхүү шийдвэрийг гаргахын тулд 2 жил болж, ажиллагааг ийнхүү хугацаагаар түдгэлзэхэд хүргэжээ. Үүний дараа 2022.05.24-ний өдөр хамтран зээлдэгч 3 нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлийн шаардлага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.5 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээ хийгдсэнээс хойш 4 жил 5 сар өнгөрсөн тул ҮХЭХ-ийг дахин үнэлгээ тогтоолгохыг шийдвэр гүйцэтгэгчид даалгах, анхны албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах бөгөөд одоо болтол ажиллагаа түдгэлзсэн байдалтай байх буюу 7 жил төлбөр авагч барьцаа хөрөнгөөс төлбөр гаргуулж чадахгүй, ялагч 2017 оны 11 сараас хойш өмчлөлийн хөрөнгөө авч чадахгүй 6 жил болж байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

Шигтгээ 2

2019 оны 09 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлсэн. 2022 оны 09 сард үнэлгээг хүчингүйд тооцуулах нэхэмжлэгчийн гомдлыг УДШ хангахгүй орхисон. Ажиллагаа эхэлснээс хойш 2 жил өнгөрсөн гэж дахин үнэлгээ хийлгүүлэх хүсэлтийг төлбөр төлөгч тавьж дахин үнэлгээ хийлгэж, энэхүү үнэлгээг хүчингүй болгуулахаар 2022 оны 12 сард хамтран зээлдэгч шүүхэд нэхэмжлэл гаргаж, ажиллагаа 2023 оны 3 сарын байдлаар түдгэлзсэн байх ба хоёр дахь албадан дуудлага худалдаанд барьцаа хөрөнгийг оруулж чадахгүй байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

²⁵ ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

²⁶ ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

²⁷ Т.Наранцогт, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

²⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023-аас.

Шигтгээ 3

2021 оны 2 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлсэн. 2021 оны 09 сард үнэлгээний асуудлаар иргэний хэргийн анхан шатны шүүхэд төлөгч нэхэмжлэл гаргаж, 2022 оны 02 сарын 22-нд төлөгчийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Үндэслэл нь зах зээлийн ханшаас багаар үнэлсэн асуудал тогтоогдохгүй байх тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна. Давж заалдах шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 2022 оны 07 сард УДШ хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан. 2022 оны 09 сард АДХ-ны ялагч тодорсон ч үүний дараа 2022.10.27-нд албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг мэдэгдээгүй гэх үндэслэлээр шүүхэд гаргасан, ажиллагаа түдгэлзсэн байна. 2022 оны 11.09-нд албадан чөлөөлөх байсан ч нэхэмжлэгчийн албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй иргэний хэргийг шүүхээс шийдвэрлэж, хуулийн хүчин төгөлдөр болтол ИХШХШтХ-ийн 69.1.5-д зааснаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулах тухай нэхэмжлэгчийн хүсэлтийг шүүх хангасан байна. 2023 оны байдлаар.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

Шигтгээ 4

2018 оны 6 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэж, 2018 оны 10 сарын 31-нд үнэлгээг талуудад мэдэгдсэн ч мөн оны 12.18-нд шүүхэд гомдол гаргаж, хуульд заасан 7 хоногийг хэтрүүлсэн ч шүүх үнэлгээг хүчингүй болгуулах гомдлыг хүлээн авч 3 шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгосон. Анхан шатны шүүхээс гомдлыг хүчингүй болгохдоо үнэлгээчин томилсон шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа хууль зөрчөөгүй байна гэж, давж заалдах шатны шүүхээс зах зээлийн ханшаас доогуур үнэлсэн гэх нотлох баримт байхгүй байна гэж шийдсэн. Ийнхүү 3 шатны шүүхээс 2 жилийн хугацаанд тухайн хэргийг эцэслэн шийджээ. 2019 оны 11 сард АДХ-аар ялагч тодорсон боловч хөрөнгийг битүүмжилж, хураан үнэлүүлэх үед насанд хүрээгүй байсан хамтарн өмчлөгч үнэлгээг хүчингүй болгуулах нэхэмжлэл, гомдлыг 3 шатны шүүхэд гарган, үүний дараа АДХ-г хүчингүй болгуулахаар 3 шатны шүүхэд нэхэмжлэл, гомдол гарган 2022 оны 10 сарын 10-нд хэргийг шүүхээс эцэслэн шийдсэн байна. 4 жил 4 сарын дараа барьцаа хөрөнгөөс төлбөр авагч хөрөнгөө гаргуулж авч, ялагч 3 жилийн дараа ҮХЭХ-ийг өмчлөх боломжтой болсон байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023 /Хавсралт 2 дахь дэлгэрэнгүйг үзнэ үү./

Шигтгээ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр төлбөр төлөгчийн гомдлын дагуу 2018 онд иргэний хэргийн анхан шатны шүүх иргэний хэрэг үүсгэж, төлбөр төлөгч нэхэмжлэгчийн гаргасан удаа дараа хурал хойшлуулах болон шүүгчээс татгалзах хүсэлт зэргээс шалтгаалан иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдээгүй буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх

Дүгнэлт

Үнэлгээ зах зээлийн ханшаас доогуур, эсхүл үнэлгээний үнэд их хэмжээний өөрчлөлт орсон гэх үндэслэлээр шүүхэд гомдол гаргах ШШГТХ-ийн 55.7-ийн хүрээнд гаргасан төлбөр төлөгчийн гомдол нийт шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд гаргасан гомдлын ихэнх буюу 60 орчим хувийг эзэлж байна.

Гэтэл 2023 онд гаргасан үнэлгээний 362, 2024 онд гаргасан 377 гомдлыг шүүх шийдвэрлэхдээ үнэлгээг хүчингүйд тооцсон нь 2023 онд 3, 2024 онд 4 бөгөөд ихэнх тохиолдолд үнэлгээг үндэслэлгүй тогтоосон гэх нотлох баримт үгүй байна гэж хэргийг хэрэгсэхгүй болгож байна.

Учир нь үнэлгээний гомдлыг гаргаснаар шүүх ШШГТХ-ийн 27.1.4-т зааснаар ажиллагааг түдгэлзүүлдэг тул түдгэлзүүлж, удаашруулах зорилгоор уг гомдлыг гаргадаг практик тогтсон байна.

Бусад улсын туршлага

Одоо мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд үнэлгээг дахин хийлгэх зохицуулалт байхгүй байна.

Бусад улсад хэрхэн зохицуулсныг харвал, Казакстаны хувьд үнэлгээг буруу хийсэн бол үнэлгээчин дахин үнэлгээний төлбөрийг нөхөн төлнө.²⁹ Дахин үнэлгээний төлбөрийг дахин үнэлгээ хийлгэхээр хандсан тал төлөх буюу дахин үнэлгээ хийлгэж шийддэг бол ХБНГУ-д мөн адил үнэлгээг дахин хийлгэх боломжтой бөгөөд шүүхэд энэ талаарх гомдлыг гаргадаггүй.

Үнэлгээний гомдлыг шүүхэд гаргах зохицуулалт практикт төлбөр авагчийн эрх удаан хугацаанд сэргэхгүй байх сөрөг үр дагавар бий болгосон байна.

▪ **Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3.** Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах ажиллагааны үе шатуудад хамаарах зохицуулалт болон үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх зохицуулалт /60 дугаар зүйл, 63.1, 71.14, 68.1, 68.2, 22.1/ практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

ҮХЭХ албадан дуудлага худалдааны хүртээмж

²⁹ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021).

2022 онд 982.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа явуулах 863 гүйцэтгэх баримт бичиг байснаас анхны албадан дуудлага худалдаагаар 412.7 тэрбум төгрөгийн 612 хөрөнгийг худалдан борлуулахаар нийтэд мэдээлэхэд, 247.1 тэрбум төгрөгийн 165 хөрөнгийн дуудлага худалдаа түдгэлзэж, 12.1 тэрбум төгрөгийн 31 хөрөнгийн худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшлуулж, 8.9 тэрбум төгрөгийн 71 түдгэлзүүлж, хөрөнгийн дуудлага худалдаанд 71 оролцогч бүртгүүлэн 7.4 тэрбум төгрөгийн 59 үл хөдлөх эд хөрөнгө зарагдсан буюу нийт нийтэд зарласан албадан дуудлага худалдааны үл хөдлөх эд хөрөнгийн 1.8 хувь нь анхны албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдсон байна.³⁰

Харин хоёр дахь албадан дуудлага худалдаагаар 124.1 тэрбум төгрөгийн 369 хөрөнгийг худалдан борлуулахаар нийтэд мэдээлж, 47.2 тэрбум төгрөгийн 48 хөрөнгийн албадан дуудлага худалдаа түдгэлзэж, 16.4 тэрбум төгрөгийн 41 хөрөнгийн албадан дуудлага худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшлуулж, 14.8 тэрбум төгрөгийн 122 хөрөнгийн албадан дуудлага худалдаанд 122 оролцогч бүртгүүлэн 23.0 тэрбум төгрөгийн 119 хөрөнгө буюу нийт нийтэд зарласан хоёр дахь албадан дуудлага худалдааны үл хөдлөх эд хөрөнгийн 18.5 хувь нь худалдан борлогджээ.³¹

2022 онд зохион байгуулсан 980 үл хөдлөх эд хөрөнгийн анхны болон хоёр дахь дуудлага худалдааны 19.6 хувьд дэнчин тавьж, 193 оролцогч бүртгүүлсэн байна. Хөрөнгийн албадан дуудлага худалдаанд багадаа 2, ихдээ 28 оролцогч бүртгүүлж, оролцсон байх бөгөөд нэг хөрөнгийн дуудлага худалдаанд дунджаар 3-4 оролцогч бүртгүүлжээ.³²

Тухайлбал, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын фэйсбүүк хуудсаар зарлалыг хүргэдэг ба 2025 оны 2 сарын 6-нд оруулсан зар нэг лайктай³³ буюу нийтэд хүрэх байдал тааруу байна.

Ялагчид өмчлөх эрх шилжих зохицуулалт

ШШГТХ-ийн 71.14-т зааснаар “Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.” Үүний дагуу төлбөр төлөгч шүүхэд үндэслэлгүй гомдол гаргаж, ялагчид өмчлөх эрх шилжихийг удаашруулдаг.

2023 онд 1 их наяд 370 тэрбум төгрөгийн 738 үл хөдлөх эд хөрөнгийг нийтэд зарласнаас анхны дуудлага худалдаанд 64 оролцогч, хоёр дахь дуудлага худалдаанд 178 оролцогч бүртгүүлж, анхны дуудлага худалдаагаар 45, хоёр дахь дуудлага худалдаагаар 167 буюу нийт 74 орчим тэрбумын 212 үл хөдлөх эд хөрөнгө борлуулагдсан байна. Энэ нь нийт дуудлага худалдаанд орсон үл хөдлөх эд хөрөнгийн 28 орчим хувийг эзэлж байна.³⁴ Үүний бас нэг шалтгаан нь ялагчид өмчлөх эрх шилжих баталгаа байхгүй тул ҮХЭХ албадан дуудлага худалдаанд итгэх сонирхогчийн итгэл буурсан гэж хэлж болно.

³⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

³¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

³² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

³³ Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим хуудас 2025.03.08

³⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

Шигтгээ 1

Ялагч төлбөрийг төлсөн ч төлбөр төлөгчийн гомдлоор ажиллагааг дуусгавар болгосон тохиолдол

2021 оны 10 дугаар сард албадан дуудлага худалдаагаар ҮХЭХ-ийг худалдан борлуулж, ялагч тодорч, төлбөрийг шилжүүлсэн байхад 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлбөр төлөгч төлбөрийг бүрэн төлж, улмаар ялагч үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн авах боломжгүй болсон. Төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох тухай гомдлыг 2022 оны 06 сард иргэний хэргийн анхан шатны шүүхэд гарган мөн оны 11 сард шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангасан буюу “албадан дуудлага худалдаа хууль ёсны болсон ч гэсэн албадан дуудлага худалдаа болоод ялагч тодорч ялагч төлбөрийг бүрэн шилжүүлснээс хойш 2 сар орчмын дараа төлбөр төлөгч төлбөрөө төлсөн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь зүйтэй, ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгөө өмчлөх эрхгүй” гэж шүүх шийдвэрлэжээ.

Шигтгээ 2

2016 оны 4 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн. 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр иргэн 3 дуудлага худалдааны ялагчаар тодорсон. Төлбөр төлөгч үнэлгээг хүчингүй болгуулахаар 2017 оны 12 дугаар сард иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2019.09 сард УДШ хяналтын гомдлыг хуралдаанаар хэлэлцэхээс татгалзсан. Үндэслэл нь хуульд заасан үнэлгээний талаарх гомдол гаргах 7 хоногийг хэтрүүлсэн гэх боловч зөвхөн энэхүү шийдвэрийг гаргахын тулд 2 жил болж, ажиллагааг ийнхүү хугацаагаар түдгэлзэхэд хүргэжээ. 2022.05.24-нд төлөгч ШШГТХ-ийн 55.5-ын дагуу үнэлгээ хийгдсэнээс хойш 4 жил 5 сар өнгөрсөн тул ҮХЭХ-ийг дахин үнэлгээ тогтоолгохыг шийдвэр гүйцэтгэгчид даалгах, анхны албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж, 7 жил төлбөр авагч барьцаа хөрөнгөөс төлбөр гаргуулж чадахгүй, түдгэлзсэн, ялагч 2017 оны 11 сараас хойш өмчлөлийн хөрөнгөө авч чадахгүй 6 жил болж байна.

ШШГТХ-ийн 71.14-т “Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.” гэсэн зохицуулалт нь Иргэний хуулийн 178 дугаар зүйлийн 178.2-т “Дуудлага худалдаагаар худалдсан зүйлийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагч тухайн зүйлийн өмчлөгч болно.” гэж заасантай зөрчилдөж байх бөгөөд хэрэв өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд дуудлага худалдаагаар өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн өмчлөх эрхийг хязгаарлаж байна.

Битүүмжлэх, хураах 2 тусдаа ажиллагаа

ШШГТХ-ийн 49.1-д зааснаар “Хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах гэж тухайн хөрөнгийг захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагааг ойлгоно.” Үүний дараа төлбөр төлөгч гомдол шүүхэд гарган удаашруулна.

Шигтгээ 1

Ажиллагааг 2017 оны 4 сарын 17-нд эхлүүлж 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр битүүмжлээд битүүмжилсэн тогтоолд өмчлөгч гомдол гарган 2022 оны 6 сард эцэслэн шийдвэрлэгджээ. Ийнхүү 5 жил болоход 2023 онд хураах тогтоол гаргаж, ҮХЭХ-ийг хураасан байдалтай байгаа буюу төлбөр авагчийн эрх ашиг ноцтой зөрчигдөж, үндэслэлгүй гомдол өмчлөгч гарган ажиллагаа удааширчээ.

Эх сурвалж: 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр Дугаар 102ШШ202200313 /Хавсралт 2-оос дэлгэрэнгүй дүн шинжилгээг үзнэ үү./

ШШГТХ-ийн 54.1-д зааснаар “Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хөрөнгийг худалдан борлуулах, эсхүл гүйцэтгэх баримт бичигт заасан тохиолдолд төлбөр авагчид шилжүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авна.” Үүний дараа мөн хураах тогтоолд гомдол гаргаж, худалдан борлуулах ажиллагааг удаашруулдаг. /Хавсралт 2-оос дэлгэрэнгүй дүн шинжилгээнүүдийг үзнэ үү./

ҮХЭХ-ийг битүүмжлэх, дараа нь хураах тогтоол гаргах зохицуулалтаас шалтгаалан энэ хэмжээгээр удаашралыг бий болгожээ.

Барьцааны ҮХЭХ-ийг албадан борлуулах зохицуулалт

Монгол Улсын хувьд барьцаатай буюу ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах, эсхүл барьцаагүй ч төлбөр төлөгчийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах албадлагын ажиллагаа нь ижил байна. Өөрөөр хэлбэл, аль ч тохиолдолд битүүмжлээд, хураасны үндсэн дээр үнэлгээ тогтоолгон, үүний дараа албадан дуудлага худалдаанд оруулж байна.

Барьцааны ҮХЭХ-д шуурхай ялгаатай зохицуулалт үгүйгээс дараах сөрөг үр дагавар гарч байна.

Шигтгээ 1

Төлбөр авагч Х банкинд төлбөр төлөгч М ХХК, И ХК 1.8 их наяд төгрөгийн үүргийн гүйцэтгэлд **барьцаа хөрөнгийг** албадан худалдах гүйцэтгэх хуудастай хэрэгт 2019 оны 09 сард ажиллагаа үүсгэж, барьцаа хөрөнгийг 2 удаа үнэлүүлсэн. Үнэлгээ бүрд төлбөр төлөгч тус бүр шүүхэд гомдол гарган 2023 оны 3 сарын байдлаар нийт 4 жил ажиллагааг түдгэлзүүлсэн байдалтай байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн үнэлгээний гомдол төлбөр төлөгч гаргаж 4 жил ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдол

Шигтгээ 2

2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр¹ шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн 234.2 сая төгрөг гаргуулах гүйцэтгэх баримт бичигт **барьцаа хөрөнгийг** мөн оны 02 дугаар сард битүүмжилж, улмаар төлбөр төлбөр төлөгчөөс барьцаа хөрөнгийн үнэлгээ болон албадан дуудлага худалдаатай холбогдуулан удаа дараа шүүхэд гомдол гаргаж, энэ хугацаанд шүүгчийн захирамжаар 3 удаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн бөгөөд хамгийн сүүлд 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр¹ 7 жилийн дараа Улсын дээд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсний дараа төлбөр төлөгч төлбөрөө бүрэн барагдуулсан байна.

ҮХЭХ-ийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх

Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх зохицуулалтын тухайд практикт хэрэглэсэн тохиолдол байхгүй байна.

Тодруулбал, ШШГТХ-ийн 60.1-д “Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар төлбөр төлөгчийн хүсэлтэд заасан үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлж болно.” гэж тул төлбөр төлөгч үл хөдлөх хөрөнгөө төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх хүсэлт илгээх нь өөрөө практикт энэ зохицуулалт хэрэглэгдэхгүй байх шалтгаан болсон байна.

Дүгнэлт

Дараах дүгнэлтийг ҮХЭХ-д явуулах ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн талаар хийж байна. **Үүнд:**

- Дуудлага худалдааны зарыг шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд мэдүүлэх байдал сайнгүй байгаа нь дуудлага худалдааны талаар олж мэдэх хүмүүс бага байхад хүргэж байна;
- Ялагчид өмчлөх эрх төлбөр төлснөөр шилжихгүй, гомдол гаргаж удаашруулдаг тул дуудлага худалдаанд итгэх итгэлийг бууруулж, дуудлага худалдааны хүртээмжид сөргөөр нөлөөлж байна;
- Цахим дуудлага худалдааны зохицуулалт, дэд бүтэц байхгүй;
- Битүүмжлэх, дараа нь хураах тогтоол гаргадаг зохицуулалт удаашралыг тэр хэрээр үүсгэж байна;
- Барьцааны зүйл ҮХЭХ-д явуулах ялгаатай, шуурхай зохицуулалт байхгүй байна;
- ҮХЭХ-ийг төлбөр авагчийн хүсэлтээр бус төлбөр төлөгчийн хүсэлтээр шилжүүлэх зохицуулалттай тул төлбөр төлөгч уг хүсэлтийг гаргахгүй учраас энэ зохицуулалт практикт хэрэгжихгүй байна.

Бусад улсын туршлага

Битүүмжлэх

Seize гэх нэр томъёог хураах, битүүмжлэх гэсэн утгаар тайлбарласан байна.³⁵ Судалгаанд хамрагдсан улсуудын хуульд битүүмжлэх, хураах 2 үйлдэл хийхгүй байна.

ХБНГУ-ын хувьд, дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэр гаргахдаа үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх буюу битүүмжлэх, дуудлага худалдаа явуулах шийдвэрийг цугт нь гаргаж байна.³⁶

Цахим дуудлага худалдаа

Мөн дуудлага худалдааг цахимаар явуулах зохицуулалт хуульд байхгүй. Харин БНСУ, ХБНГУ, Казакстан улсын хувьд цахим дуудлага худалдааг хуульчилсан байна.

Барьцааны ҮХЭХ-д явуулах албадан ажиллагаа

Бусад улсын туршлагыг харвал, БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 264 дүгээр зүйлд заанаар ипотекийн зүйлийг албадан дуудлага худалдаанд оруулах хүсэлтийг шүүхэд гаргахдаа тухайн ҮХЭХ-д барьцааны эрхтэй талаарх эрхийг гэрчилсэн баримтыг мэдүүлнэ. Дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэрийг ҮХЭХ-ийн өмчлөгчид гаргаж барьцаатай ҮХЭХ-ийн хувьд битүүмжлэх асуудал байхгүйгээр шууд барьцаа болон шүүхийн энэ талаарх гүйцэтгэх хуудсыг үндэслэн үнэлгээ тогтоож, дуудлага худалдааг эхлүүлж байна.³⁷

Түүнчлэн ХБНГУ-ын иргэний процессын хуулийн 867 дугаар зүйлийн 3-т “Баталгаат ипотекийг албадан дуудлага худалдаагаар дамжуулан шаардлагыг хангахад бүртгэлд бүртгүүлсэн тухай тэмдэглэл бүхий шийдвэр гүйцэтгэлийн баримт бичиг хангалттай.” гэж заасан. Мөн адил барьцаатай бол барьцааг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шууд худалдан борлуулах боломжийг олгосон буюу барьцаагүй тохиолдолд ҮХЭХ-ийг битүүмжилж, албадан дуудлага худалдаа явуулдагаас шуурхай ажиллагаа явуулдаг байна.³⁸

Гүрж улсын хувьд, Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2n-д зааснаар барьцаалсан талаарх гэрчилгээ нь шууд шийдвэр гүйцэтгэх үндэслэл болж байна.³⁹

Энэ нь барьцаалагчийн эрхийг шуурхай хангах, гэрээндээ үл маргах журмаар барьцааг үүргийн гүйцэтгэлд гаргуулахаар тохиролцсон талуудын гэрээнд итгэх итгэлийг хангах зарчмыг хангах үр дүнтэй арга хэрэгсэл болж байна.

Ялагчид өмчлөх эрх шилжих

БНСУ-ын хуульд зааснаар ҮХЭХ-ийг худалдсаны төлбөрийг бүрэн төлөхөөс өмнө дуудлага худалдаа эхлүүлэх шийдвэрт шүүхэд эсэргүүцэл гаргаж болно. /Даруй шуурхай шийддэг/ Мөн эсэргүүцлийг шийдвэрлэсэн шийдвэрт нэн даруй гомдол гаргаж болно. Төлбөр төлөгдөхөөс өмнө энэ талаарх гомдол гаргах, үүнээс хойш гомдол гаргахгүй бөгөөд төлбөр төлснөөр өмчлөх эрхийн бүртгэлд өмчлөгчөөр

³⁵ С.Нарангэрэл – Хууль зүйн Англи-Монгол эх толь 2012 он, 489 дүгээр тал.

³⁶ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

³⁷ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

³⁸ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

³⁹ <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

бүртгүүлэхээр БНСУ, Герман улсын хуульд,⁴⁰ харин Казакстаны хувьд төлбөрийг төлснөөр худалдах худалдан авах гэрээ ялагчтай байгуулах ба уг гэрээ нь өмчлөгчөөр бүртгүүлэх үндэслэл болохоор байна.⁴¹

Төлбөр авагчийн удирдлагад ҮХЭХ-ийг шилжүүлэх

Бусад улсын туршлагаас харахад, БНСУ-ын хувьд, төлбөр авагчийн хүсэлтээр ҮХЭХ-ийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх, эсхүл албадан дуудлага худалдаагаар борлуулах аргын аль нэгийг сонгож, албадан гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлдэг байна.⁴²

▪ **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4.**Төлбөртэй этгээдийн бүртгэл ба эд хөрөнгийн мэдүүлгийн талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Төлөгчийн хөрөнгийн мэдүүлэг

ШШГТХ-ийн 44.2.3-т зааснаар төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх нь шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний нэг төрөл юм.

Гэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болох⁴³ буюу төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэхэд хүртэл гомдол гаргаж болохоор байна. Уг гомдлыг цаашлаад шүүхэд ч гаргаж болно.⁴⁴

Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр төлөгчөөс түүний хөрөнгийн тухай бичгээр мэдүүлэг авах бөгөөд мэдүүлэг гаргахын өмнө мэдүүлгийг худал гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.⁴⁵

Төлбөр төлөгч хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.⁴⁶ Төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн байдалд орсон өөрчлөлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, өөрчлөлтийг хөрөнгийн мэдүүлэгт тусгана.⁴⁷

Төлөгч хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс зайлсхийсний үр дагавар

Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч

⁴⁰ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

⁴¹ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

⁴² https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

⁴³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44.3 дахь хэсэг.

⁴⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44.4 дэх хэсэг.

⁴⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.1 дэх хэсэг.

⁴⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.3 дахь хэсэг.

⁴⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.4 дэх хэсэг.

хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд түүний хөрөнгийг эрэн сурвалжилна.⁴⁸ Ингэхдээ төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч бүрэн эрхийнхээ хүрээнд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхдээ ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авдаг.⁴⁹

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлалыг ХЗДХС-ын 2017 оны А/218 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан байх бөгөөд ажиллагааг эхлүүлэхдээ даалгасан шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хувийн хэрэг нээх, хамаарал бүхий этгээдийн оршин суугаа хаяг, тэдгээртэй харилцаа үүсгэж байгаа эсэхийг шалгах, цагдаагийн байгууллагаас туслалцаа авах, төлбөртэй мэдээлэл авах, олон нийтийн хэрэгслээр зарлана. Мөн эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олсон бол албадан ирүүлж, батлан даалт 2-оос дээш хүнээс гаргуулж авна.⁵⁰

Өөрөөр хэлбэл, хөрөнгийн мэдүүлэг гаргах нь заавал албадлагын биш зохицуулсан буюу мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч эрэн сурвалжилж төлбөр төлөгчийн араас хөөцөлдөх зохицуулалт болжээ.

Эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгчийн талаарх гүйцэтгэлийг харуулбал:

Он	Оны үлдэгдэл	Шинээр нэмсэн	Олж тогтоосон	Үлдэгдэл
2017	400	471	490	381
2018	381	739	614	506
2019	506	761	719	548
2020	548	1348	1102	794
2021	794	614	804	604
2022	604	1495	1181	918
2023	918	2498	2427	989
2024	989	1332	1372	349
2025	949	150	226	873

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025 оны 3 дугаар сар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁵¹

Эрүүгийн хууль дагаж мөрдсөн 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хойш буюу 7 жил орчмын хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх гэмт хэрэгт 11 тохиолдолд шүүх хуралдаан хийж, гэм бурууг шийдвэрлэсэн байна.⁵² Үүнээс нийслэл 7, орон нутагт 4

⁴⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.5 дахь хэсэг.

⁴⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 57.4 дэх хэсэг.

⁵⁰ ХЗДХС-ын 2017 оны А/218 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

⁵¹ Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл

⁵² <https://shuukh.mn/cases/2/1>

шүүхийн шийдвэр хамаарч байна. Үүнээс 2 хэрэгт 6 сарын хугацаагаар хорих шийдвэр гаргасан байна. Гэхдээ эдгээр тохиолдлуудад хөрөнгийн мэдүүлгээ буруу гаргасан, зайлсхийсэн гэх үйлдлийг шийтгэсэн тохиолдол байхгүй буюу хөрөнгийн мэдүүлэг гаргахгүй байсан ч хариуцлагын механизм ажилдаггүй болно.

2025 оны байдлаар гэхэд хөрөнгийн мэдүүлгийг авч чадаагүй эрэн сурвалжилж байгаа 873 тохиолдол байна.

Мөн эд хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй байхад төлбөр төлөгчийн бүртгэлд бүртгэдэг байх хөшүүрэг байхгүй.

Төлбөртэй этгээдийн бүртгэл

Төлбөртэй этгээдийн бүртгэл нь хаалттай мэдээлэл байна. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.⁵³

Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, тодорхойлолт, лавлагаа гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.⁵⁴ Тус журмыг ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаалаар баталсан бөгөөд тус журамд зааснаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдэд олгож болохоор заасан. Ийнхүү тодорхойлолт, лавлагаа авахад төлбөртэй байхаар заажээ. Төлбөртэй бол лавлагаа, төлбөргүй бол тодорхойлолт гаргана. Гэхдээ энэхүү сангаас иргэн, хуулийн этгээдэд бусад этгээдийн талаарх мэдээлэл өгөхийг хориглосон.⁵⁵

Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэсний үр дагавар

Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн ч хязгаарлалт, төлбөрийг төлүүлэхэд хүргэх хөшүүрэг үр дагаваргүй.

Бусад улсын туршлага

Төлөгчийн хөрөнгийн мэдүүлэг

БНСУ-ын хувьд, төлбөр авагчийн хүсэлтээр шүүх төлбөртэй этгээдийг өөрийн эд хөрөнгийн байдлыг тодорхойлсон эд хөрөнгийн жагсаалт ирүүлэхийг шаардана. Өр төлбөртэй этгээдийн хөрөнгийг хялбар илрүүлэх боломжтой бол шүүх хүсэлтээс татгалзана. Ингэхдээ төлбөртэй этгээдийн тайлбарыг авахгүй. Хөрөнгийн жагсаалт гаргах шийдвэрийг биелүүлэхгүй бол 20 хүртэл хоногоор баривчлах шийтгэл оногдуулна. Хуулийн этгээд бол төлөөлөгч, удирдлага нь баривчлагдана.⁵⁶ Харин худал мэдүүлсэн бол 5 сая хүртэл вонноор торгох, эсхүл 3 жил хүртэлх хугацаагаар хорих ялтай.

⁵³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.1 дэх хэсэг.

⁵⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.2 дахь хэсэг.

⁵⁵ ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаал

⁵⁶ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

Түүнчлэн төлбөртэй этгээд албадан ажиллагаа хийгдэх эд хөрөнгө болон дараах асуудлыг тусгасан хөрөнгийн жагсаалтыг гаргана.

- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн төлбөртэйгөөр бусдад шилжүүлсэн үл хөдлөх эд хөрөнгө
- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн үл хөдлөх эд хөрөнгөөс бусад төлбөртэйгөөр өөрийн эхнэр, нөхөр, цусан төрлийн хамаатан садан, өөр эцэг, эхийн ах, эгч, дүүдээ шилжүүлсэн хөрөнгө
- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө хоёр жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн бусдад шилжүүлсэн хандив, тусламж
- Дээд шүүх хөрөнгийн жагсаалтад тусгах зүйл, хамрах хүрээг журмаар тогтооно.⁵⁷

6 сарын хугацаанд төлөөгүй бол төлбөртэй этгээдийн жагсаалтад оруулахаар шийднэ. Засаг захиргаа, банк ББСБ буюу зээлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад мэдэгдэнэ.⁵⁸

ХБНГУ-ын хувьд төлбөр төлөгч нь өөрийн санхүүгийн нөхцөл байдал, өмчилж байгаа хөрөнгийн талаарх мэдээллээр хангах үүрэгтэй.

Дараах мэдээллийг оруулна:

- Төлбөр төлөгчийн энэ хуулийн 802e-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс хоёр жилээс доошгүй хугацааны өмнө ойр дотны хүндээ төлбөртэй шилжүүлсэн эд хөрөнгө (Дампуурлын тухай хуулийн 138-р зүйл);
- Төлбөр төлөгч энэ хуулийн 802e-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс дөрвөн жилээс доошгүй хугацааны өмнө бусдад шилжүүлсэн бөгөөд ёс заншлын дагуу бэлэглэсэн, ялимгүй өртөг бүхий зүйлсээс бусад эд хөрөнгө.

Түүнчлэн ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 882f-д зааснаар төлбөр төлөгчтэй дараа дараад гэрээ байгуулах гэсэн ямар ч этгээд эдийн засгийн сөрөг үр дагавар гарахаас сэргийлж, гэрээ байгуулах эсэхээ шийдэхийн тулд энэхүү төлбөртэй этгээдийн бүртгэлээс мэдээлэл авч болдог байна.⁵⁹

Гүрж улсын хувьд, Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн 19^j-д зааснаар? төлбөртэй этгээдийн бүртгэлийг мөнгөн хөрөнгө гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эхэлмэгц заавал хийнэ.⁶⁰

Хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй, худал өгсөн бол үүсэх үр дагавар

⁵⁷ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

⁵⁸ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8

⁵⁹ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

⁶⁰ <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

ХБНГУ-ын Иргэний процессын хуульд зааснаар эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах үед төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацааг хожимдуулсан, эсхүл мэдүүлэг өгөх үүргээ зөрчсөн бол эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахад төлбөр төлөгчдийн бүртгэлд бүртгэлд бүртгэгдэх үр дагавартай байна.⁶¹

Түүнчлэн хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс баривчлах тушаал гаргана. Баривчлах тушаалд төлбөр авагч ба төлбөр төлөгчийг түүнчлэн баривчлах үндэслэлийг заана. Баривчлах тушаалыг биелүүлэхээс өмнө зайлшгүй хүргүүлэх шаардлагагүй.⁶²

Хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, эсхүл буруу өгсөн, эсхүл төлбөр төлөх хөрөнгөгүй, хүрэлцэхгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулдаг. Тус бүртгэлд орсноор банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, бусад бизнес хамтрах боломж хязгаарлагдахын зэрэгцээ тухайн төлбөр төлөгчийн үндсэн үйл ажиллагааг хязгаарладаг. Тухайлбал, төлбөр төлөгч хуульч бол хуульчаар ажиллах зөвшөөрлийг түдгэлзүүлдэг. Мөн төлбөртэй этгээдийн бүртгэл нь нийтэд нээлттэй байдаг тул төлбөр төлөгчид даруй төлбөрөө төлж, бүртгэлээс гарах гэж хичээх хөшүүрэг нь болдог.⁶³

Гүрж улсын хувьд, төлбөртэй этгээдийн бүртгэл нь банк, ББСБ, төрийн байгууллагуудад нээлттэй бөгөөд сонирхогч этгээдэд төлбөртэйгээр нээлттэй байна.⁶⁴

Гүрж улсын хувьд, мөн энэхүү бүртгэлд бүртгэгдсэнээр аливаа бүртгэлтэй ҮХЭХ, хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхэд нь хязгаарлалт тогтоох үр дагавартай байдаг.⁶⁵

Дүгнэлт

Дараах дүгнэлтийг өөрийн улсын зохицуулалт, түүний хэрэгжилт, гадаад улсын туршлагад үндэслэн хийж байна. **Үүнд:**

- Ажиллагаа эхэлмэгц хөрөнгийн мэдүүлэг заавал албадан авах зохицуулалт бусад улсад байгаа нь төлбөр төлөгчийг хариуцлагажуулах, төлбөр төлөгчийн араас эрэн сурвалжилж, хугацаа алдахаас сэргийлж байна
- Хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол манай улсад шийдвэр гүйцэтгэгч эрэн сурвалжлах зохицуулалттай бол бусад улсад баривчлах, бүртгэлтэй этгээдийн бүртгэлд бүртгэх зэрэг үр дагавартай байна
- Хөрөнгийн мэдүүлэг, төлбөртэй этгээдийн бүртгэлийн уялдаа манай улсад байхгүй

⁶¹ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

⁶² https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

⁶³ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

⁶⁴ <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

⁶⁵ <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

- Төлбөртэй этгээдийн бүртгэлд тодорхой хэмжээнд, эсхүл нээлттэй мэдээлэл байх практик бусад улсад байгаа ч манай улсад төлбөртэй этгээд зөвхөн өөрөө л лавлагаа авдаг хаалттай мэдээлэл
- Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэсний үр дагавар төлбөр төлөгчид байхгүй ч бусад улсад захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох, зарим төрийн үйлчилгээ авах эрхэд хязгаарлалт тогтоох зэрэг үр дагавартай байгаа нь төлбөр төлөгч төлбөрөө төлөх хөшүүрэг болсон байна.
- **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 5.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зөрчил, эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэхтэй холбоотой зохицуулалтууд буюу төлбөр төлөгчийн хариуцлага болон эрүү, зөрчлийн хууль дахь хариуцлагын талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах зөрчил

- Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах /ЗтХ-ийн 15.2 дугаар зүйл/;
- Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх/ЗтХ-ийн 15.27 дугаар зүйл/;
- Хүүхдийн эрхийг зөрчих /ЗтХ-ийн 6.20 дугаар зүйл/ зөрчил.

Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2-т заасан Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан, төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл бүхий зөрчлийн хэргээр 2022 онд 60 хүн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор шалгасан дараах тохиолдол байна. **Үүнд:**

2023 онд 16 хүнд, 2024 онд 28 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан бол мөн хуулийн 15.27 дугаар зүйлд заасан Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх зөрчлийн хэргээр 2022 онд 14 хүн шалгаснаас 4, 2023 онд 8 хүнд, 2024 онд 5 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан байна.⁶⁶ /Хавсралт 1-ийн статистик 9-өөс дэлгэрэнгүйг үзнэ үү./

Гэтэл биелэгдээгүй иргэний шийдвэр гүйцэтгэл их буюу 2024 онд гэхэд 26619 төлбөр төлөгч төлбөрөө төлөөгүй байна. /Хавсралт 1-ийн статистик 3-аас дэлгэрэнгүйг үзнэ үү./

Харин Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6-д заасан Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах зөрчлийн хэргээр дараах шийтгэсэн тохиолдол байна. **Үүнд:**

2022 онд 18 хүнд торгох, 36 хүн баривчлах, 2023 онд 14 хүнд торгох, 24 хүн баривчлах, 2024 онд 24 хүнд торгох, 34 хүн баривчлах шийтгэлийг тус тус ногдуулсан. /Хавсралт 1-ийн статистик 9-өөс дэлгэрэнгүйг үзнэ үү./

⁶⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл.

Гэтэл хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны сүүлийн 5 жилийн биелэлтийн дундажлан авч үзэхэд гүйцэтгэх хуудасны тоогоор 10.3 хувь, мөнгөн дүнгээр 43.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь энэ төрлийн гүйцэтгэх ажиллагаа төдийлөн хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа ч ердөө жилд 50 орчим төлөгч зөрчлийн шийтгэл ногдуулж байгаа нь хангалтгүй, хуулийн хариуцлагын зохицуулалт хэрэгжихгүй оновчгүй байгааг илтгэж байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны биелэлт (2020-2024 он)

ҮЗҮҮЛЭЛТ		Оны эхний үлдэгдэл	Шинээр	Төлбөр			
				Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Хувь
2020 он	гүйцэтгэх хуудас	19808	2310	13097	2044	11053	15.6
	мөнгөн дүн /мян/	1,605,346,793.7	25,397,140.6	51,296,952.1	24,274,228.9	27,022,723.2	47.3
2021 он	гүйцэтгэх хуудас	19019	1644	12724	1444	11280	11.3
	мөнгөн дүн /мян/	1,315,863,593.9	43,409,242.5	70,406,769.3	36,428,354.7	33,978,414.6	51.7
2022 он	гүйцэтгэх хуудас	16628	2184	13416	1170	20325	8.7
	мөнгөн дүн /мян/	1,450,604,118.1	13,803,982.8	46,363,522.3	18,026,381.8	1,855,107,380.6	38.9
2023 он	гүйцэтгэх хуудас	20325	2090	14182	1038	22121	7.3
	мөнгөн дүн /мян/	1,855,107,380.6	25,847,674.0	50,566,295.7	20,693,635.3	2,374,780,552.7	40.9
2024 он	гүйцэтгэх хуудас	22121	2140	15435	1327	14108	8.6
	мөнгөн дүн /мян/	2,374,780,552.7	17,511,343.1	48,596,184.7	18,308,909.4	30,287,275.3	37.7

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах Эрүүгийн хариуцлага

Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Статистик мэдээллээс үзэхэд 2022 онд 48, 2023 онд 90, 2024 онд 61 хэрэг шалгасан боловч, дийлэнх тохиолдолд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд прокуророос хэрэг үүсгэхээс татгалзсан байна.⁶⁷ /Хавсралт 1-ийн статистик 9-өөс дэлгэрэнгүйг үзнэ үү./

⁶⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл.

Түүнчлэн шүүхээс 2022 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон 1⁶⁸, 2024 онд 2⁶⁹ тохиолдолд байна.



⁶⁸ https://shuukh.mn/single_case/81099?daterange=2022-01-01%20-%202024-12-31&id=1&court_cat=2&bb=1


⁶⁹ https://shuukh.mn/single_case/105064?daterange=2022-01-01%20-%202024-12-31&id=1&court_cat=2&bb=1

https://shuukh.mn/single_case/112870?daterange=2022-01-01%20-%202024-12-31&id=1&court_cat=2&bb=1

2023 ОН/НИЙТ 90 ХЭРЭГ/



2024 ОН/НИЙТ 61 ХЭРЭГ/



Хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хэрэгжилт тааруу байхад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт тааруу, төлбөр төлөгчид төлөхгүй ч хариуцлага хүлээдэггүйг илтгэх дараах статистик байна. **Үүнд:**

ШШГЕГ-ын статистик мэдээллээс үзэхэд иргэний шийдвэр гүйцэтгэлийн биелэлт 2024 оны хувьд биелүүлбэл зохих 56920 гүйцэтгэх хуудаснаас 26619 гүйцэтгэх хуудас биелэгдээгүй бөгөөд мөнгөн дүнгийн хувьд 3 их наяд 486 тэрбум 12 сая 933 мянган төгрөгийг биелүүлэхээс 2 их наяд 383 тэрбум 137 сая 592 мянган төгрөгийг биелүүлээгүй буюу мөнгөн дүнгийн биелэлтийн хувь 31.6 хувьтай байна.⁷⁰

⁷⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024 оны 12 дугаар сарын байдлаар.

Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 639 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 167 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 50 гүйцэтгэх хуудсанд хамаарах 45 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 7.2 хувь буюу 593 тэрбум орчим төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.

Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 19 гүйцэтгэх хуудсанд хамаарах 120 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 80 орчим хувь буюу 478 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.

Бусад улсын туршлага

БНСУ, ХНБГУ, Гүржийн туршлагаас харахад, шийдвэр гүйцэтгэлийн шүүх эдгээр торгох, баривчлах хөшүүргийг хэрэглэх эрх нь байна.

Тухайлбал, ХБНГУ-ын хуулийн 802g-д зааснаар шийдвэр гүйцэтгэлийн шүүх баривчлах /coercive detention/ шийдвэр гаргана.⁷¹

Гүрж улсын хуулийн 14¹⁴⁻¹⁸-д зааснаар шийдвэр гүйцэтгэлийн цагдаа /enforcement police officer/ ажиллах бөгөөд дүрэмт хувцас өмсөж, ID card-тай, даатгалд хамрагдсан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн цагдаагаар гүйцэтгүүлэх ажлын хүсэлтийг гаргах, хувийн шийдвэр гүйцэтгэгч мөн хүсэлт гаргах гэхдээ төлбөр төлдөг байна.⁷²

Дүгнэлт

Манай улсын хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь Зөрчлийн тухай, Эрүүгийн хуульд тусгагдсан тул шийдвэр гүйцэтгэгч хэрэг үүсгэх саналыг цагдаагийн байгууллагад, үүний дараа прокурор хэрэг үүсгэх эсэхийг шийдэж, шүүхэд шилжүүлж, эрүүгийн шүүх шийдвэрлэдэг тул албадлагын үе шатны хариуцлагыг шуурхай хүлээлгэх зохицуулалт бүрдээгүй байна.

Бусад улсад Эрүү, зөрчлийн хуулиар цагдаа, прокуророр дамжилгүй шүүх өөрөө баривчлах, торгох зэрэг хариуцлагыг шууд хүлээлгэх боломжтой байгаа нь төлбөр төлөгчийг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулахаас сэргийлэх ач холбогдолтой байна.

- **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6.** Шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс ба урамшуулалтай болон урамшуулалгүй үеийн зохицуулалт

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид

⁷¹ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

⁷² <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

2025 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба буюу иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх албанд нийт 460 алба хаагч ажилладаг бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч 56, шийдвэр гүйцэтгэгч 244, захиргаа, мэргэжлийн удирдлага 26, санхүү үйлчилгээ 42, тоо бүртгэл, лавлагаа мэдээлэл 17, харуул, хамгаалалт 6, эрэн сурвалжлах 9 албан хаагч ажиллаж байна.

2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 244 шийдвэр гүйцэтгэгч байсан. 118 нь нийслэлд, 126 нь орон нутагт байдаг. Ахлах шийдвэр гүйцэтгэгч 47 байна. /1 ахлах зөрчил шалгадаг,/ нийслэлд 18 ахлах, үүний 5 нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид ирсэн гомдол, хүсэлтийг хянадаг байсан байна.

Улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/23 тоот тушаалын хавсралтаар батлагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тооны дагуу 304 шийдвэр гүйцэтгэгчтэй байхаар буюу 2021 оноос хойш 244⁷³ байснаас 60-аар нэмэгджээ.⁷⁴

Шийдвэр гүйцэтгэгчийн цалин

Цалин хөлсний тухайд Дэслэгч цолтой шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлсийг тооцож үзвэл гарт олгох цалин 2,318,892 төгрөг байна.

Үндсэн цалин	Нэмэгдэл	Эрүүл мэндийн даатгал	Татвар
ТТ-7 ⁷⁵	1. Цол /Дэслэгч/- 26% 2. ХАН- 10% 3. ОНН- 25% 4. ТТАХН- 0% <i>Нийт 61%</i>	2%	10%
1,633,000 төг	996,130 төг	52,582.6 төг	257,654.7 төг

Гарт олгох : 2,318,892.7 төг

Цаашид шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах бодлоготой уялдуулан судлаачын зүгээс эдгээр албан хаагчдын цалин хөлс хэрхэн өөрчлөгдөх талаар тооцоолох шаардлагатай гэж үзэн дараах байдлаар тооцлоо.

Үндсэн цалин	Нэмэгдэл	Эрүүл мэндийн даатгал+Нийгмийн даатгал	Татвар
	1. зэрэг дэвийн нэмэгдэл /дэс түшмэл/- 18% 2. ТАН- 3% <i>Нийт 21%</i>	11.5 %	10%

⁷³ ХЗДХС-ын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тоо тогтоох тухай 2021 оны А/293 тоот тушаал.

⁷⁴ ХЗДХС-ын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тоо тогтоох тухай 2025 оны А/23 тоот тушаал.

⁷⁵ ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”

T3-6 ⁷⁶			
1,693,000 төг	355,530 төг	235,580 төг	181,294 төг

Гарт олгох : 1,631,656 төг

Дээрх тооцооллоос үзэхэд шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргаж, төрийн захиргааны албан хаагчийн ангилалд хамруулснаар шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс 30 орчим хувиар буурахаар байна.

Шигтгээ

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах тохиолдолд алба хаагчдын тэтгэвэр, тэтгэвэр тэтгэмжийн асуудал хөндөгдөх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авсан мэдээллээс үзэхэд ирэх 5 жилийн хугацаанд 48 албан хаагчийн тэтгэврийн эрх үүсэхээр байна.

Иймд цаашид шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах эсэх, ангилал зэрэглэлийг хэрхэн тогтоох зэргийг харгалзан эдгээр алба хаагчдын эрх зүйн байдлын талаар Хууль тогтоомжий тухай хуульд заасан холбогдох бусад судалгааг гүйцэтгэх замаар судлах нь зүйтэй.

Урамшуулал

1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 2002 он хүртэл дагаж мөрдөж байсан ба энэ үед шийдвэр гүйцэтгэгч урамшуулал авдаггүй байсан байна.⁷⁷ Харин 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгч цалингаас гадна урамшуулал авдаг байсан байжээ.⁷⁸ Энэхүү зохицуулалт 2017 оны буюу одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдах хүртэл хэрэгжсэн.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэлх хувиар урамшуулна.” гэж, мөн зүйлийн 83.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчилэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна.” гэж, хуулийн 83.3 дахь хэсэгт зааснаар олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор заажээ.

⁷⁶ ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”

⁷⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=7165>

⁷⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=89>

ХЗДХС-ын 2002 оны 208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмын⁷⁹ 2.1-д зааснаар биелүүлсэн шүүхийн шийдвэрийн хувьд мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс 5-10 хувийн урамшууллыг суутгаж, аймаг, нийслэлийн ШГА-ны дансанд төвлөрүүлнэ. 3-т зааснаар урамшууллыг шийдвэр гүйцэтгэгчид, болзошгүй эрсдлийн санд, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бусад зардалд хуваарилдаг. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэгчид хуваарилах урамшууллын хэмжээ нь 1 сая хүртэлх төгрөгийн шийдвэрийн хувьд 5.5 хувь, 1-5 сая бол 4 хувь, 5-10 сая бол 3 хувь, 10-25 сая бол 2.5 хувь, 25-50 сая бол 2 хувь, 50-75 сая 1.5 хувь, 75-100 сая төгрөгийн 1 хувь, 100 саяас дээш бол 0.5 хувь байхаар заасан байна.

1-5 сая төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудас биелүүлэхэд 200 мянган төгрөг, 75 сая төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудас биелүүлэхэд 1,875,000 төгрөгийн урамшууллыг шийдвэр гүйцэтгэгчид олгохоор байсан байна.

Түүнчлэн дээрх Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмыг ХЗДХС-ын 2010 оны 104 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар шинэчлэн тогтоосон байна.⁸⁰

Урамшуулалтай байсан 2002-2016 оны хоорондын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл 4,7 тэрбум орчим мөнгөн дүн бүхий 413916 гүйцэтгэх хуудаст хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 1,6 тэрбум мөнгөн дүн бүхий гүйцэтгэх ажиллагаа биелэгдсэн байх бөгөөд энэ нь нийт гүйцэтэвэл зохих гүйцэтгэх хуудасны 53 хувь, мөнгөн дүнгийн 35 хувийг эзэлж байна.

Харин Урамшуулалгүй үеийн /2017-2024/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн үзүүлэлт дундажаар 52.5 хувь, мөнгөн дүн 26.3 хувьтай ажилласан байна. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүнээс хамаарсан ялгамжтай урамшуулалгүй болсноор гүйцэтгэх баримт бичиг бага үнийн дүнтэй эсэхээс үл хамааран гүйцэтгэх баримт бичгийн биелэлт өндөр, мөнгөн дүнгийн биелэлт буурсан байна.

Өөр нэг ажиглагдаж буй чухал давтамж бол урамшуулалгүй үеийн 2017-2024 оны шийдвэрийн биелэлтийг үзэхэд, бүх онуудад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт мөнгөн дүнгийн биелэлтээс илүү байсан байна.

2015 онд буюу ШШГТХ 2017 батлагдахаас өмнө гүйцэтгэх хуудасны биелэлт 46.3 хувь, 2022 онд 54.6 хувь болж өссөн ч энд бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн өсөлтийн хувь 9.2 байсан, 5 саяас дээш гүйцэтгэх хуудаст явуулсан ажиллагааны биелэлт 3.3 хувиар өссөн. Шийдвэр гүйцэтгэгч урамшуулалтай байсан 2017 оноос өмнөх үед өндөр үнийн дүнтэй буюу урамшуулал ахиухан авах гүйцэтгэх баримт бичигт хийх ажиллагаа түлхүү явагдаж, бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн биелэлт сул, харин 2017 оноос хойш урамшуулалгүй тул бага үнийн дүнтэй хялбар гүйцэтгэж болох гүйцэтгэх баримт бичгийн биелэлт нь нэмэгджээ.⁸¹

⁷⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203760>

⁸⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205350>

⁸¹ Я.Батгэрэл, Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал, хэрэгцээ шаардлага, ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

Мөн урамшууллын хувь хэмжээг зохистой тогтоохгүй бол төлбөр төлөгч, төлбөр авагчийн хувьд санхүүгийн дарамт болох, улмаар шүүхийн шийдвэрийн биелэлтэд сөргөөр нөлөөлөх, гагцхүү том үнийн дүнтэй хэргүүд дээр ажиллагаа төвлөрөх зэрэг сөрөг үзэгдлүүд түгээмэл ажиглагддаг.⁸²

Зардал

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын тухайд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд дараах зардал иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд хамаарч байна:

- төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулахад зарцуулсан зардал;
- төлбөр төлөгч, түүний нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж илрүүлэхэд зарцуулсан зардал;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон журмын дагуу оролцсон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас бусад оролцогч нарын ажлын хөлс;
- илгээмж, шуудан, холбоо, хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхтэй холбогдон гарсан зардал;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гүйцэтгэсэн бусад ажиллагааны зардал.

Мөн “Журам батлах тухай” ХЗДХС, СС-ын 2018 оны А/107, 132 тоот хамтарсан тушаалын 2-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэгт заасан зардлыг дараах байдлаар тооцохоор заасан.

- битүүмжлэх, барьцаалах, хураах, шилжүүлэх, худалдан борлуулах, гэрч оролцуулах зардлыг төрийн эрх бүхий байгууллагаас зарласан дундаж цалингийн /ҮСХ-оос тухай бүр зарласан дундаж цалингаас тооцох/ 1 цагийн ажлын хөлсийг тухайн ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулсан ажлын цагаар тооцох;
- хөрөнгө хадгалах, тээвэрлэх, илгээмж, шуудан холбоо, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон журмын дагуу оролцсон оролцогчийн ажлын хөлс, гүйцэтгэлийн хувийн хэргээс баримт, бичиг хуулбарлах зардлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон уйлчилгээний хөлсний хэмжээгээр тооцох;
- эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг тухайн ажиллагааг гүйцэтгэсэн бодит зардлын хэмжээгээр тооцох;
- эдийн бус шаардлага, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг даалгасан, үнийн дүн тодорхойгүй гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх зардал нь ХХ доод хэмжээнээс хэтрэхгүй байна.
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн тойргийн нутаг дэвсгэрээс өөр алслагдсан нутаг дэвсгэрт явуулах бол гарах зардлыг улсын төсвийн

⁸² 3.Шагдарсүрэн, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо, олон улсын туршлага, ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

байгууллагад мөрдөгдөж буй томилолтын зардлын хэмжээгээр тооцон гаргуулна.

- ҮХЭХ худалдан борлуулах хөлс нь тухайн хөрөнгийн үнийн дунгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

Төлбөрийн үнийн дүн /төгрөгөөр/	Зардлын хувь, хэмжээ /төгрөгөөр/	
0-100.000 төг	5.000 төг	5000
100 001-500.000	5.000 төг дээр 100.000 төгрөгөөс давсан дүнгийн 5 хувийг нэмнэ.	21000
500.001-1.000.000	25.000 төг дээр 500.000 төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг нэмнэ.	35000
1.000.000-5.000.000	45.000 төгрөг дээр 1.000.000 төгрөгөөс давсан дүнгийн 1 хувийг нэмнэ.	85000
5.000.000-10.000.000	85.000 төг дээр 5.000.000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.	110000
10.000.000-50.000.000	110.000 төг дээр 10.000.000 төгрөгөөс давсан дүнгийн 0.1 хувийг нэмнэ.	150000
50.000,001- дээш	150.000 төг дээр 50.000.000 төгрөгөөс давсан дүнгийн 0.05 хувийг нэмнэ.	200000 – 100 саяын төлбөрийн дүнтэй бол

Зардлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон дундаж цалингийн 1 цагийн ажлын хөлсийг тухайн ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулсан цагаар тооцохоор журамласан тул Үндэсний статистикийн хорооноос тухай бүр зарласан дундаж цалингийн хэмжээгээр тооцохыг анхаарах талаар заасан.⁸³

Бусад улсын туршлага

Зардал ба түүнээс бодох шийдвэр гүйцэтгэгчийн бонус

ХБНГУ-ын хувьд гэхэд, шийдвэр гүйцэтгэгч нь төрийн албан хаагчийн үндсэн цалингаас гадна төлбөр авагчийн урьдчилан төлсөн ажиллагааны зардлын 15 хувийг бонус болгон авдаг.⁸⁴ Ажиллагаа бүр энэхүү бонусыг шингээсэн хэмжээнд тогтоосон зардалтай байдаг.

Түүнчлэн Гүрж улсын хувьд мөн адил шийдвэр гүйцэтгэгч ажиллагааны зардлаас 15 хувийг бонус байдлаар авдаг, хувийн шийдвэр гүйцэтгэгч зардлыг бүтэн авч, үйл ажиллагаандаа зарцуулдаг байна.⁸⁵

Шийдвэр гүйцэтгэгч ба бусад ажилтан

⁸³ ХЗДХС, СС-ын 2025 оны А/34 А/24 хамтарсан тушаалаар нэмсэн.

⁸⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

⁸⁵ Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

Гүржид нийт 424 албан хаагч байх ба үүний 158 нь шийдвэр гүйцэтгэгч, захиргаанд 157, шийдвэр гүйцэтгэлийн цагдаа 57 байна.⁸⁶

Дүгнэлт

Цалин урамшуулал

Монгол Улсын иргэний шийдвэр гүйцэтгэгчид төрийн тусгай албан хаагч бөгөөд цолны нэмэгдэл авч байна. Гэхдээ бонусгүй.

Мөн манай улсын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал нь тухайн ажлыг гүйцэтгэх зардлыг л нөхөх хэмжээнд бага байна. Бусад улсад зардлыг үүнээс бага зэрэг өндрөөр тогтоож, шийдвэр гүйцэтгэгч уг зардлаас 15-20 хувийн бонус дор дор нь авах боломжтой байна.

Бусад улсын хувьд цэргийн цолгүй ч бонус авч, төрийн албан хаагч байгаа нь урамшуулах тогтолцоог бүрдүүлжээ. Цэргийн цолгүй болвол уг бонусаар нэмэгдэл цалинтай байх боломжтой байна.

Шийдвэр гүйцэтгэгч ба бусад захиргааны албан хаагч

Гүрж улс гэхэд 3 сая 800 мянга гаруй хүн амтай ч⁸⁷ нийт 424 албан хаагчтай 158 шийдвэр гүйцэтгэгчтэй тэдэнд туслах 157 захиргааны албан хаагчтай, 57 шийдвэр гүйцэтгэлийн цагдаатай багтай байна. Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 56 ахлах шийдвэр гүйцэтгэгчтэй ч Захиргаа, мэргэжлийн удирдлага-хяналт тавих 26 албан хаагч байгаа нь нийт 460 албан хаагчийн 6.7 хувь нь байгаа нь туслах чиг үүрэгтэй захиргааны албан хаагч дутмаг байгаа нь ажиллагаа удаашралтай, шийдвэр гүйцэтгэгч ачаалалтай байгаатай холбоотой байж болохоор байна. /Хавсралт 1-ийн статистик 10-ыг үзнэ үү./

- **Шалгуур үзүүлэлтийн томъёолол 7.** Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт

ШШГТХ-д зааснаар дараах үйл ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэхээр заажээ.

Үйл ажиллагаа	Хуулийн зохицуулалт
Гүйцэтгэх баримт бичиг хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд түүнийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тогтоол гарган гүйцэтгэх баримт бичиг олгосон шүүхэд буцаах	20.3
Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, иргэний	21.1

⁸⁶ Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

⁸⁷ <https://www.worldometers.info/world-population/georgia-population/>

шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарлах	
төлбөр төлөгчийн оршин суух хаяг өөрчлөгдсөн, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрт төлбөр төлөгчийн эд хөрөнгө байхгүй бол шийдвэр гүйцэтгэгч энэ талаар тэмдэглэл үйлдэж, ахлах шийдвэр гүйцэтгэгч болон төлбөр авагчид мэдэгдэх бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч ажлын 3 өдрийн дотор харьяаллыг шийдвэрлэх	22.10
хоёр, түүнээс дээш шийдвэр гүйцэтгэгчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах шийдвэрийг орон нутгийн хэмжээнд ахлах шийдвэр гүйцэтгэгч гаргах	25.2
Ахлах шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлэх, тухайлбал, хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл;	27.2
ахлах шийдвэр гүйцэтгэгч түдгэлзүүлэх үндэслэл арилмагц төлбөр авагч, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн тогтоол гарган иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх	27.6
ахлах шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуусгавар болсонд тооцож, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг хаах	29.1
ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргаж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээн явуулах	30.1
төлбөрийг гаргуулах боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч энэ тухай тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэх баримт бичиг, холбогдох баримтыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж, тогтоол гаргах	31
Шийдвэр гүйцэтгэгч, үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгчийг татгалзан гаргах асуудлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэх	43.8
төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх;	44.2.7
шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно. Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Ахлах шийдвэр гүйцэтгэгч талуудаас ирүүлсэн гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэсэн арга хэмжээг хүчингүйд тооцно.	44.3, 44.6
22.00 цагаас 06.00 цагийн хооронд гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчээс зөвшөөрөл авах. Хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас энэ арга хэмжээг шууд гүйцэтгэсэн тохиолдолд 24 цагийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэнэ.	45.2, 45.3
ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр бусдын орон байранд нэвтрэн орох	48.1
Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч бүрэн эрхийнхээ хүрээнд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхдээ ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авах	57.4
Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр	59.3

гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэх	
худалдан борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийн үнийг тогтоосон үнээс 30 хувиар тооцон бууруулж худалдан борлуулна. Энэ тохиолдолд эд хөрөнгийн үнийг бууруулах талаар ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргах	64.4
дуудлага худалдаа явуулах тухай тогтоол гаргах	66.3
Төлбөр авагч дуудлага худалдааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулахыг зөвшөөрсөн хүсэлтээ ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргах	67.1
Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх тухай шийдвэрийг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгч гаргах	73.6
Төлбөр авагч хөрөнгийн үнэлгээний талаарх мэдэгдэх хуудсыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гүйцэтгэх баримт бичгийн шаардлагад нийцэхүйц хөрөнгийг төлбөрт суутган авах тухай хүсэлтийг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргах	78.3
Гүйцэтгэх баримт бичигт заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд харилцан үүрэг бүхий ижил төрлийн шаардлагыг гүйцэтгүүлэхээр нэхэмжилсэн тохиолдолд аль бага шаардлагыг их шаардлагаас нь хасаж суутган, уг хэмжээгээр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелэгдсэнд тооцох шийдвэрийг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгч гаргах	80.2
Хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсаны улмаас шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухайн баримт бичгийг шүүхэд буцаах тухай шийдвэр гаргаж, ахлах шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлэх	103.4
Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн гаргана.	118.10

Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагааны талаарх зохицуулалт

ШШГТХ-д зааснаар дараах үйл ажиллагааг ерөнхий шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэхээр заажээ.

Үйл ажиллагаа	Хуулийн зохицуулалт
хоёр, түүнээс дээш шийдвэр гүйцэтгэгчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах шийдвэрийг улсын хэмжээнд ерөнхий шийдвэр гүйцэтгэгч гаргах	25.2
Шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргахыг зөвшөөрөхгүй тухай ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргасан бол энэхүү тогтоолын талаар 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.	43.10
Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг шийдэрлэсэн талаарх тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болох	44.4
Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлнэ. Түүнчлэн уг эрхийг сэргээх	59.3, 271.3
шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих;	271.3

Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 56 ахлах шийдвэр гүйцэтгэгчтэй ч Захиргаа, мэргэжлийн удирдлага-хяналт тавих 26 албан хаагч байгаа нь нийт 460 албан хаагчийн 6.7 хувь нь байгаа нь туслах чиг үүрэгтэй захиргааны албан хаагч дутмаг байгаа нь ажиллагаа удаашралтай, шийдвэр гүйцэтгэгч ачаалалтай байгаагаар холбоотой байж болохоор байна. /Хавсралт 1-ийн статистик 10-ыг үзнэ үү./

Бусад улсын туршлага

Гүрж улсад ердөө 158 гүйцэтгэгч байх бөгөөд арын алба сайтай буюу захиргааны 157, шийдвэр гүйцэтгэлийн цагдаа 57, ложистик алба, хуулийн алба зэрэг ажилладаг бөгөөд уг алба нь ажилчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг байна.⁸⁸ Мөн ХБНГУ, БНСУ, Гүрж зэрэг улсын хуулиудад ахлах шийдвэр гүйцэтгэгчээс зөвшөөрөл авч хийх зохицуулалт байхгүй байна.

Олон улсад шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан бүрэн эрхээ хэрэгжүүлж, тэр хэрээрээ хариуцлагаа хүлээдэг байдлыг зөвлөдөг.⁸⁹

Дүгнэлт

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүрэг

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хийх ажлуудыг шийдвэр гүйцэтгэгч бие даан хийх боломжтой төдийгүй шат дамжин зөвшөөрөл авснаар ажиллагаа удаашрах, зөвшөөрөл авахгүйгээр хариуцлагыг хүлээж, тэдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлж болохоор байна. Тухайлбал, орон байранд нэвтрэн орох, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авахад шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан хийх боломжтой байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хийх үйл ажиллагааг цахимжилтаар шийдэх боломжтой байна. Тухайлбал, ажиллагааг нээх, хаах, гүйцэтгэх баримт бичгийг буцаах, дуудлага худалдаа явуулах шийдвэр гаргах гэх мэт.

Ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчдэд гомдол жилд маш их ирдэг бөгөөд энэхүү чиг үүргийг байхгүй болгож, шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шуурхай шийддэг боломжтой.

Арын албаны ажилчид

Шийдвэр гүйцэтгэгчид туслах албаны ажилтан хүрэлцээтэй хэмжээнд байлгах зохицуулалт Гүрж улсад байна. Шийдвэр гүйцэтгэгчийн тоотой тэнцэхүйц хэмжээний арын албатай, харин шат дамжлага нэмэх ахлах шийдвэр гүйцэтгэгч байхгүй.

Бүтэц, зохион байгуулалтын асуудлаар нэмэлт

Хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо болон иргэний шийдвэр гүйцэтгэлийн тусдаа албаны талаар

⁸⁸ Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

⁸⁹ <https://rm.coe.int/cepej-guidelines/16809f007a>

Иргэний шийдвэр гүйцэтгэх тусдаа алба байгуулах

ЕСБХБ-ны судалгаанд ШШГЕГ-ын хариуцах асуудлаас иргэний шийдвэр гүйцэтгэлийг хасч, тусдаа агентлаг байгуулах нь тодорхой давуу талтай байж болох ч уян хатан байдал, үр дүнд суурилсан арга барил нь гол зарчим байх ёстой. Одоогийн төрийн алба хаагчид цэргийн цол, урамшуулал (түүний дотор эрт тэтгэвэрт гарах) зэрэг давуу талтай. Бидний бодлоор бол тусдаа агентлаг байгуулахад энэ нь саад болохгүй. Бусад хэд хэдэн оронд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид дүрэмт хувцас өмсдөг (жишээлбэл, ОХУ, Азербайжан) талаар дурдсан байна.⁹⁰

Гэвч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд цэргийн цолтой байснаар үүсэх эерэг болон сөрөг үр дагаврыг харгалзан үзэхэд сөрөг үр дагавар давамгайлж байгааг анхаарах шаардлагатай байна.

Цэргийн цолтой байхын үр дагавар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага болно.⁹¹ Шийдвэр гүйцэтгэх алба шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх цахим сан бүрдүүлэх, лавлагаа мэдээлэл олгох, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй.⁹²

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдан хорих шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх алба, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх алба, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэсээс бүрдэнэ.⁹³

Төрийн цэргийн байгууллагын нэг хэсэг болох иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид цэргийн цолтой, төрийн тусгай алба хаагч байдаг. Тодруулбал, Цэргийн албаны тухай хуулийн 3.1.1-д зааснаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, **шүүхийн шийдвэр гүйцэтгэх**, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгодог.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн шийдвэр гүйцэтгэлтэй нэгдсэн нэг агентлаг байсаар ирсэн тул иргэний шийдвэр гүйцэтгэлийн алба, албан хаагч цэргийн байгууллага, цэргийн цолтой алба хаагч байх эрх зүйн үндэс бүрджээ.

⁹⁰ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

⁹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257.1 дэх хэсэг.

⁹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 263.1 дэх хэсэг.

⁹³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257.3 дахь хэсэг.

Хэдийгээр цэргийн цолтой алба хаагчид эрт тэтгэвэрт гарах зэрэг алба хаагчид давуу талтай ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөрөг үр дагавар үүсгэх олон сул тултай.

Тухайлбал, шийдвэр гүйцэтгэгч дэслэгчээс, ахлах дэслэгч, хошууч, ахмад гэх 4 цолыг хүртэх боломжтой байдаг,⁹⁴ боловч эдгээрийн дээд албан тушаалтан нь ахлах шийдвэр гүйцэтгэгч /дэд хурандаа ч байх боломжтой/ байх бөгөөд хамгийн дээд албан тушаалтан нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгч /хурандаа/ байна.

Цэргийн албаны тухай хуульд зааснаар дээд офицероос бусад цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг батлан хамгаалах, хил хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох⁹⁵ ба цэргийн цолоо авах нь хүртэл дээд албан тушаалтнаас хамааралтай байгаа нь ажиллагаанд ямар нэг байдлаар нөлөөлөлд автах, ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжийг бүрдүүлж байна.

Мөн цэргийн албанд цэргийн албан тушаалын байдлаар захирах захирагдах байдал заавал байх тул шийдвэр гүйцэтгэгч хараат бус, бие даасан байдлаар шийдвэрийг гүйцэтгэх олон улсын зарчимтай нийцэхгүй байгаа болно.

Иймээс эрүүгийн шийдвэр гүйцэтгэлээс тусад нь алба байгуулах, энэ алба нь цэргийн байгууллага биш байхад анхаарах шаардлагатай. Ингэснээр шийдвэр гүйцэтгэгч хараат бус, бие даасан байдлаар ажиллагааг шуурхай, үр дүнтэй явуулах, цэргийн захирах захирагдах байдлаар ажиллагааг удаашруулах байдлаас сэргийлнэ.

Энэ талаар ЕСБХБ-ны судалгаанд “Иргэний болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчдыг цэргийн эрдэмд сургах шаардлагагүй гэсэн асуудлыг зарим оролцогчид хөндөж байлаа. Харин эрх зүйн болон эдийн засгийн бусад ур чадваруудыг сургах шаардлагатай.” талаар дурджээ.⁹⁶

Түүнчлэн ЕСБХБ-ны судалгаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрүүгийн болон иргэний чиг үүргийг салгах шаардлагатай байгаа талаар зөвлөжээ.⁹⁷

Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тусдаа албаны эрх зүйн үндэс

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болно.⁹⁸

Иргэний шийдвэр гүйцэтгэлийн албыг эрүүгийн шийдвэр гүйцэтгэлээс салгаснаар энэхүү бүдүүвчид өөрчлөлт орох буюу тусдаа иргэний шийдвэр гүйцэтгэлийн алба Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар тусгах боломжтой.

⁹⁴ ШШГЕГ-ын мэдээлэл.

⁹⁵ Цэргийн албаны тухай хуулийн 26.6 дахь хэсэг.

⁹⁶ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

⁹⁷ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

⁹⁸ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.

Түүнчлэн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайдын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.⁹⁹

Засгийн газар тухайн агентлагийг байгуулах шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.¹⁰⁰

Агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.¹⁰¹

Иймээс агентлагийг өөрчлөн байгуулах асуудлыг сайд санал гаргаж, Засгийн газраар шийдвэрлүүлэх боломжтой.

Сургалт

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуульд бакалаврын зэргээр шийдвэр гүйцэтгэгчийг бэлддэг. Гэхдээ тухайн хөтөлбөрийн агуулгыг авч үзвэл, 120 кредит цагийн хөтөлбөртэй байх ба үүнээс иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэл 6, иргэний шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, судалгаа 3, иргэний процессын эрх зүй 3, иргэний эрх зүй 3 нийт 15 кредитийн иргэний шийдвэр гүйцэтгэлийн хичээл үзэхээр байна.¹⁰² Үйлдвэрлэлийн дадлага 4 кредиттэй байна.¹⁰³

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэгч нарт давтан байнгын /ongoing training/ сургалт заавал явагдах зохицуулалт болон практик байхгүй байна.

Мөн дээрх сургуулийг төгссөнөөр цэргийн дэслэгч цолтойгоор шийдвэр гүйцэтгэгчээр томилогддог байна. Харин бусад хуулийн сургуулийн эрх зүйн бакалаврын хөтөлбөр дүүргэсэн этгээдийн хувьд ажилд томилогдсоноос хойш 6 сарын дараагаас дэслэгч цол авдаг байна.¹⁰⁴

Түүнчлэн дээрх сургуулийг төгссөн бол сонгон шалгаруулалтад оролгүй томилогддог бол бусад сургууль төгссөн этгээдийн хувьд шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн байх шаардлага тавигддаг.¹⁰⁵

Мэргэжлийн шаардлага

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага,

⁹⁹ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1 дэх хэсэг.

¹⁰⁰ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.5 дахь хэсэг.

¹⁰¹ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3 дахь хэсэг

¹⁰² “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, Дотоод хэргийн их сургууль.

¹⁰³ “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, Дотоод хэргийн их сургууль.

¹⁰⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл.

¹⁰⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270.4 дэх хэсэг.

шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна.¹⁰⁶

Арван найман насанд хүрсэн нь хангалттай эсэх, шийдвэр гүйцэтгэлийн мэргэжлийн шаардлага нь зохистой хангагдсан эсэх буюу сургалтын агуулгаас энэ нь хамаарахаар байна.

Бусад улсын туршлага

Сургалтын тухайд анхны болон ажилд орсноос хойшхи үргэлжилсэн байнгын сургалтыг олон улсын байгууллагууд, тэр дундаа хувийн шийдвэр гүйцэтгэлийн зарчмыг бий болгосон НҮБ, Дэлхийн банк, Европын консул, ЭСБХБ зэрэг байгууллагуудын нэн тэргүүнд тавьдаг зорилт байдаг.¹⁰⁷ Үүнийг мөн CEPEJ 2009 Guidelines 24-26-д мөн зөвлөсөн байдаг.

Шийдвэр гүйцэтгэгчийг ажилд авахад тухайн нэр дэвшигчийн ёс зүй болон иргэний шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн онол, практик мэдлэг, туршлагыг чухалчилахыг зөвлөж байна. Тэдгээрийн онол, практикын түвшинг шалгалтаар авахыг зөвлөжээ.¹⁰⁸

Түүнчлэн агуулгын хувьд, сургалтаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим, зорилго, мэргэжлийн болон ёс зүйн дүрэм, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шатууд, ажиллагааны үндэслэл, зохион байгуулалт, хэрэгжилт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомж, практик дадлага, суралцагчийн мэдлэгийг үнэлэх, олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг биелүүлэх зэрэг асуудлыг оруулахыг зөвлөжээ.¹⁰⁹

Сургалтын материалыг бичгээр боловсруулахад арга зүй, хөгжүүлэлт чухал талаар мөн дурджээ.¹¹⁰

Ажилд орсны дараах сургалт дундажаар нэг удаадаа 5 орчим өдрийнх байхаар Европийн практик тогтсон байна.¹¹¹

Шийдвэр гүйцэтгэгчид тавигдах шаардлагын хувьд дээд боловсролтой байхыг зөвлөж байна.¹¹²

ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэгчээр бүрэн дунд боловсролтой иргэнийг сургалтад хамруулдаг. Сургалт нь шийдвэр гүйцэтгэлийн процессын талаарх онолын мэдлэг олгох, биеэ хамгаалах, болон практик дээр шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж

¹⁰⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270.3 дахь хэсэг.

¹⁰⁷ Jos Uitdehaag (the Netherlands) Judicial officer, Secretary of the Board of the UIHJ, international expert, Modern training methods for enforcement agents: structured, competence based and interprofessional

¹⁰⁸ Principle IV.3 Recommendation 17/2003 of the Council of Europe нь Jos Uitdehaag (the Netherlands) Judicial officer, Secretary of the Board of the UIHJ, international expert, Modern training methods for enforcement agents: structured, competence based and interprofessional-д ишлэгдсэн.

¹⁰⁹ CEPEJ 2009 Guidelines 28.

¹¹⁰ European Judicial Training 2017; annual report of the European Commission Directorate General for Justice.

¹¹¹ European Judicial Training 2017; annual report of the European Commission Directorate General for Justice.

¹¹² Jos Uitdehaag (the Netherlands) Judicial officer, Secretary of the Board of the UIHJ, international expert, Modern training methods for enforcement agents: structured, competence based and interprofessional

дадлагажих онол практик хосолсон сургалт байдаг.¹¹³ Тодруулбал, онолын хичээлийн хувьд 11 сар, дадлагын хичээл нь 4 сар байна. Түүнчлэн төгсөхөд нь шалгалт авдаг байна.¹¹⁴

Иймээс сургалтын агуулгад иргэний шийдвэр гүйцэтгэлийн процесс, зарчмыг түлхүү заах, практикыг сайтар эзэмшүүлэхэд чиглэсэн байхад анхаарах шаардлагатай байна.

Хувийн шийдвэр гүйцэтгэлийн талаар

Европын үндсэн хуулийн эрх зүйн төв болон Олон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн холбооноос гаргасан “Европын холбоон дахь иргэний шийдвэр гүйцэтгэл харьцуулсан судалгааны тайлан 2021”¹¹⁵-аас үзэхэд тогтолцооны хувьд 3 төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн загвар байна.

ЕСБХБ-ны хувийн хэвшлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог нэвтрүүлэх боломжийн талаар маш товч ярилцсан бөгөөд энэ санааг эрс эсэргүүцсэн зүйл гараагүй. Гэсэн хэдий ч энэ нь хэтэрхий радикал байж магадгүй бөгөөд ийм санаачилга гаргахад тодорхой улс төрийн хүсэл зориг алга. Зарим хүн төрийн болон хувийн хэвшлийн холимог хууль сахиулах тогтолцоог бий болгох саналыг дэвшүүлсэн. Жишээлбэл, төрийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүүхдийн мөнгө болон бусад ижил төстэй нэхэмжлэлийг хариуцдаг бол хувийн шийдвэр гүйцэтгэгчид томоохон/арилжааны нэхэмжлэлийг хариуцах болно.¹¹⁶

Төрийн албаны шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс ялгаатай нь хувийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн туслах байгууллага биш, хуулийн хүрээнд бие даасан шийдвэр гаргадаг байгууллага юм. Мөн хувийн тогтолцоо руу шилжсэнээр шийдвэр гүйцэтгэл нь төрд (эсвэл шүүхэд) дарамт болохгүй гэсэн үг биш гэдгийг ойлгох нь чухал. Харин ч хувийн тогтолцоонд төрийн оролцоо төрд суурилсан шийдвэр гүйцэтгэх тогтолцоотой харьцуулахад бүр ч өндөр байж болох юм. Эдгээр зардлыг мэдээж тооцох ёстой.¹¹⁷

Холимог тогтолцоо

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал өөрчлөгдөж байгаа *трендийг* авч үзвэл дараах дарааллыг харуулж байна.

Төрийн статус —————> Холимог статус —————> Хувийн статус

Холимог тогтолцоо бүхий улсад төрийн болон хувийн шийдвэр гүйцэтгэгч аль аль нь ажилладаг бөгөөд улсаад хувийн 100 хувь тогтолцоонд шилжихээс өмнө эдгээр загварыг хослуулдаг байна. Холимог тогтолцоотой улсууд болох Гүрж, Казакстан улсын хувийн шийдвэр гүйцэтгэгчийн тогтолцоог авч үзвэл:

¹¹³ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

¹¹⁴ Bayerische Justizakademie 2024.

¹¹⁵ <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

¹¹⁶ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

¹¹⁷ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

Гүрж улсад гэхэд төрийн болон хувийн шийдвэр гүйцэтгэгчийн холимог тогтолцоо байна. Энэ талаар тус улсын шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн III² бүлгээр private bailiff буюу хувийн шийдвэр гүйцэтгэлийн талаар, мөн бусад бүлэгт төрийн шийдвэр гүйцэтгэгч зэрэгцэн орших холимог тогтолцоог хуульчилжээ.¹¹⁸

Түүнчлэн Казакстан улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн 16 дугаар бүлгээр хувийн шийдвэр гүйцэтгэгчийн талаар зохицуулсан.¹¹⁹

Тухайлбал, Казакстан улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хувийн шийдвэр гүйцэтгэгч нь эрх зүйч мэргэжилтэй, хувийн шийдвэр гүйцэтгэгчдийн танхимд элссэн, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх шаардлага тавигддаг. Мөн тодорхой төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, төрийн албанаас сөрөг шалтгаанаар урьд нь халагдаж байгаагүй гэх мэт шаардлага тавигдаж байна.¹²⁰

Эдгээр шаардлагыг хангасан бөгөөд дадлага хийсэн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн байгууллагын хувийн шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах эрх олгох 2 шаттай шалгалтанд орж тэнцсэн тохиолдолд хувийн шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах эрхтэй болно. Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн байгууллага уг эрхийг олгож, хувийн шийдвэр гүйцэтгэгчдийн бүртгэлийг хөтөлнө. Шүүгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан, прокурор, мөрдөгчөөр 5 жил ажилласан этгээд гэх мэт тодорхой этгээдийг дадлага хийх, эрх олгох шалгалтад орохоос чөлөөлдөг.¹²¹

Мөн тус хуульд хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түүнчлэн ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээлгэх асуудлыг тусгасан байна. Хувийн шийдвэр гүйцэтгэгч мэргэжлийн үйл ажиллагааны даатгалын үндсэн дээр үйл ажиллагаа явуулж, хувийн шийдвэр гүйцэтгэгчдийн танхимд гишүүнчлэлийн татвар төлж, ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.¹²² Мөн хувийн шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх тодорхой нутаг дэвсгэрийн бүсчлэлд хуваагдаж, төлбөр авагчийн хүсэлтээр шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа явуулна. Тэдгээрийн үйл ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал хариуцсан төрийн байгууллага болон хувийн шийдвэр гүйцэтгэгчдийн танхим хяналт тавина.¹²³

Иймд хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, хариуцлага, хяналтын талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд бий болгож, холимог тогтолцоонд шилжиж турших боломжтой.

¹¹⁸ <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

¹¹⁹ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

¹²⁰ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

¹²¹ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

¹²² https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

¹²³ https://adilet.zan.kz/eng/docs/Z100000261_#:~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings,2021

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн мэдээлэлд (мэдээллийн сан, лавлагаа гэх мэт) хандах эрх, одоогийн зохицуулалт хэр сайн ажиллаж байгаа, мөн ямар нэгэн дутагдалтай, бэрхшээлтэй байдлаас болж шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад тотгор учирж байгаа эсэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор төлбөр төлөгчийн оршин суугаа газар, банкин дахь данс болон хөрөнгийн талаарх мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт зэргийг холбогдох этгээдээс гаргуулдаг байна. Эдгээр үйл ажиллагааг хуульд дараах байдлаар тусгажээ.

д/д	Хуулийн заалт
1.	44 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ 44.1.Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно. 44.2.Энэ хуулийн 44.1-д заасан арга хэмжээнд дараахь үйл ажиллагаа хамаарна: 44.2.2.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах; 44.2.11.төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар <u>улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;</u>
2.	50 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх 50.2.Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны дугаар, төрөл, данс эзэмшигчийн нэр болон бусад шаардлагатай мэдээлэл тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч банк, эрх бүхий хуулийн этгээдээс шаардлагатай лавлагаа, тодорхойлолтыг гаргуулж, хэрэв төлбөр төлөгч данстай бол дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэрийг хүргүүлнэ.
3.	58 дугаар зүйл.Улсын бүртгэлийн байгууллагаас лавлагаа, тодорхойлолт гаргуулах 58.1.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахуйц хөрөнгийг олж тогтоох зорилгоор хууль тогтоомжийн дагуу бүртгүүлбэл зохих хөрөнгө, тэдгээрийн эрхийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандаж лавлагаа, тодорхойлолт гаргуулна.
4.	96 дугаар зүйл.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх 96.4.Улсын бүртгэлийн байгууллага нь энэ хуулийн 96.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд тухайн битүүмжлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг тодорхойлсон лавлагааг ажлын 3 өдрийн дотор мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ.
5.	117 дугаар зүйл.Гадаад улсын болон олон улсын байгууллагын хөрөнгийг битүүмжлэх, хураах

	117.2.Төлбөр төлөгч-гадаад улс Монгол Улсын нутаг дэвсгэрт өмч хөрөнгөтэй эсэхийг тогтоох зорилгоор төрийн холбогдох байгууллага, албан тушаалтнаас лавлагаа, тодорхойлолт авна.
6.	271 дүгээр зүйл.Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх 271.1.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 44, 77 дугаар зүйлд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 271.1.9.төлбөр төлөгч, ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах; 271.1.14.шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээдийг эрэн сурвалжлах, уг зорилгоор төлбөр төлөгч, ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ хаягийг тогтоох зорилгоор шаардлагатай лавлагаа, мэдээлэл авах;

Хуульд заасан дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд үүсдэг хүндрэл бэрхшээлийн талаар шийдвэр гүйцэтгэгч нарын дунд асуулга хэлбэрээр явуулсан бөгөөд асуулгад үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. **Үүнд:**

1.Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах арга хэмжээний талаар

2021 онд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус хуулийн дагуу төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем ажиллаж эхэлсэн бөгөөд Улсын бүртгэлийн байгууллагаас гаргуулах шаардлагатай мэдээллүүдийн дийлэнхийг тус системээр дамжуулан гаргаж авдаг болсон. Тус системээс төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэл, иргэний бүртгэл, оршин суугаа хаяг зэрэг шаардлагатай олон төрлийн бүртгэлийн мэдээллийг авах боломжтой.

Харин төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн мэдээллийг авах боломжгүй тул уг мэдээллийг бүртгэлийн байгууллагад хүсэлт гаргах замаар авдаг бөгөөд хүсэлт гаргаснаас хойш дунджаар 14 хоногийн дотор бүртгэлийн байгууллага хариу ирүүлдэг байна. Товчхондоо, энэхүү мэдээллийг гаргаж өгөх хугацааны зохицуулалт нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль дахь 30 хоногийн хугацаа болдог практик тогтсон.

Гэтэл энэ талаарх хуулийн зохицуулалтыг судлан үзвэл Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-т заасны дагуу “төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад үл хөдлөх эд хөрөнгө, газрын байршил, хил зааг, талбай, эзлэхүүн, тоо хэмжээ, зориулалт, төлөв байдал, эргэлтийн цэг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн төрөл, тусгай тэмдэглэл.” нь улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн нээлттэй мэдээлэлд хамаарч байна.

Хуулийн дээрх зохицуулалтаас харахад үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн талаарх мэдээлэл нь нээлттэй мэдээлэлд хамаарах бөгөөд барьцааны бүртгэлийн талаарх мэдээллийг тус хуулийн 12.11-д заасны дагуу төрийн мэдээлэл

солилцооны системээр дамжуулан авах эрх зүйн орчин бүрэн хангагдсан байна. Нөгөөтэйгүүр мөн хуулийн 12.9-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага лавлагаа, мэдээлэл авах тухай хүсэлт, мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж хариу өгнө.” гэж зааснаас үзэхэд үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн талаарх мэдээллийг олж авахад хугацаа шаарддаг гэх асуудал нь хуулийн зохицуулалтаас бус харин хуулийн хэрэгжилт хангалтгүйн улмаас үүсдэг гэж дүгнэж байна.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад шаардлагатай “ХУР” системээс авах боломжгүй “гэрлэлтийн” болон “төрөл, садангийн” гэх 2 төрлийн лавлагаа, мэдээлэл байна. Хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэгчийн холбогдох этгээдээс мэдээлэл, лавлагаа авах эрх нь зөвхөн төлбөр төлөгчийн мэдээллээр хязгаарлагддаг бөгөөд түүний гэр бүл, төрөл садангийн нэр дээр эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар мэдээлэл авах эрх нь хязгаарлагдмал байна.

Иймээс төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд шийдвэр гүйцэтгэгч шууд нэвтэрч авч болохгүй, гэхдээ шаардлагатай мэдээллийг шуурхай авах зохицуулалтыг бүрдүүлэх шаардлага үүсчээ.

2.Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны дугаар, төрөл, данс эзэмшигчийн нэр болон бусад шаардлагатай мэдээлэл тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч банк, эрх бүхий хуулийн этгээдээс шаардлагатай лавлагаа, тодорхойлолтыг гаргуулж, хэрэв төлбөр төлөгч данстай бол дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэрийг хүргүүлэх ажиллагааны талаар

Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны дугаар, төрөл, данс эзэмшигчийн нэр болон бусад шаардлагатай мэдээллийг Банкны тухай 7 дугаар зүйлийн 7.2.7-д “төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга зөвшөөрсөн” гэж заасны дагуу гаргуулан авдаг бөгөөд уг ажиллагаанд дунджаар 1 өдөр шаардлагатай байдаг төдийлөн хүндрэл үүсдэггүй харин төлбөр төлөгчийн дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, дансан дахь мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, татах арга хэмжээг авахад хүндрэл бэрхшээл үүсдэг тухай асуулгын хариуд дурджээ.

Тухайлбал, зарим арилжааны банкууд төлбөр төлөгчийн данснаас мөнгөн хөрөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэхдээ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчтай байгуулсан гэрээ, түүний даалгавар, зөвшөөрлийг үндэслэн шилжүүлгийг хийнэ.” гэж заасныг үндэслэн гэрээ, дотоод журамд заасан бол заавал данс эзэмшигчээс зөвшөөрөл авах ажиллагааг хийдэг байна. Ингэснээр шуурхай байх байдал алдагдаж байна.

Мөн хуулийн этгээдийн данс битүүмжлэх, мөнгөн хөрөнгийг татах ажиллагааны явцад тухайн хуулийн этгээд харилцагч банктai зээлийн харилцаатай тохиолдолд битүүмжилсэн данснаас банкинд төлбөл зохих зээлийн төлбөрийг суутгасны дараа үлдэгдэл мөнгөн хөрөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэх явдал цөөнгүй байгаа нь шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг хөндөж байгааг анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

Цахим баримт бичиг (цахим гарын үсэг), харилцаа холбооны цахим хэрэгсэл, мэдээллийн сүлжээний ашиглалт, болон хэргийн удирдлагын системийг цахимжуулах, автоматжуулах талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан цахим ажиллагаатай холбоотой зохицуулалтын тухайд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхэд цахим мэдээллийн сүлжээ ашиглаж болно.” гэж, 10.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 10.1-д заасан цахим мэдээллийн сүлжээг ашиглан ирүүлсэн зохих баталгаа бүхий шийдвэр /баримт бичиг/ болон албаны хэрэгцээнд ашиглаж байгаа төрийн байгууллагын төвлөрсөн мэдээллийн сангийн лавлагааг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор хуульд заасан арга хэмжээг гүйцэтгэж болно.” гэж тус тус заажээ.

Дээрх зохицуулалтад заасан “цахим мэдээллийн сүлжээ” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “мэдээллийн сүлжээ” гэж хоёр, түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл илгээх, дамжуулах, хүлээн авах программ хангамж болон техник хэрэгслийн иж бүрдлийг; гэж, 4.1.9 дахь заалтад “цахим баримт бичиг” гэж мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой мэдээллийг ойлгохоор тус тус зааснаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглаж байгаа цахим мэдээллийн сүлжээг хоёр, түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл илгээх, дамжуулах, хүлээн авах программ хангамж гэж ойлгож болохоор байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглаж байгаа цахим мэдээллийн сүлжээ нь цаасан баримтыг цахимаар солилцох төдий зохицуулалтаар хязгаарлагдаж байх бөгөөд баримт бичгийг цахим хэлбэрээр үйлдэх, үүнийг цаасан баримт бичигтэй адилтгах талаар зохицуулалтгүй байна.


Дээрх хуулийн зохицуулалт нь практикт “Хэргийн удирдлагын систем” хэлбэрээр хэрэгждэг бөгөөд тус системийн үйлдлийг задлан авч үзвэл¹²⁴:

- Тушаал, шийдвэрийн удирдлага;
- Хэргийн удирдлага;
- Гуравдагч этгээдийн лавлагаа, мэдээлэл;
- Хүсэл, санал хүлээн авах;
- Тайлан, мэдээ;
- Нэхэмжлэлийн удирдлага;
- Ажиллагааны талуудын аппликэйшн зэрэг багтаж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэхээс дуусгах хүртэл авч хэрэгжүүлдэг арга хэмжээг тоймлон авч үзвэл¹²⁵:

¹²⁴ “Монгол Улсад арилжааны шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг бэхжүүлэх нь” техникийн хамтын ажиллагааны төсөл. “МУ-ын ШШГЕГ-т зориулсан Хэргийн удирдлагын систем (ХУС)-ийг шинэчлэх үзэл баримтлал” тайлан. 2024 он. 8-р хуудас.

¹²⁵ “Монгол Улсад арилжааны шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг бэхжүүлэх нь” техникийн хамтын ажиллагааны төсөл. “МУ-ын ШШГЕГ-т зориулсан Хэргийн удирдлагын систем (ХУС)-ийг шинэчлэх үзэл баримтлал” тайлан. 2024 он. 14-р хуудас.



Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд цаасанд суурилсан баримт бичгийг цахимд сүлжээнд оруулах, мэдэгдэл хүргүүлэх ажиллагааг цахимаар явуулах боломж хязгаарлагдмал, мөн давхардсан ажиллагаа ихтэй бөгөөд энэхүү холимог арга нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үр ашиггүйгээс гадна ажлын ачаалал үүсгэх зэргээр нэмэлт зардал үүсгэдэг гэж үзэхээр байна.

Түүнчлэн “Хэргийн удирдлагын систем”-д мэдээллийн өгөгдлийг оруулахын зэрэгцээ баримт, бичгийг цаасан хэлбэрээр давхар үйлдэж, хадгалдаг бөгөөд үүнээс гуравдагч этгээдтэй харилцах баримт бичгийг голчлон цаасан баримтад тулгуурладаг бөгөөд үйл ажиллагааны тайлан, актыг гараар үйлддэг байна.

Иймд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад авч хэрэгжүүлдэг мэдэгдэл хүргүүлэх, дуудлага худалдаа зохион байгуулах зэрэг тодорхой төрлийн арга хэмжээ, үйлдлүүдийг цахим хэлбэрээр явуулах зохицуулалтыг хуульд тусгаж, “Хэргийн удирдлагын систем”-ийг хөгжүүлэх замаар цахимжуулах боломжтой гэж үзэж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэгт зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй байна.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цахим баримт бичгийг цаасан баримт бичигтэй адилтган үзэх нөхцөл бүрдсэн. Тухайлбал, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Тоон гарын үсэг нь бичмэл гарын үсэгтэй адил хүчинтэй байна.” гэж заасан.

Тухайлбал, шийдвэр гүйцэтгэгч бие даан хийх боломжгүй, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлөөр хийх ажиллагаа болох хувийн хэрэг нээх, ажиллагаа үүсгэх тогтоол гаргах, ажиллагааг түдгэлзүүлэх, ажиллагааны талаарх гомдлыг хянах, түдгэлзүүлсэн хугацаанд хяналт тавих, ажиллагааг сэргээх, ажиллагааг дуусгавар

болгож хувийн хэрэг хаах, дуудлага худалдаа явуулах, орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргах, ахлан шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэх зэрэг шат дараалласан хугацаа шаардсан ажиллагааг цахим хэлбэрээр бие даан явуулах боломжтой байна.

2024 оны 10 дугаар сарын байдлаар 1,287,187 тоон гарын үсэг олгосон бол үүнээс 1,127,388 иргэнд, 133,440 тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгжид олгожээ.¹²⁶

Тоон гарын үсгийг төрийн худалдан авах систем, албан хэрэг хөтлөлтийн систем, тусгай зөвшөөрлийн хүсэлт зэрэг иргэн, аж ахуйн нэгжид цахимаар үзүүлж буй үйлчилгээнд нэгтгэсэн бөгөөд тоон гарын үсэг хэрэглэх замаар цахим шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцох боломж нөхцөл бүрдэж эхэлсэн байна.

Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд мэдэгдэл хүргэх системийн талаар зохицуулсан байх бөгөөд 23.3-т “Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан иргэний бүртгэлийн дугаараар хүнд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаараар хуулийн этгээдэд цахим шуудангийн хаягийг хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр мэдэгдэл хүргэх системд үүсгэнэ.” 23.4-т “Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 23.3-т зааснаас бусад цахим шуудангийн хаягийг мэдэгдэл хүргэх системд бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно.” гэж заасны дагуу төрөөс иргэний бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаараар нээсэн цахим хаягт, эсхүл мэдэгдэл хүргэх системд бүртгүүлсэн бусад хаягаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдэгдлийг хүргэх боломж нөхцөл бий болсон байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Эрх зүйт төрийн үзүүлэлт /Rule of law Index/-ээр 7 хүчин зүйлийг хэмждэг бөгөөд иргэний эрхийн хамгаалалт /civil justice/ нь эрх зүйт төрийн үзүүлэлтийн нэг үндсэн үзүүлэлт болно.¹²⁷ Тус үзүүлэлтээр иргэнд учирсан хохирлыг тухайн улс тайван, үр дүнтэй аргаар иргэний эрх зүйн тогтолцоогоороо барагдуулж байгаа эсэх, тогтолцоо нь нээлттэй, үнэтэй биш бөгөөд ялгаварлан гадуурхалт, авлига, төрийн албан хаагчийн зохисгүй нөлөөллөөс ангид эсэх, иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь үндэслэлгүйгээр удааширдаг эсэх, шүүхийн шийдвэр үр дүнтэй хэрэгждэг эсэхийг хэмждэг байна.¹²⁸

Монгол Улс эрх зүйт төрийн индексээр 2022 онд 65 дугаарт жагсаж байгаа бөгөөд Civil Justice буюу иргэний эрхийн хамгаалалт үзүүлэлтийн дэд хүчин зүйл болох иргэний шийдвэр гүйцэтгэл үр дүнтэй байх үзүүлэлтээр **80 дугаарт жагсаж байгаа тул** иргэний шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо, шийдвэр гүйцэтгэх

¹²⁶ <https://montsame.mn/mn/read/353747>

¹²⁷ https://eucrim.eu/news/new-2022-rule-of-law-index/?fbclid=IwAR0-_dsWAPqlyDA1nfabG2NdoMMNf4DZv_SmgeRSG1EvjeBsfeEPn_6YLuo

¹²⁸ https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2022/Denmark/Civil%20Justice/?fbclid=IwAR2AdiPD05venmr2gS7ScAbnkiovqpPb7gWTjWE_RAc7YtZfTqVIBICeF_4Q

ажиллагааны журмыг боловсронгуй болгох, уг ажиллагааг үр дүнтэй хэрэгжих эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.¹²⁹

Дараах дүгнэлтийг энэхүү судалгаанд үндэслэн өгч байна. **Үүнд:**

1/Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан албадлагын арга хэмжээний талаарх тогтоол, шийдвэрийг хүчингүй болгуулахаар талууд /ихэвчлэн төлбөр төлөгч/ болон өмчлөгч шүүхэд гомдол гаргаж, тус гомдлыг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл ажиллагаа түдгэлзээгдэж, улмаар шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй төлбөр төлөгчөөс төлбөр авагч төлбөрөө удаан хугацаанд авч чадахгүй, ажиллагаа сунжрах гол шалтгаан болж байна.

2/Гэтэл одоогийн хүчин төгөлдөр дагаж буй хуульд албадлагын арга хэмжээг биелүүлэхгүй бол хөшүүрэгдэх хөшүүрэг байхгүй, тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд төлбөл зохих мөнгөн дүнд алданги, торгууль тооцох зохицуулалт үгүй.

3/Шүүхэд гомдол гаргах хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.5 дахь хэсэгт заасны дагуу өмчлөгч болон талууд иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй, эсхүл хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гүйцэтгэх хуудастай бол иргэний хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхэд law suit буюу нэхэмжлэл гаргадаг бөгөөд энэ тохиолдолд төлбөр төлөгч нэхэмжлэгч буюу claimant болж, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч буюу defendant болж иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа буюу litigation процесст ордог.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 156.2-т зааснаар эн төрлийн гомдлыг 2017 оноос хойш ердийн журмаар шийддэг байсан. Харин 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдлыг тусгайлсан журмаар ердийн журмаас богиновтор хугацаанд, зөвхөн давж заалддаг, хяналтын гомдол гаргахгүй байдлаар шийдвэрлэхээр болсон.¹³⁰

Гэвч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шат буюу civil enforcement үе шат нь албадлагын үе шат буюу шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд албадан гүйцэтгүүлэх үе шат тул энэ үе шатанд law suit буюу нэхэмжлэлийг төлбөр төлөгч гаргаж claimant болох, шийдвэр гүйцэтгэгч defendant буюу хариуцагч болох боломжгүй юм. Учир нь материаллаг эрхийн маргаан нэгэнт дууссаны дараах үе шат юм.

Иймээс энэ үе шатанд зөвхөн complaint, objection буюу процессын гомдол гаргаж, түүнийг шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шуурхай шийдвэрлэдэг бусад улсын туршлага байгааг анхаарч, засах шаардлагатай байна. Түүнчлэн ахлах шийдвэр гүйцэтгэгч, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид ханддаг давхар үе шаттай гомдлыг байхгүй болгож, ажиллагаанд нэг удаа шуурхай гомдлыг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид хандан шийдвэрлэдэг шуурхай, үр дүнтэй механизмыг бий болгох;

¹²⁹ World Justice Project, <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2022/Mongolia/Civil%20Justice>

¹³⁰ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹¹².

4/Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргахад гомдлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгч түдгэлзүүлдэг зохицуулалттай¹³¹ мөн үнэлгээний гомдлын хувьд шүүгч гомдлыг хянан шийдвэрлэж дуустал түдгэлзүүлдэг зохицуулалттай¹³² тул түдгэлзүүлж, удаашруулж гомдол гаргадаг шалтгааныг нөхцөлдүүлж байна.

Иймээс гомдлыг шуурхай шийдвэрлэх, мөн энэ хугацаанд төлбөр төлөгчөөс баталгаа гаргаж, төлбөр авагчид хохиролгүй бол түдгэлзүүлэх боломжтой байдлаар зохицуулбал гомдол үндэслэлгүйгээр гаргаж, ажиллагааг удаашруулдаг байдал буурахаар байна.

5/Түүнчлэн гомдлыг аман хуралдаан хийлгүйгээр шийдвэрлэх боломжтой байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдлыг гаргах тодорхой үндэслэлийг хуульчлах, одоогийн хуулийн зохицуулалтаар бүхий л тохиолдолд гомдол гаргах боломжтой задгай байгааг хумих, гомдлыг гомдол гаргагч тодорхой нотлох баримттай гаргах, харин шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хийсэн бүхий л ажиллагааг ажиллагааны материалаас шийдвэр гүйцэтгэлийн шүүгч цахимаар танилцах боломжтой байдлаар зохицуулах боломжтой байна.

6/Үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргаж, хянан шийдвэрлэж дуустал ажиллагаа түдгэлзэж зогсдог тул төлбөр төлөгч үнэлгээний гомдол энэ зорилгоор гаргах шалтгаан болсон байна.

Иймд үнэлгээний асуудлаар маргаан гарвал дахин үнэлгээ хийлгэж, энэ нь эцсийн байхаар шийдвэрлэвэл зохихоор байна.

7/Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах зохицуулалт нь үр дүнгүй олон үе шаттай, үе шат бүрд гомдол гаргаж болохоор тусгасан нь ажиллагааг удаашруулах үндэслэл болсон байна.

Тэгвэл гадаад улсын хууль тогтоомжийг үзэхэд, үл хөдлөх эд хөрөнгийг seize буюу битүүмжилснээс хойш үнэлүүлж, АДХ-нд оруулж байна. Seize гэх нэр томъёог хураах, битүүмжлэх гэсэн утгаар тайлбарласан байна.¹³³ Иймд Битүүмжлэх, хураах гэсэн 2 тогтоол гаргах нь ажиллагааг удаашруулж байна.

8/Бусад улсад үл хөдлөх хөрөнгө албадан дуудлага худалдааны хүртээмжийг өсгөхийн тулд ялагчид өмчлөх эрх даруй шилждэг зохицуулалтыг тусгасан байна.

Манай улсын хувьд ялагч тодорсон ч дуудлага худалдааг хүчингүй болгуулахаар шүүхэд гомдол law suit гарган удаашруулж байгаа тул ялагч төлбөрийг төлснөөр өмчлөх эрх шилжүүлэх шаардлага үүсчээ. Ингэснээр дуудлага худалдаанд итгэх оролцогчийн итгэл нэмэгдэж, дуудлага худалдаанд оролцогч ихэснэ.

9/ Түүнчлэн Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх талаарх хуулийн 60.1 дэх зохицуулалтын тухайд практикт хэрэглэсэн тохиолдол байхгүй байна. Учир нь төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэх зохицуулалттай тул төлбөр төлөгч ийм хүсэлт гаргахгүй нь тодорхой юм.

¹³¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.2.5 дахь заалт

¹³² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.1.4 дэх заалт

¹³³ С.Нарангэрэл – Хууль зүйн Англи-Монгол эх толь 2012 он, 489 дүгээр тал.

10/Дуудлага худалдаанд оролцогчийн ирц бага байгаа нь энэ талаарх зарлал хүнд хүрэхгүй байгаатай нэг талаар холбоотой байна.

11/ҮХЭХ барьцаалсан шүүхийн шийдвэрийн хувьд барьцаагүй ҮХЭХ-ийг ажиллагаанд оруулахаас шуурхай байдлаар зохицуулсан зохицуулалт хуульд байхгүй.

12/Хөрөнгийн мэдүүлэг авах Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46 дугаар зүйл нь албадах арга хэрэгсэл биш хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй байхад хэрхэх хөшүүрэг, үр дагаваргүй хуульчлагдснаас шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийг эрэх, араас нь хөөх зохицуулалт болжээ. Хөрөнгийн мэдүүлэг аваад төлөхгүй, эсхүл хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх, төрийн зарим үйлчилгээг хязгаарлах, мэдээллийг нийтэд, эсхүл холбогдох байгууллагад нээлттэй болгох зэргээр төлбөр төлөгчид төлбөрөө төлөх хөшүүрэг байхгүй байна.

13/Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зөрчил, эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэхтэй холбоотой зохицуулалтууд буюу төлбөр төлөгчийн хариуцлагын тухайд хэрэгжилт сул. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлд саад учруулсан, үл биелүүлсэн бол Зөрчлийн болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага яригдахаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шийдвэр гүйцэтгэгч өөрөө авч хэрэгжүүлэх торгох, баривчлах зэрэг арга хэмжээ авах боломжгүй, цагдаа, прокурорт хандан шүүхээр шийдвэрлүүлэхээр байгаа нь үр дүнгүй байна.

14/Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зардал нь зөвхөн ажиллагааны зардлыг л гаргуулах хэмжээнд байна. Иймээс энэхүү зардлаас шийдвэр гүйцэтгэгчид хувь өгөх боломжгүй байна.

ХБНГУ-ын хувьд гэхэд, шийдвэр гүйцэтгэгч нь төрийн албан хаагчийн үндсэн цалингаас гадна төлбөр авагчийн урьдчилан төлсөн ажиллагааны зардлын 15 хувийг бонус болгон авдаг.¹³⁴ Ажиллагаа бүр энэхүү бонусыг шингээсэн хэмжээнд тогтоосон зардалтай байдаг.

Түүнчлэн Гүрж улсын хувьд мөн адил шийдвэр гүйцэтгэгч ажиллагааны зардлаас 15 хувийг бонус байдлаар авдаг, хувийн шийдвэр гүйцэтгэгч зардлыг бүтэн авч, үйл ажиллагаандаа зарцуулдаг байна.¹³⁵

15/Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хуульд заасан ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан хийхүйц, мөн цахим шийдлээр хийх боломжтой зүйлс байна. Мөн ахлах шийдвэр гүйцэтгэгч эдгээр ажиллагааг хийснээр ажиллагааг тэр хугацаагаар удаашруулах сул талтай байна.

Харин шийдвэр гүйцэтгэгчид туслах албан хаагчдыг бий болгох шаардлагатай болжээ. Тухайлбал, Гүрж улсад ердөө 158 гүйцэтгэгч байх бөгөөд арын алба сайтай буюу захиргааны 157, шийдвэр гүйцэтгэлийн цагдаа 57, ложистик алба, хуулийн алба зэрэг ажилладаг бөгөөд уг алба нь ажилчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг байна.¹³⁶ Мөн ХБНГУ, БНСУ, Гүрж зэрэг улсын хуулиудад ахлах шийдвэр гүйцэтгэгчээс зөвшөөрөл авч хийх зохицуулалт байхгүй байна.

¹³⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

¹³⁵ Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

¹³⁶ Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

16/Цэргийн цолтой байснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашрах, ашиг сонирхлын зөрчил бий болох сул талтай тул шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлсийг зохистой хэмжээнд хуульчлан урамшуулалтай байдлаар эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр хуульчлах нь эерэг үр дүнг авчирна.

17/Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг хуульчлан, холимог тогтолцоог турших боломжийг нээх, ингэхдээ бэлтгэл ажлыг сайтар хангах шаардлагатай.

18/Сургалтын агуулгыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтыг сайтар хангалттай оруулсан байдлаар боловсруулах, мөн дадлагын хугацаа, хөтөлбөр хангалттай хэмжээнд боловсруулагдах шаардлагатай байна. Насны хувьд 18 насыг дээшлүүлбэл зохистой байж болно.

19/Цахим баримт бичгийг цаасан хувьтай адил үзэх, цахим сангаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүчинтэй буюу цаасаар давхар хийх шаардлагагүй байгааг анхаарах нь зүйтэй. Ингэснээр үргүй зардал үүсгэж, удаашрахаас сэргийлнэ.

20/Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системээс шийдвэр гүйцэтгэгч авах боломжгүй мэдээллийг төрийн байгууллагаас шуурхай авах зохицуулалт шаардлагатай байна.

Зөвлөмж

Дараах зөвлөмжийг өгч байна. **Үүнд:**

Гомдол, ажиллагааг түүнтэй холбоотойгоор түдгэлзүүлэх асуудлаар:

Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хянах, олон шаттай гомдол гаргахгүй байх буюу ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргах шат дамжлага бүхий зохицуулалтыг хүчингүй болгох

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гомдлоор авч хэлэлцэх иргэний хэргээс шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой гомдлыг хасаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь шуурхай гомдлыг шийдвэр гүйцэтгэх хариуцсан шүүгч шийдвэрлэхээр өөрчлөх;

Шуурхай гомдол гаргах, шуурхай шийдвэрлэх үндэслэл, зарчим, журмыг бий болгох, хугацаандаа гаргаагүй бол гомдол гаргах эрхээ алдахаар заах;

Гомдол гаргахад түдгэлзүүлэх зохицуулалтыг түдгэлзүүлэхэд баталгаатайгаар төлбөр төлөгч түдгэлзүүлж болох онцгой тохиолдлыг л бий болгож шийдвэрлэх, ингэснээр түдгэлзүүлэх гэж төлбөр төлөгч гомдол гаргах нь буурна;

Үнэлгээний гомдлыг шүүхэд гаргах зохицуулалтын талаар:

Үнэлгээг дахин, эсхүл нэмэлтээр хийлгүүлэх эрх нь талуудад Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу хадгалагдаж байгаа болно. Заавал шүүхэд хандаж үнэлгээг хүчингүй болгуулах бус шууд үнэлгээг дахин, эсхүл нэмэлтээр хийлгүүлэх хүсэлтийг тавих боломжтой байна.

Үнэлгээ, шинжилгээг дутуу, буруу хийх нь процесс дахь ажиллагаа болохоос биш материаллаг эрх зүйн зөрчил биш болно. Харин иргэний эрх зүйн материаллаг эрхийн зөрчил үүссэн үед хүн, хуулийн этгээд иргэний хэргийн шүүхэд хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй.

Иймээс талууд дахин шинжилгээ хийлгэх эрхтэй байж болно. Харин үндсэн хэрэг маргаан дуусчихаад байхад хэрэг маргаан шийдвэрлэдэг шүүхдээ нэхэмжлэл гарган нэхэмжлэгч болж, гурван шатны шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж оролцох, нэхэмжлэл гаргах замаар шийдвэр гүйцэтгэх байгууллагыг хариуцагч болгон үнэлгээг хүчингүйд тооцуулах боломжийг төлбөр төлөгчид олгосноор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа санаатайгаар удаашрах, төлбөр төлөгч, түүний өмгөөлөгчийн зүгээс ажиллагааг үр дүнгүй, сунжруулах боломж олгосон зохицуулалт байгааг засах шаардлагатай байна.

ҮХЭХ-д явуулах ажиллагаанд холбогдох зохицуулалтын талаар:

Битүүмжлэх, дараа нь хураах зохицуулалт удаашрал үүсгэж байх тул ҮХЭХ-ийг зөвхөн битүүмжлээд албадан дуудлага худалдаагаар борлуулах зохицуулалт бий болгох.

Битүүмжлэхдээ дуудлага худалдаа явуулах шийдвэрийг цугт нь гаргах боломжтой байна.

Барьцааны зүйл ҮХЭХ-д ажиллагаа явуулах ялгамжтай зохицуулалт бий болгох буюу барьцааны зүйл бол битүүмжлэх шаардлагагүй шууд дуудлага худалдаа явуулах шийдвэр шуурхай гаргадаг байх, ингэснээр гэрээнд итгэх итгэл хангагдана.

Ялагчид өмчлөх эрх төлбөр төлснөөр шилждэг байх зохицуулалтыг бий болгох, ингэснээр дуудлага худалдаанд орох сонирхолтой этгээд нэмэгдэж, хүртээмж сайжирна.

Дуудлага худалдааг цахимаар мөн явуулах зохицуулалт, дэд бүтцийг шийдэж, дуудлага худалдааны зарлалыг олон нийтэд зарын сувгаар далаацтай тараадаг болгох.

Эд хөрөнгийн мэдүүлэг ба төлбөртэй этгээдийн бүртгэлийн талаар:

Эд хөрөнгийн мэдүүлэг ажиллагаа эхлэхэд л заавал авдаг болгох, өгөөгүй, эсхүл худал өгсөн бол хариуцлага оногдуулдаг болгох.

Эд хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй бол, эсхүл бүр анх ажиллагаа эхлэхэд шууд төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулдаг болгох.

Төлбөртэй этгээдийн бүртгэл тухайн төлбөр төлөгчөөс бусад тэдэнтэй гэрээ байгуулах эсэхээ шийдэх этгээдэд нээлттэй, эсхүл олон нийтэд нээлттэй байдлаар цахимд байршуулдаг болгох, ингэснээр төлбөр төлөгч бүртгэлээс гарахын тулд төлбөрөө төлөх гэж чармайх хөшүүрэг үүснэ.

Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэнээс үүсэх үр дагавар буюу хязгаарлалтуудыг бий болгож, төлбөр төлөгч бүртгэлээс гарахын тулд төлбөрөө төлөхөд хөшүүрэгдэх.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлагын тухайд:

Одоогийн Эрүү, зөрчлийн хуульд зааснаар төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэхийн тулд цагдаа, прокуророор дамжин шүүхээр шийдвэрлүүлдэг зохицуулалт хариуцлага хүлээлгэлтийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж чадахгүйд хүргэж байх тул бусад улсын жишгээр шүүх албадлагын үе шатанд саад учруулсан төлбөр төлөгчид шууд шийтгэл оногдуулах хариуцлагын зохицуулалтыг бий болгох.

Цалин, урамшууллын тухайд:

Шийдвэр гүйцэтгэгч цэргийн цолтой байхаас илүү энгийн төрийн алба хаагч байх, гэхдээ цалин хөлс нь одоогийнхоос буурах тул урамшууллаар зөрүүг хангалттай хэмжээнд нөхөж чадна.

Урамшуулал, бонусыг зардлын 15-20 хувиар тооцож шийдвэр гүйцэтгэгчид өгдөг байх. Зардлыг ажиллагаанд гарах бодит зардлаас гадна шийдвэр гүйцэтгэгчид өгөх бонусыг тооцсон байдлаар ажиллагаа бүрээр тогтоох боломжтой.

Гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүнгээс ялгамжтай хэмжээгээр урамшуулал тогтооход бага үнийн дүнтэй гүйцэтгэх хуудасны биелэлт тааруу байсан тул өмнөх урамшууллыг сэргээхэд болгоомж хэрэгтэй.

Тогтолцоо, бүтцийн хувьд:

Иргэний шийдвэр гүйцэтгэлийн албыг цэргийн байгууллагаас салангид тусдаа агентлаг болгох, Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу үүнийг гүйцэтгэх.

Сургалтын тухайд:

Сургалтыг иргэний шийдвэр гүйцэтгэлээр мэргэшүүлэхэд чиглэсэн бүтэц, агуулгатай байхаар боловсруулах, дадлага олгох хугацааг хангалттай бий болгох, насан туршын давтан сургалтын агуулгыг мөн тогтоох шаардлагатай байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүргийн тухайд

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн явуулах ажиллагаа, тухайлбал, хэрэг нээх, хаах, гүйцэтгэх баримт бичиг буцаах, шийдвэр гүйцэтгэлийн гомдлыг хянан шийдвэрлэх, ажиллагааг түдгэлзүүлэх, орон байранд нэвтрэх эрх олгох, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэгчийн саналыг ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид уламжилж шийдвэрлүүлэх зэрэг нь нэгдүгээрт, шийдвэр гүйцэтгэгч өөрөө мөн цахимжилтаар хийх боломжтой, мөн хурд нэмэгдэнэ, хоёрт, ийм шат дамжлага нь хугацаа авч тэр хэмжээгээр удаашралыг бий болгож байх тул ахлах шийдвэр гүйцэтгэгчийн статус, үйл ажиллагааг байхгүй болговол зүйтэй.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэгчийн тоог дахин нэмэхээс илүү шийдвэр гүйцэтгэгчид туслах арын захиргааны алба, ложистик, зохион байгуулалтын алба, алба хаагчдыг бий болгох нь ажиллагааны үр дүнд эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

Бусад асуудлаар

Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн асуудлаар

Захиргааны шийдвэр гүйцэтгэлийг иргэний шийдвэр гүйцэтгэгч зөвхөн мөнгөн хөрөнгө гаргуулах, тодорхой үйлдэл хийлгүүлэх тухайд гүйцэтгэх, бусад акт хүчингүй болгох, илт хууль бусад тооцох, түдгэлзүүлэх зэргийг ЗХШ өөрөө шийддэг байх.

Ажиллагаатай захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй холбоотой гүйцэтгэх баримт бичгийн харьяаллыг үзвэл, нийт 231 гүйцэтгэх хуудас байгаагаас нийслэлийн ЧД, ХУД, СХД, БЗД гэхчилэн төрийн байгууллага ихээр байршсан дүүргүүдэд 160, Орхон аймагт 10, Говь-Алтайд 8, Дарханд 7, Өвөрхангайд 1 гэхчилэн орон нутагт 71 гүйцэтгэх хуудас нийтдээ байна.¹³⁷

Захиргааны шийдвэр гүйцэтгэл нь иргэний шийдвэр гүйцэтгэлээс тусдаа бөгөөд хэрэв мөнгөн дүнгийн нэхэмжлэл, тодорхой үйлдэл хийлгэх, хийлгүүлэхгүй байх нэхэмжлэл бол иргэний шийдвэр гүйцэтгэлээр харин захиргааны актыг хүчингүй болгох, илт хууль бусад тооцох, даалгах, түдгэлзүүлэх зэргийг захиргааны шүүхээс шийдвэр гаргаснаар, биелүүлээгүй тохиолдолд хэрхэх хөшүүргүүдтэйгээр шийдвэр гүйцэтгэгчийн оролцоогүйгээр шийдвэрлэдэг.¹³⁸

Бусад улс гэхэд Захиргаа, иргэний шийдвэр гүйцэтгэлийг тус тусын хуулиар зохицуулдаг бөгөөд захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хууль гэж байдаггүй.¹³⁹ Үүнд дараах 6 улсыг ЕСБХБ-ны харьцуулсан судалгаагаар харуулжээ.

Улс	Иргэний шийдвэр гүйцэтгэлийн бие даасан хууль	Захиргааны шийдвэр гүйцэтгэлийг зохицуулсан хууль тогтоомж
Сингапур	Order 22 Enforcement of judgments and orders ¹⁴⁰	Тусгайлсан хууль байхгүй. Төрийн байгууллагуудын үл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж
Норвеги	Enforcement Act (Lov om tvangsfullbyrdelse) ¹⁴¹	Public Administration Act (Forvaltningsloven)
Эстони	Code of Enforcement Procedure	Administrative Procedure Act
БНСУ	Civil Execution Act	Administrative Litigation Act, Administrative Appeals Act
Япон	Civil Execution Act	Administrative Case Litigation Act
Швед	Enforcement Code (Utsökningsbalken)	Administrative Procedure Act

Эх сурвалж: ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

Ёс зүйн асуудлаар

¹³⁷ ШШГЕГ-ын мэдээллээс 2025.02.27

¹³⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

¹³⁹ ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

¹⁴⁰ [https://sso.agc.gov.sg/SL-Supp/S914-](https://sso.agc.gov.sg/SL-Supp/S914-2021/Published/20211201?DocDate=20211201&ViewType=Within&Phrase=enforcement)

[2021/Published/20211201?DocDate=20211201&ViewType=Within&Phrase=enforcement](https://sso.agc.gov.sg/SL-Supp/S914-2021/Published/20211201?DocDate=20211201&ViewType=Within&Phrase=enforcement)

¹⁴¹ https://lovdata.no/dokument/NL/lov/1992-06-26-86/KAPITTEL_2-10-1#%C2%A713-3

Шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн асуудлыг төрийн албан хаагчийн ёс зүйн журмаар ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапурт зохицуулж байхад Эстонид шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн журмаар зохицуулсан байна.¹⁴²

Европын холбоо даяар шийдвэр гүйцэтгэгчийн ажлын чанарыг тогтмол хянадаг байна. Европын холбооны ихэнх улсууд олон улсын стандартад нийцсэн тусгай шийдвэр гүйцэтгэлийн чанарын стандартыг баталсан байдаг байна.¹⁴³

Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг тогтмол хянахдаа талуудын эрхийг хүндэтгэж буй эсэх, шийдвэр гүйцэтгэгчийн гүйцэтгэл, албадлагын арга хэмжээ үр дүнтэй байж чадах байгаа эсэх, шийдвэр гүйцэтгэлийн ачаалал болон зардал хамаардаг. Мөн процедурыг хянахдаа хэдэн хэрэг, хэдэн хэрэг түдгэлзсэн, хэдэн хэрэг гүйцэтгэгдсэн, гүйцэтгэхэд зарцуулсан хугацаа, ажиллагааны зардлыг хэрхэн гаргасан, нийт шийдвэрлэгдсэн хэрэгт холбогдуулан гаргасан гомдол болон хохирол барагдуулсан тоо зэргийг хянана. Үүнийг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлэх, тухайлбал мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэхийг зөвлөдөг байна. Харин хянах процедурыг нь тодорхой хуульчлах шаардлагатай байна. Шийдвэр гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг үнэлэхдээ ажилд нь саад болохгүйгээр шалгах арга хэмжээ авах нь зүйтэй байна. Үнэлгээг олон нийтэд нээлттэй байршуулдаг байна.

Ёс зүйн асуудлыг хараат бус байгууллагаар хянуулах нь зохимжтой байна. Харин хэргийг санаатайгаар удаашруулах тактикаар гаргах гомдлыг урьдчилан ялгах тогтолцоог бий болгох нь зүйтэй байдаг байна. Ийнхүү мэргэжлийн болон ёс зүйн асуудлыг хянасны үндсэн дээр сахилгын шийтгэл оногдуулдаг байна.

Мөн ёс зүй, мэргэжлийн дүрэм, шийдвэр гүйцэтгэлийн зорилго, зарчим, үе шат, ямар тохиолдолд ямар хөрөнгөд аль төрлийн албадлагын арга хэмжээг авах нь зохистой, олон улсын, бусад улсын гүйцэтгэх хуудасны талаар байнгын сургалтыг шийдвэр гүйцэтгэгч нарт зохион байгуулах шаардлагатай байна. Эдгээр сургалтууд нь заавал гүйцэтгэх үүрэг нь байхыг зөвлөдөг байна.

Монгол Улсын хувьд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 тоот тушаалаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагийн сахилга, ёс зүйн дүрмийг баталсан. Уг журамд цэргийн дүрэмт хувцасыг зохих журмын дагуу өмсөх, дүрэмт хувцастай архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх, хариу мэдэгдэх зэрэг ёс зүйн хэм хэмжээг зөрчвөл сахилгын шийтгэлийг ШШГЕГ-ын хяналт шалгалтын нэгж, эсхүл Сахилга ёс зүйн хороо оногдуулна. Сахилга, ёс зүйн хорооны дарга нь ШШГЕГ-ын Тэргүүн дэд дарга байх бөгөөд алба, нэгжийн дарга нараас бүрдэхээр байна. Сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд ШШГЕГ, алба, салбар нэгжийн дарга нар өдөр тутам хяналт тавьж ажиллахаар журамд заажээ.

Эндээс үзвэл, сахилга, ёс зүйн дүрмийн агуулга, мөн ёс зүйн зөрчлийг шалгах тогтолцоо нь шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагууд байх тул хараат бусаар ёс зүйн зөрчлийг шалгах нь эргэлзээтэй. Мөн ШШГЕГ-ын мэдээллээс үзэхэд, ёс зүйн зөрчил оногдуулсан тохиолдол нэн ховор байна.

¹⁴² ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

¹⁴³ <https://rm.coe.int/cepej-guidelines/16809f007a> Шүүх засаглалын үр нөлөөтэй байдлын Европын комиссын удирдамж Guidelines of European commission of judicial efficiency.

Хугацаа хэтрүүлсний хүүгийн асуудлаар

Төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүйн хүү, торгууль, алдангийг ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапур, Эстонид төлбөр төлөгчид оногдуулдаг байна. Гэрээгээр зохицуулаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэгчдэд ийнхүү төлбөр төлөгчөөс хугацаандаа төлөөгүйгийн хүү, алданги, торгуулийг авах эрхийг олгосон байдаг.¹⁴⁴

Манай улсад ийм хүү шийдвэр гүйцэтгэлийн шатанд бодоггүй бөгөөд бий болговол төлөх ёстой төлбөр төлөхгүй удах тусам нэмэгдэх үр дагавартай гэсэн ойлголт, хөшүүрэг бүрдэж, төлөлтөд эерэгээр нөлөөлнө.

Хөөн хэлэлцэх хугацааны асуудлаар

Хуулийн 18 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа нэлээд богино богино буюу 2-4 жил байхаар заасан байна.¹⁴⁵

Үүнээс гадна хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо нэлээн төвөгтэй байна. Хэдийгээр ажиллагаа үүсгэх хугацаа богино байгаа ч төлбөр авагч нь шүүхээс хугацааг дахин гурван жилээр сунгах хүсэлт гаргах эрхтэй (18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт). Хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийд нь сунгаснаар энэ шаардлагагүй хүнд суртлын тогтолцооноос зайлсхийх боломжтой. Жишээлбэл, Нидерландад хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа (Иргэний хуулийн 3:324-т) 20 жил байдаг (Австри, Люксембург: 30 жил). Хугацааг сайтар хэлэлцэж, хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийд нь сунгах саналыг гаргаж байна.¹⁴⁶ Хөөн хэлэлцэх хугацааны хувьд энэтхэгт гэхэд 12 жил байна.¹⁴⁷

Хувийн шийдвэр гүйцэтгэлийн талаар

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг хуульчлан, холимог тогтолцоог турших боломжийг нээх, ингэхдээ бэлтгэл ажлыг сайтар хангах үүднээс дагаж мөрдөх хугацааг 5 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах.

---o0o---

СУДАЛГААНЫ ХАВСРАЛТ 1

статистик 1

¹⁴⁴ ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

¹⁴⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйл.

¹⁴⁶ ЕСБХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

¹⁴⁷ <https://cdnbbsr.s3waas.gov.in/s3ec030655f117444fc1911ab9c6f6b013/uploads/2024/06/2024062630.pdf>

АХЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА											
№.	Үзүүлэлт		2022			2023			2024		
			Ахлах шийдвэр	Тухайн нэгжийн даргад	Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргасан.	Ахлах шийдвэр	Тухайн нэгжийн даргад	Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргасан.	Ахлах шийдвэр	Тухайн нэгжийн даргад	Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид гаргасан.
1	Нийт гаргасан өргөдөл, гомдол		513	1782	1001	1103	1245	1235	699	991	1126
	Агуулга	ШГА удаашрилтай	280	686	547	462	525	674	335	578	532
		ШГА хууль бус явагдсан	85	369	139	88	178	140	93	129	120
		Ёс зүйтэй	36	290	13	29	33	27	30	39	27
		Бусад	114	443	302	526	511	390	236	278	447
5	Үндэслэлтэй		244	1011	778	478	598	887	288	497	733
6	Үндэслэлгүй		246	774	223	554	644	348	359	469	393
7	Өргөдөл, гомдол гаргагч	төлбөр төлөгчийн тоо	179	385	197	410	342	237	283	342	338
		төлбөр авагчийн тоо	324	1198	286	574	818	896	334	487	697
		гуравдагч этгээдийн тоо	54	216	81	114	91	97	69	98	91
8	Шийдвэрлэсэн байдал	Бүрэн шийдвэрлэсэн	360	1194	530	639	863	744	297	650	573
		Боломжгүй хариу өгсөн	118	431	354	399	289	372	260	251	429
		Бусад	36	189	117	82	98	119	36	70	124

№	Үзүүлэлт		2023 он	2024 он
1	Нэхэмжлэл гаргагч	төлбөр төлөгчийн тоо	425	444
		төлбөр авагчийн тоо	33	33
		гуравдагч этгээдийн тоо	88	98
2	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчингүйд тооцсон		25	37
	Шийдвэрлэсэн байдал /тоон үзүүлэлтээр тавих/ үүнээс	албадан дуудлага худалдаа хүчингүйд тооцсон	10	8
		эд хөрөнгө битүүмжилсэн, хураасан ажиллагаа хүчингүйд тооцсон	1	3
		эд хөрөнгө төлбөрт санал болгох ажиллагаа хүчингүйд тооцсон	8	20
		хохирол, төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн	3	0
		бусад ШГА	3	6
		Үнэлгээ хүчингүйд тооцсон	3	6
		нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	274	290
		нэхэмжлэлийг буцаасан	39	31
		нэхэмжлэл шийдвэрлэгдээгүй хянагдаж байгаа	177	193

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

статистик 3

2024 оны шийдвэртэй гүйцэтгэх ажиллагааны биелэлт

Д.д	Төрөл		Шүүхээс ирсэн	2024 оны 12 дугаар сар			
				Биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудас	Биелүүлсэн гүйцэтгэх хуудас	Үлдэгдэл гүйцэтгэх хуудас	Бодит биелэлтийн хувь
	Төлбөрийн гүйцэтгэх хуудас	г/х	37879	56920	30301	26619	53.2
		м/дүн	1,462,268,468.3	3,486,012,933.9	1,102,875,341.9	2,383,137,592.0	31.6
Үүнээс	Иргэний хэргийн шийдвэртэй	г/х	19182	33879	18234	15645	53.8
		м/дүн	1,208,613,919.0	2,535,940,516.0	754,325,434.4	1,781,615,081.6	29.7
	Эрүүгийн хэргийн шийдвэртэй	г/х	6879	9267	5003	4264	54.0
		м/дүн	188,686,204.8	321,517,691.6	31,014,805.4	290,502,886.2	9.6
	Захиргааны хэргийн шийдвэртэй	г/х	225	436	231	205	53.0
		м/дүн	1,039,871.9	7,586,094.8	903,583.1	6,682,511.7	11.9
	Зөрчлийн хэргийн шийдвэртэй	г/х	10397	10883	5710	5173	52.5
		м/дүн	8,217,396.6	15,985,995.3	4,386,461.9	11,599,533.4	27.4
Зөрчлийн хэргийн шийдвэртэй	Торгох шийтгэл ногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас	г/х	373	375	352	23	93
		м/дүн	1,064,740.0	1,077,860.0	113,721.5	964138.487	10.6
	Хохирол нөхөн төлбөр гаргуулах	г/х	90	129	81	48	63
		м/дүн	740,082.5	3,790,145.8	977,213.8	2,812,932.0	25.8
	Эрх хасах шийтгэл	г/х	4773	4774	34	4740	0.7
		м/дүн	61,740.0	61,340.0	13,953.2	47,386.8	22.7
	Шүүхээр баталгаажуулсан эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудас	г/х	4867	5298	4984	314	94
		м/дүн	6,294,407.2	10,977,340.6	3,226,065.2	7,751,275.4	29.4
	Бусад	г/х	294	307	259	48	84.3
		м/дүн	56,426.9	79,308.9	55,508.1	23,800.8	87.9
	Бусад хэргийн шийдвэртэй	г/х	1196	2455	1123	1332	45.7
		м/дүн	55,711,076.0	604,982,600.4	312,245,057.2	292,737,543.2	51.6
Бусад хэргийн шийдвэртэй	Монгол улсын арбитрын шийдвэртэй	г/х	68	155	61	94	39
		м/дүн	6,853,480.4	34,153,522.5	5,396,978.4	28,756,544.1	15.8
	Нотариатын мэдэгдэх хуудас	г/х	79.0	137.0	62.0	75.0	45.3
		м/дүн	9,213,644.9	12,875,933.7	5,012,654.3	7,863,279.5	38.9
	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар гэрээг баталгаажуулсан	г/х	1038	2112	981	1131	46
		м/дүн	36,392,529.5	85,303,617.6	29,565,582.5	55,738,035.2	57.6
	Бусад	г/х	11	51	19	32	60
		м/дүн	3,251,421.2	472,649,526.5	272,269,842.0	200,379,684.5	53.9

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

статистик 4

Арбитрын шийдвэртэй гүйцэтгэх ажиллагааны биелэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ		шүүхээс ирсэн	Арбитрын шийдвэртэй			
				Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	хувь
1	2014 он	г/х	15	20	5	15	25.0
		мөн.дүн /мян.төг/	321,752,233.1	151,278,419.3	55,315,114.6	95,963,304.7	36.6
2	2015 он	г/х	13	33	7	26	21.2
		мөн.дүн /мян.төг/	4,364,601.8	42,720,491.1	26,229,491.3	16,490,999.8	61.4
3	2016 он	г/х	31	49	5	44	10.2
		мөн.дүн /мян.төг/	122,973,336.2	130,969,035.7	270,581.9	130,698,453.8	0.2
4	2017 он	г/х	52	90	17	73	18.9
		мөн.дүн /мян.төг/	125,502,966.9	249,984,552.2	1,418,019.8	248,566,532.4	0.6
5	2018 он	г/х	43	108	32	76	29.6
		мөн.дүн /мян.төг/	103,647,554.2	412,413,596.2	216,324,146.2	196,089,450.0	52.5
6	2019 он	г/х	46	123	29	94	23.6
		мөн.дүн /мян.төг/	8,362,504.3	203,212,209.5	5,403,862.0	197,808,347.5	2.7
7	2020 он	г/х	56	139	39	100	28.1
		мөн.дүн /мян.төг/	36,665,764.9	219,278,651.2	22,890,930.3	196,387,720.9	10.4
8	2021 он	г/х	55	147	42	105	28.6
		мөн.дүн /мян.төг/	15,355,441.3	168,460,497.8	14,155,669.8	154,304,828.0	8.4
9	2022 он	г/х	63	121	13	108	10.7
		мөн.дүн /мян.төг/	117,216,424.9	257,376,142.6	508,887.2	256,867,255.4	0.2
10	2023 он	г/х	73	167	50	117	29.9
		мөн.дүн /мян.төг/	298,617,092.3	639,861,577.1	45,864,153.8	593,997,423.3	7.2
11	2024 он	г/х	19	140	19	121	13.6
		мөн.дүн /мян.төг/	4,446,622.8	598,555,049.1	120,403,598.5	478,151,450.6	20.1

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

статистик 5

Урамшуулалгүй үеийн /2017-2024/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт

Д/д	Үзүүлэлт		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
1.	2002 он	г/х	70030	14767	55263	21.1
		м/д	84,300,000.0	15,700,000.0	68,600,000.0	18.6
2.	2003 он	г/х	34200	16380	17820	47.9
		м/д	49,000,000.0	32,100,000.0	16,900,000.0	65.5
3.	2004 он	г/х	26769	12489	14280	46.7
		м/д	47,100,000.0	31,500,000.0	15,600,000.0	66.9
4.	2005 он	г/х	22820	12022	10798	52.7
		м/д	32,053,955.0	21,548,633.0	10,505,322.0	67.2
5.	2006 он	г/х	19134	11401	7733	59.6
		м/д	38,561,321.0	28,110,811.7	10,450,509.3	72.9
6.	2007 он	г/х	19855	12581	7274	63.4
		м/д	35,823,965.9	26,128,382.7	9,695,583.2	72.9
7.	2008 он	г/х	19864	13574	6290	68.3
		м/д	48,044,130.0	37,761,355.1	10,282,774.9	78.6
8.	2009 он	г/х	21658	14243	7415	65.8
		м/д	56,754,075.8	43,095,013.1	13,659,062.7	75.9
9.	2010 он	г/х	25288	15411	9877	60.9
		м/д	193,425,616.7	83,104,929.1	110,320,687.6	43.0
10.	2011 он	г/х	22155	14292	7863	64.5
		м/д	189,173,860.5	83,573,636.3	105,600,224.2	44.2
11.	2012 он	г/х	22050	14545	7505	66.0
		м/д	223,754,936.2	89,806,577.2	133,948,359.0	40.1
12.	2013 он	г/х	23839	16077	7762	67.4
		м/д	823,732,110.8	507,487,040.5	316,245,070.3	61.6
13.	2014 он	г/х	19507	13068	6439	67.0
		м/д	840,536,988.6	333,061,612.9	507,475,375.7	39.6
14.	2015 он	г/х	30839	16347	14492	53.0
		м/д	848,973,885.2	168,230,853.0	680,743,032.2	19.8
15.	2016 он	г/х	35908	17721	18187	49.4
		м/д	1,218,647,885.5	149,670,798.7	1,068,977,086.8	12.3

ДУНДАЖ ДҮН	413916	214918	198998	52
	4,729,882,726.0	1,650,879,641.4	3,079,003,084.6	35

статистик 6

Урамшуулалтай үеийн /2017-2024/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт

Д/д	Үзүүлэлт		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэл хувь
1.	2017 он	г/х	39405	19648	19757	49.9
		м/д	1,448,379,834.0	294,940,057.2	1,153,439,776.8	20.4
2.	2018 он	г/х	38579	20054	18525	52.0
		м/д	1,848,896,314.6	504,376,269.1	1,344,520,045.6	27.3
3.	2019 он	г/х	40999	21191	19808	51.7
		м/д	1,908,853,931.1	303,480,377.5	1,605,373,553.6	15.9
4.	2020 он	г/х	39342	20323	19019	51.7
		м/д	1,908,853,931.1	381,300,000.0	1,527,553,931.1	20.0
5.	2021 он	г/х	36321	19693	16628	54.2
		м/д	1,908,853,931.1	339,000,000.0	1,569,853,931.1	17.8
6.	2022 он	г/х	44731	24406	20325	54.6
		м/д	2,643,470,326	788,362,945.4	1,855,107,380.6	29.8
7.	2023 он	г/х	52956	30835	22121	58.2
		м/д	1,373,084,082.814	646,617,641.647	646,617,641.647	21.4
8.	2024 он	г/х	56920	30301	26619	53.2
		м/д	3,486,012,933.9	1,102,875,341.9	2,383,137,592.0	31.6
Дундаж дүн			349,253	183,451	165,802	52.5
			16,526,405,284.6	4,360,952,630	12,165,452,654.6	26.3

статистик 7

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/23 тоот тушаалын хавсралт

Д/д	Харьяа газар, хэлтсийн нэр		Тойргийн тоо
1	Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		5
2	Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		5
3	Булган аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		5
4	Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		6
5	Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		5
6	Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих		3
7	Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		5
8	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь ШШГХ		5
9	Дорнод ШШГГ		7
10	Дундговь аймаг дахь ШШГГ		4
11	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1-р тасаг	5
		2-р тасаг	5
12	Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		4
13	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь ШШГХ		2
14	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1-р тасаг	5
		2-р тасаг	6
15	Өвөрхангай аймаг дахь ШШГГ		5
16	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ		3
17	Өмнөговь аймаг дахь ШШГГ		5
18	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГХ		2
19	Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		6
20	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШШГХ		2
21	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГХ		5
22	Сүхбаатар аймаг дахь ШШГГ		4
23	Төв аймаг дахь ШШГГ		7
24	Увс аймаг дахь ШШГГ		5
25	Ховд аймаг дахь ШШГГ		6
26	Хөвсгөл аймаг дахь ШШГГ		8
27	Хэнтий аймаг дахь ШШГГ		7
28	Налайх, Багахангай дүүрэг дэх ШШГХ		5
29	Багануур дүүрэг дэх ШШГХ		4
30	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Чингэлтэй дүүрэг	12
		СХД 1-р хэлтэс	8
		СХД 2-р хэлтэс	7
		СХД 3-р хэлтэс	7
		Хан-Уул 1-р хэлтэс	9
		Хан-Уул 2-р хэлтэс	9
		Баянгол 1-р хэлтэс	10
		Баянгол 2-р хэлтэс	9
		Сүхбаатар 1-р хэлтэс	8
		Сүхбаатар 2-р хэлтэс	9
		Баянзүрх 1-р хэлтэс	9
		Баянзүрх 2-р хэлтэс	9
		Баянзүрх 3-р хэлтэс	8
31	Банкны төлбөр барагдуулах газар	Сүхбаатар дүүрэг	4
		Баянгол дүүрэг	6
		Сонгинохайрхан дүүрэг	8
		Баянзүрх дүүрэг	9
		Хан-Уул дүүрэг	7
		Чингэлтэй дүүрэг	5
НИЙТ			304

статистик 8

2023, 2024 ОНЫ БАЙДЛААР ШҮҮХЭД ХАРИУЦАГЧААР ОРОЛЦСОН СУДАЛГАА							
						2025.02.26	
№	Огноо	Үзүүлэлт	Нийт шүүхэд хариуцагчаар оролцсон тоо	Хугацаа			Үнэлгээнд гаргасан нэхэмжлэл
				0-1 жил	1-3 жил	3 жил түүнээс дээш	
1	2023	тоо	546	374	155	17	362
2	2024	тоо	486	312	149	25	377
НИЙТ ДҮН			1032	686	304	42	739

статистик 9

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГҮҮЛЭХЭЭР ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН

2025.02.18

ДД	Огноо	ЦАБ-д хандсан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэх						
			хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаа	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн боловч татгалзсан /дээд шатны про-т гомдол гаргасан эсэх/	Эрүүгийн хэрэг нээн шалгаж байгаа	Эрүүгийн хэрэг нээсэн боловч татгалзсан /дээд шатны про-т гомдол гаргасан эсэх/	шалгаж шүүх рүү шилжүүлсэн	ЦБ шалгах явцад төлбөр төлөгдсөн Шалгаж байгаа

№	Албан тушаалын төрөл	Алба хаагчдын тоо	Эзлэх хувь
1.	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	56	12.0%
2.	Шийдвэр гүйцэтгэгч	304	62.4%
3.	Захиргаа, мэргэжлийн удирдлага-хяналт тавих	26	6.7%
4.	Санхүү, үйлчилгээ	42	10.8%
5.	Тоо бүртгэл, лавлагаа, мэдээлэл	17	4.3%
6.	Харуул, хамгаалалт	6	1.5%
7.	Эрэн сурвалжлах	9	2.3%
Нийт дүн		460	100%

1	2022	48	13		33		1	1		
2	2023	90	82		5		2		1	
3	2024	61	6	0	1	0	1	0	4	49

АХЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭСЭН СУДАЛГАА /2023,2024/

2025.02.18

№	Огноо	Гомдол, мэлээлэл хүлээн авсан тоо	Үүнээс		15.2 дугаар зүйл		15.27 дугаар зүйл		6.20 дугаар зүйл			Прокурорын шаардлага хүлээн авсан
			татгалзсан	хэрэгсэхгүй болгосон	шалгасан	шийтгэл оногдуулсан	шалгасан	шийтгэл оногдуулсан	торгох шийтгэл оногдуулсан		баривчлах шийтгэл оногдуулсан	
					тоо	мөн.дүн	тоо	мөн.дүн	тоо	мөн.дүн	тоо	тоо
1	2023	76	7	7	16	10,700.0	8	4,150.0	14	1,400.0	24	15
2	2024	103	4	3	28	9,200.0	5	6,200.0	24	2,400.0	34	13
НИЙТ		179	11	10	44	19,900.0	13	10,350.0	38	3,800.0	58	28

статистик 10

Одоо байгаа алба хаагчдын тоо, албан тушаал

СУДАЛГААНЫ ХАВСРАЛТ 2

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА БОЛОН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.Битүүмжлэх тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл бүхий хэргийн шийдвэр

1.1.2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Дугаар 102ШШ202200313

Нэхэмжлэгч Ү (өмчлөгч)

Хариуцагч ШШГЕГ-ын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын алба

Нэхэмжлэлийн шаардлага

2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн эд хөрөнгө битүүмжлэх тухай тогтоолыг хүчингүй болгож, битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалтаас чөлөөлүүлэх тухай

Хэргийн талаар

БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн шүүхийн шийдвэрээр Э ХХК-иас 501,830,358 төгрөгийг гаргуулж К банкинд олгохоор шийдвэрлэжээ. Барьцаа хөрөнгө болох Ү-ийн өмчлөлийн эд хөрөнгөөс гаргуулах шийдвэртэй.

2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн.

Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр түдгэлзүүлсэн. 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр эд хөрөнгийг битүүмжлэх тогтоол гарсан.

Жич: 2017 оны 4 дүгээр сарын 10-нд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэснээс хойш 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр барьцаанд байгаа ҮХЭХ-ийг битүүмжилсэн буюу ажиллагаа эхэлснээс хойш 2 жил 9 сарын дараа барьцаанд байгаа ҮХЭХ-ийг битүүмжилжээ.

Нэхэмжлэгчийн тайлбар

Э ХХК-ийн үүргийн гүйцэтгэлд барьцаалуулсан эд хөрөнгө нь иргэн Ү миний өмч бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 14.1, 14.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу эд хөрөнгө битүүмжлэх тухай тогтоол гаргахдаа мэдэгдээгүй, байлцуулаагүй тул тус тогтоолыг хүчингүй болгож өгөх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт

14.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, ялтан, бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, тайлбар авах, холбогдох баримт бичиг гаргуулан авах, эсхүл гаргасан шийдвэр болон түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар танилцуулна.

14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас гадна төлбөр төлөхийг шаардах, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг төлбөр төлөгч, төлбөр авагч, ялтан, бусад этгээдэд даалгах, цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх тухай хугацаатай мэдэгдэх хуудас өгнө.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Нэхэмжлэгч Ү нь тухайн хөрөнгийн өмчлөгч тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогч буюу бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд болох ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу шийдвэр гүйцэтгэгч өөрийг нь мэдэгдэх хуудсаар дуудах, тайлбар авах, төлбөр төлөх талаар хугацаатай мэдэгдэл өгөх ажиллагаа явуулалгүйгээр түүний өмчлөлийн хөрөнгийг битүүмжилсэн нь уг ажиллагаа хуульд заасан журмын дагуу явуулаагүй гэх үндэслэлээр мэтгэлцсэн ч шийдвэр гүйцэтгэгч нь барьцаа хөрөнгө болох ҮХЭХ-ийг битүүмжлэх арга хэмжээ авахад дээрх хуульд заасан мэдэгдэл хүргүүлэх зохицуулалт хамаарахгүй байх тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүхээс дүгнэсэн.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2.8 дахь заалтад заасан албадлагын арга хэмжээг авахдаа өмлөгчид мэдэгдэх үүрэг хүлээгээгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт

44.2.8.гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;

2.2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 00594 тоот Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Нэхэмжлэгч Ү
Хариуцагч шийдвэр гүйцэтгэгч С

Нэхэмжлэлийн шаардлага

2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн эд хөрөнгө битүүмжлэх тухай тогтоолыг хүчингүй болгож, битүүмжилсэн эд хөрөнгийн жагсаалтаас чөлөөлүүлэх тухай

Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлын агуулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож болно гэж, мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт төлбөр гаргуулахаар хураагдсан хөрөнгийн өмчлөх эрхтэй холбогдсон маргаан үүссэн тохиолдолд холбогдох

хүн, хуулийн этгээд тухайн эд хөрөнгийг битүүмжлэх эд хөрөнгийн жагсаалтаас хасуулах, чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлээ шүүхэд гаргаж болно гэж заасан тул нэхэмжлэгч Ү нь ҮХЭХ-ийн өмчлөгч байх тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бөгөөд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болно.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, тайлбар авах ... мэдэгдэх хуудсыг дуудан ирүүлж гардуулах боломжгүй тохиолдолд биечлэн, эсхүл баталгаат шуудангаар хүргүүлнэ гэж заасан боловч өмчлөгчид мэдэгдээгүй.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Давж заалдах шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.” гэж зааснаар хэргийг гомдолд дурьдсан үндэслэлээр хязгаарлалгүй бүхэлд нь хянан үзэж, анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх хуулиар тогтоосон журмыг зөрчсөний улмаас шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй байх тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Учир нь шүүх нэхэмжлэлд дурьдсан НШШГШ-т холбогдуулан иргэний хэрэг үүсгэн, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байх ба хэрэгт авагдсан дээрх бичгийн баримтуудаас НШШГГ нь уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь тодорхой харагдаж байхад хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, шийдвэртээ БХЗХТБАА-ыг хариуцагч гэж тусгасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3, 28.4 дэх хэсэгт заасан хариуцагчийг солих журмыг ноцтой зөрчсөн байна.

Жич: 2022 оны 06 сард анхан шат хэргийг дахин хэлэлцэж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхисон байна. Одоогоор ҮХЭХ-ийг хураасан байна.

Өөрөөр хэлбэл, ажиллагааг 2017 оны 4 сарын 17-нд эхлүүлж 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр битүүмжлээд битүүмжилсэн тогтоолд өмчлөгч гомдол гарган 2022 оны 6 сард эцэслэн шийдвэрлэгджээ. Ийнхүү 5 жил болоход ҮХЭХ-ийг хураасан байдалтай байгаа буюу төлбөр авагчийн эрх ашиг ноцтой зөрчигдөж, үндэслэлгүй гомдол өмчлөгч гарган ажиллагаа удааширчээ.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Битүүмжлэхтэй холбогдуулан гаргасан төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн	Хураасан тогтоол
2016.11.03	2017.04.17	2021.01.21	2022.06 сар	2023.01 сар

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 44.3, 63.4-т заасан нь бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд өөрийн эрх хөндөгдсөн асуудлаар гомдлоо шүүхэд гаргахад хамаарахгүй.” гэж заасан. Үүний дагуу төлбөр төлөгч бус өмчлөгч буюу барьцаалаагуулагч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан тогтоол, шийдвэрт аль ч үе шатанд шүүхэд гомдол гаргаж ажиллагааг түдгэлзүүлэхэд хүргэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт

44.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.

63.4.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хөрөнгийг албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар энэ хуулийн 55.7-д заасны дагуу шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн бол тухайн асуудлаар хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад шүүхэд дахин гомдол гаргах эрхгүй.

- Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд нь төлбөр төлөгч бус өмчлөгч, барьцаалуулагч байх тохиолдолд хөрөнгийг битүүмжлэх, үнэлгээ хийлгэх, албадан дуудлага худалдаа явуулах гэхчилэн ажиллагааны талаар мэдэгдэх, хэзээ, хэрхэн гомдол, хүсэлт гаргах талаар тодорхой хуульччлах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, аль ч үе шатанд хэдэн ч удаа гомдол гаргах эрхтэй байхаар заасныг хязгаарлах, үндэслэл, хүрээ, хугацааг нь тодорхой болгох.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт

Түдгэлзүүлэх үндэслэл

27.2.5.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл;

27.1.2.төлбөрт хураагдсан хөрөнгийн талаар бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол;

27.1.4.гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөрт хураан авах хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол;

- Ажиллагаа тус бүрд мэдэгдэх эсэх, хэнд мэдэгдэх асуудлыг хуульчлах. Ингэхдээ барьцаатай бол, барьцаагүй бол хэрхэх гэдгээр ялгах. Өөрөөр хэлбэл, барьцаатай бол битүүмжлэх, хураах асуудал байхгүй шууд үнэлгээ хийлгэж, албадан дуудлага худалдаагаар худалддаг болох;

- Давж заалдах шатны шүүх хуульд заасны дагуу зөвхөн гомдолд дурьдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ. Тэгвэл энэ нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх процесс доторх эрхийг хэрэгжүүлж байгаатай, шуурхай ажиллагаатай хэр нийцэж байгаа эсэхийг нягтлах. БНСУ-ын хувьд гомдлын үндэслэлээ заавал заахыг гомдол гаргагчид үүрэг болгож, зөвхөн гомдлын үндэслэлийн хүрээнд гомдлыг хянадаг.

- Хариуцагч нь Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын алба яагаад биш талаар дүгнэлт байхгүй атлаа хариуцагчийг солих журам зөрчсөн тул анхан шатны шүүхэд хэргийг буцааж байна. Ингэхийн тулд 3-5 сарын хугацаа алдагдаж, ажиллагаа удаашран түдгэлзэж, төлбөр авагчийн эрх ноцтой зөрчигдөж байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дахь ердийн журмыг хэрэглэх нь онвчгүй байна.

2.Эд хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл бүхий хэргийн шийдвэр

1.2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 102Ш3202001774 тоот БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Б хамтран зээлдэгч

Хариуцагч НШШГГ

Хэргийн талаар

БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн шүүхийн шийдвэрээр иргэн Б, хамтран зээлдэгч Б-ээс 252,239,933 төгрөгийг гаргуулж Г ББСБ-д олгохоор шийдвэрлэжээ.

2019 оны 10 дугаар сарын 14-ний өдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн.

Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгийг 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг хийж,

мөн хураах ажиллагааг 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр тус тус явуулсан.

Үнэлгээний компаниар үнэлгээ хийлгэсэн бөгөөд ҮХЭХ-ийг 244,500,000 төгрөгөөр үнэлсэн байна. 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр талуудад үнэлгээний тайланг мэдэгдсэн байна.

Нэхэмжлэгчийн тайлбар

Хөрөнгийг хэт доогуур үнэлсэн.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Шинжээч ХХК нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлгээ хийх эрх бүхий этгээд байх бөгөөд үнэлгээг гаргахдаа хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Нэхэмжлэгчээс шинжээчийн тогтоосон үнийг зах зээлийн үнээс хэт доогуур байгаа гэж тайлбарлаж байгаа боловч үндэслэлээ баримтаар нотлоогүй, зах зээлд тухайн үл хөдлөх ямар үнээр худалдан борлогдож байгаа талаарх баримтыг шүүхэд гаргаагүй, шинжээчийн үнэлгээ тогтоосон аргачлалыг няцаагаагүй тул шинжээчийн тогтоосон үнэлгээг үгүйсгэх боломжгүй байна. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгов.

2.2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 102ШШ202100978 тоот БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Б үндсэн зээлдэгч

Хариуцагч НШШГГ

Хэргийн талаар

2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр манай эхнэр буюу хамтран зээлдэгч Б-д үнэлгээний талаар мэдэгдсэн. Манай эхнэр мэдэгдлийг хүлээн аваад шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Миний бие манай эхнэрт уг мэдэгдлийг өгснийг мэдээгүй байсан. Улмаар уг мэдэгдэлтэй холбогдуулан миний бие шүүхэд нэхэмжлэл гаргаж байна.

Нэхэмжлэгчийн тайлбар

Үндэслэл нь зах зээлийн ханшаас хэт доогуур үнэлсэн гэх.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Шинжээч уг ҮХЭХ-ийг үнэлэхдээ зах зээлийн хандлагын аргыг ашиглаж, үнэлснийг буруутгах, төлбөр төлөгчийн хөрөнгийг хэт багаар үнэлсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Энэхүү үнэлгээний тайланг шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т “Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг шинжээчээр тогтоолгосон бол шинжээчийн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, дүгнэлтийг танилцуулж, санал хүсэлтийг авч, тэмдэглэл хөтөлнө.” гэж заасан хугацаанд төлбөр төлөгч, төлбөр авагчид мэдэгдсэн байна. Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан байх тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх дүгнэлээ.

3.2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 1010 дугаар Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Нэхэмжлэгч Б үндсэн зээлдэгч

Хариуцагч НШШГГ

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр үнэлгээний талаар төлбөр төлөгч нарт мэдэгдсэн нотлох баримт байх тул үнэлгээний талаар мэдэгдээгүй гэх нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангах боломжгүй.

Нэхэмжлэгч Б үндсэн зээлдэгч үнэлгээний мэдэгдлийг 2020 оны 04 сарын 08-ны өдөр авсан мөрттлөө 2020 оны 10 сарын 09-ний өдөр шүүхэд гомдол гаргасан. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дахь хэсэгт “Талууд үнэлгээний талаарх гомдлоо энэ хуулийн 55.3-т заасны дагуу мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.” гэж заасан тул энэхүү хугацааг хэтрүүлсэн гэж үзнэ. Түүнчлэн хариуцагч НШШГГ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа хууль зөрчөөгүй, анхан шатны шүүх энэ талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 55.3, Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсэгт заасанд тус тус нийцжээ.

ҮХЭХ-ийг зах зээлийн ханшаас хэт доогуур үнэлсэн гэх боловч энэхүү тайлбараа баримтаар нотлох үүргээ хэрэгжүүлээгүй байна. Мөн шинжээч нь ҮХЭХ-ийг үнэлэхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан арга, аргалалын дагуу өртгийн болон зах зээлийн харьцуулан жиших аргыг хэрэглэсэн, уг үнэлгээ хуульд нийцээгүй гэх үндэслэл хэргийн баримтаар тогтоогдоогүй тул нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангах боломжгүй байна. Ийнхүү эдгээр үндэслэлээр давж заалдах гомдлыг хангахгүй орхив.

2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны тогтоол

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзсан.

Жич: 2022.01.04-ний өдөр анхны Албадан дуудлага худалдааг 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулахаар албадан дуудлага худалдаа явуулах тогтоол гаргаж мэдэгдсэн байна.

Нэг ч оролцогч ороогүй тул хоёр дахь дуудлага худалдааг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулахаар болсон байна. Ялагч тодорсон. 195 сая төгрөгөөр худалдан борлуулагдахаар болсон.

4.2022 оны 04 сарын 8-ны өдрийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Б хамтран зээлдэгч

Хариуцагч НШШГГ

Дахин үнэлгээ хийлгэх, дуудлага худалдаа зохион байгуулах тогтоолыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг хамтран зээлдэгч Б шүүхэд гаргаж 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ажиллагаа түдгэлзсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлага

Ийнхүү нэхэмжлэл гаргах болсон үндэслэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.5 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн буюу барьцаа хөрөнгийн үнэлгээ хийснээс хойш 1 жил 9 сар өнгөрсөн байна. Энэ хугацаанд ойролцоогоор 100 сая төгрөгөөр зах зээлийн ханш өсч үнийн дүнд өөрчлөлт орсон байна. Мөн шийдвэр гүйцэтгэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний албадан дуудлага худалдаа явуулах тухай тогтоолыг хүчингүй болгож өгнө үү гэсэн нэхэмжлэлийг гаргажээ.

2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр анхан шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Үнэлгээ тогтоосноос хойш 100 сая төгрөгөөр нэмэгдсэн гэж үзэн, энэхүү үндэслэлээ нотлохоор үнэгүй.мн сайтад тавигдсан цахим зарыг хуулбарлан хэрэгт нотлох баримтаар өгсөн байх боловч уг баримтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.4 дэх хэсэгт заасан нотлох баримтын шаардлага хангаагүйгээс гадна цахим баримтыг хуульд заасан журмаар бэхжүүлэн авах талаар хүсэлтийг гаргаагүй байна. Иймд үнэлгээ тогтоосноос хойш 100 сая төгрөгөөр хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Үнэлгээ дахин хийлгэх шаардлагагүй гэж шүүх үзсэн тул нэхэмжлэгчийн албадан дуудлага худалдаа явуулах тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлгүй гэж үзнэ.

5.2022 оны 7 сарын 8-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Мөн оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон байна.

6.2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрий Улсын дээд шүүхийн шийдвэр

Мөн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоолоор гомдлыг иргэний хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзсан байна.

Жич: Ийнхүү 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээсэн байна. 2023 оны 1 сарын 12-нд албадан чөлөөлсөн.

2019.10.14-ний өдөр ажиллагаа эхлүүлсэн ч шүүхэд үндэслэлгүй гомдлыг төлбөр төлөгч нар нэг нэгээрээ дарааллан гаргаж удаашруулан 2023 оны 1 сард ҮХЭХ-ийг албадан чөлөөлсөн буюу 3 жил 3 сарын хугацаагаар төлбөр авагч төлбөрөө авч чадахгүй хохирч, ялагч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байсан байна.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Үнэлгээтэй / дахин үнэлгээ тогтоолгохыг даалгах, албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгч тус бүрийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн	Хураасан тогтоол
2019.10.11	2019.10.14	2019.12.17	1.2021.10.01 2.2022.10.10	2020.03.24

ДҮГНЭЛТ

6 сараас дээш хугацааны дараа үнэ ханшид өөрчлөлт орсон гэж үзвэл дахин үнэлгээ хийлгэх гомдол гаргах, нотлох асуудлыг боловсронгуй болгох (хүсэлт гаргах), хүсэлтээс татгалзсан шийдвэрт гомдол гаргах гэхдээ тодорхой хугацаанд, үндэслэлийг тодорхойлж гаргах.

- Хэд хэдэн төлбөр төлөгч байгаа тохиолдолд нэг үнэлгээний асуудлаар нэг удаа л гомдол гаргах тухай зохицуулалт оруулах

- Үнэлгээний зорилго нь албадан дуудлага худалдаа болохоос өмнө тухайн хөрөнгийн үнийг үнэн зөвөөр шуурхай тогтоолгох тул шүүхээр үнэлгээ хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж удаашруулах бус Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хуулийн дагуу дахин, нэмэлт шинжилгээг шуурхай хийлгэх эрхийг хуульчлах, харин шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээчин, шинжээч томилсон шийдвэрт тодорхой хуульд заасан үндэслэлээр гомдол гаргах эрх нээлттэй байх. Учир нь ажиллагааны хувьд үнэлгээг хүчингүй болгохыг тогтоох, үүний дараа дахин үнэлгээ хийлгэх нь чухал бус дахин, нэмэлт үнэлгээ хийлгэх эрхийг шууд талуудын хүсэлтээр хэрэгжүүлдэг байх нь чухал бөгөөд талуудын зорилгод нийцнэ.

■ Ялагч 2022 оны 02 сарын 15-ны өдөр тодорсон байхад дахин үнэлгээний асуудлаар ялагч тодорсны дараа шүүхэд хандан, хамгийн сүүлд УДШ-ийн шийдвэр 2022 оны 10 сарын 10-нд гарчээ. Иймд дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гарсны дараа үнэлгээний асуудлаар гомдол гаргахгүй байхаар зохицуулах.

■ 2019 оны 10 сард ажиллагаа эхэлсэн бол 2023 оны 01 сард албадан чөлөөлсөн буюу 3 жил 3 сар шүүхэд хандаж ажиллагааг удаашруулсан байна. Иймд ялагч болон төлбөр авагчийн ашиг сонирхлыг удаан хугацаанд хохироосны хохирлыг төлбөр төлөгчөөр төлүүлэх эрх зүйн орчинг бий болгох.

3.Эд хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах тухай, анхны албадан дуудлага худалдаа явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгох тухай нэхэмжлэл бүхий иргэний хэргийн шийдвэр

1.2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Г үндсэн зээлдэгч

Хариуцагч НШШГГ

2016 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн гүйцэтгэх хуудас бүхий 2016 оны 06 сарын 08-ны өдөр битүүмжилж, 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хураан авсан ҮХЭХ-ийн үнэлгээг 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр шинжээч томилж, үнэлгээ тогтоолгосон байна. 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр төлбөр төлөгч нарт мэдэгдсэн байна. 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр анхны албадан дуудлага худалдаанд оруулахаар нийтэд зарласан боловч үнийн санал ирээгүй тул хоёр дахь албадан дуудлага худалдаанд 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хийж, хөрөнгө худалдан борлогдож иргэн 3 дуудлага худалдааны ялагчаар тодорсон. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55.7-д заасны дагуу төлбөр төлөгч эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргах хугацаа хэтэрсэн буюу 2017 оны 12 дугаар сарын 08-нд нэхэмжлэл гаргасан. Шүүх хүлээн авч, хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Хуульд заасан гомдол гаргах 7 хоногийн хугацааг хэтрүүлсэн тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болно.

2.2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1196 тоот Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл

Үнэлгээ тогтоосон үнэлгээний тайлан, үнэлгээ тогтоосон ажиллагаа нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлд нийцсэн байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55.7-д заасны дагуу төлбөр төлөгч эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргах хугацаа хэтэрсэн буюу 2017 оны 12 дугаар сарын 08-нд нэхэмжлэл гаргасан тул давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

3.2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Хоёр шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий болжээ. Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй байна.

4.2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн захирамж Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Нэхэмжлэгч 3 хамтран зээлдэгч

Хариуцагч НШШГГ

2022.05.24-ний өдөр 3 нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлийн шаардлага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.5 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээ хийгдсэнээс хойш 4 жил 5 сар өнгөрсөн тул ҮХЭХ-ийг дахин үнэлгээ тогтоолгохыг шийдвэр гүйцэтгэгчид даалгах, анхны албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах.

Шийдвэрийн үндэслэл

Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан байхад шүүх шүүх 2021 оны 5 сарын 30-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн байна.

Жич: Одоогоор ажиллагаа түдгэлзсэн байдалтай байна. Ялагч эд хөрөнгөө, төлбөр авагч төлбөрөө авч чадахгүй байдалтай байна. Ажиллагаа үүсгэсэн 2016 оноос хойш 7 жил өнгөрсөн байна. Ялагч 2017 оны 11 сараас хойш өмчлөлийн хөрөнгөө авч чадахгүй 6 жил болж байна.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Хураасан тогтоол	Үнэлгээг хүчингүй болгуулах, анхны албадан дуудлага худалдаа явуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн
2016.04.19		2016.06.08	2017.02.10	2017.12.08-нд шүүхэд хандсан. Албадан дуудлага худалдаа 2017.11.24-нд болж, ялагч тодорсон.

ДҮГНЭЛТ

- Ялагчид өмчлөх эрх шилжих асуудлыг зөв зохистой хуульчлах
- Үнэлгээний хүсэлтийг цаг хугацаанд нь өгөөгүй бол хүсэлтийг хүлээн авахгүй байх
- Дуудлага худалдаа болсны дараа үнэлгээний асуудлаар хүсэлт, эсхүл гомдол гаргахгүй.
- Дахин үнэлгээ хийлгэх үндэслэл буюу 6 сарын дараа үнэлгээн дэх үнийн гуравны хоёрт өөрчлөлт орсон бол дахин үнэлгээ хийлгэх хүсэлт гаргахдаа албадан дуудлага болсны дараа гаргахгүй байх.

4.Эд хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл бүхий иргэний хэргийн шийдвэр

2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн гүйцэтгэх хуудастай 147,196,000 төгрөгийг гаргуулах, төлбөр төлөгч Ө, Б нараас үүргийн гүйцэтгэлд барьцаалуулсан Ө-ийн өмчлөлийн ҮХЭХ-ийг дуудлага худалдаагаар худалдсан үнээс гаргуулах. гүйцэтгэх хуудастай, мөн оны 2 сарын 09-нд ажиллагаа эхэлсэн.

1.2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Ө, Б
Хариуцагч НШШГГ

Нэхэмжлэлийн шаардлага

2021 оны 09 сарын 13-ны өдрийн үнэлгээний тайланг хүчингүй болгуулах тухай (багаар үнэлсэн гэх)

Шийдвэрийн үндэслэл

Багаар үнэлсэн асуудал тогтоогдохгүй байх тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

2.2022 оны 05 сарын 2-нд Нийслэлийн Давж заалдах шатны шүүхийн магадлал

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж,

3.2022.07.06-нд УДШ-ийн иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзжээ.

Жич: 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр албадан дуудлага худалдаагаар тухайн хөрөнгийг худалдсан.

Албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах талаарх нэхэмжлэлийг 2022.10.27-нд шүүхэд гаргасан. Үндэслэл нь энэ талаар мэдээгүй гэх.

Шүүх нэхэмжлэгчийн хүсэлтээр 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр байрыг чөлөөлөх арга хэмжээг албадан дуудлага худалдааг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэл бүхий иргэний хэргийг шийдвэрлэж шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд ИХШХШТХ-ийн 69.1.5-д зааснаар шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулах тухай нэхэмжлэгчийн хүсэлтийг хангасан.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Хураасан тогтоол	Үнэлгээг хүчингүй болгуулах, анхны албадан дуудлага худалдаа явуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн
2021.01.27	2021.02.09	2021.08.24		2022 оны 02 сарын 22- нд анхан шатны шүүхийн шийдвэрээр шинжээч томилох тухай шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолыг хүчингүй болгуулах, үнэлгээг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Үүний дараа 2022.10.27-нд албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэл шүүхэд гаргасан, ажиллагаа түдгэлзсэн байна

ДҮГНЭЛТ

■ Мэдээгүй гэх үндэслэлээр албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахад шүүх мэдэгдсэн эсэхийг мэдээллийн сангаас харах, мэдэгдсэн бол гомдлыг авахгүй байх, мөн хуульд заасан хугацаанд гаргаагүй бол системээс харж гомдлыг авахгүй байх буюу гомдлыг хүлээж авахгүй буцаах зохицуулалтыг тодорхой тусгах;

■ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт “Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.” гэж заасан ч энэ талаар гомдол гараагүй ч ялагчид өмчлөх эрх шилжих тогтоол гарчихаад байхад албадан дуудлага худалдааг хүчингүйд тооцуулах, үнэлгээг хүчингүй болгуулах, дахин үнэлгээ хийлгүүлэх зэрэг нэхэмжлэлээс улбаалан ажиллагаа түдгэлзэж ялагч өмчлөгч өмчлөх эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна. Албадан дуудлага худалдааг хүчингүйд тооцуулах гомдлыг гаргах хугацааг нарийвчлан тогтоох буюу уг хугацаанд гаргаагүй бол гомдол гаргах эрхээ алдах, улмаар өмчлөгч ялагч шууд болох, төлбөрийг төлбөр авагчид шилжүүлэх.

5.Үнэлгээ хүчингүй болгуулах тухай болон албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах тухай

Үнэлгээг хүчингүй болгуулах тухай

1.2020.12.18 Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Д

Хариуцагч НШШГГ

Нэхэмжлэлийн шаардлага

Үнэлгээг хүчингүй болгуулах (зах зээлийн ханшаас багаар үнэлсэн)

Хэргийн талаар

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 2019.03.22-ны өдөр үүсгэж,
2020.03.03-нд ҮХЭХ-ийг битүүмжилж, 2020.08.25-ны өдөр хураасан.

2020 оны 09.18-нд үнэлгээчинг томилж, 2020.09.22-нд үнэлгээний тайланг ирүүлсэн байна. Талуудад 2020.09.24-ний өдөр хөрөнгийн үнэлгээг мэдэгдсэн бөгөөд **анхны албадан дуудлага худалдааг 2020.10.29-нд зохион байгуулахаар тогтоож, тогтоол, мэдэгдлийг 2020.10.14-нд хүргүүлсэн.**

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Үнэлгээчин эрх бүхий байх бөгөөд үнэлгээний тайландаа үнэлгээ хийсэн арга, аргалалаа тусгасан буюу үнэлэх ажиллагаа явуулахдаа хууль зөрчсөн гэх нөхцөл байдал тогтоогдоогүйгээс гадна нэхэмжлэгч шаардлагаа баримтаар нотолж чадаагүй тул нэхэмжлэл үндэслэлгүй байна. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож байна.

2.2021.02.05 Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Үндэслэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55.7 дахь хэсэгт заасан үнэлгээний талаар мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд энэ талаарх гомдлоо гаргаж болно гэж заасан. Гэвч нэхэмжлэгч Д үнэлгээний мэдэгдлийг 2020 оны 09 сарын 24-ний өдөр хүлээн авсан атлаа 2020 оны 10 сарын 5-нд шүүхэд гомдол гаргасан нь дээрх хуульд заасан хугацааг хэтрүүлсэн гэж үзнэ.

Үнэлгээчний харьцуулсан үл хөдлөх эд хөрөнгүүд нь хамгийн хямдаар худалдаалагдаж байсан гэдэг нь нотлогдоогүй, үнэлгээг хуульд нийцээгүй гэх үндэслэл хэргийн баримтаар тогтоогдоогүй болно. Дээрх шинжээчийн дүгнэлтийг няцаасан баримтыг нэхэмжлэгч шүүхэд гаргаагүй байх тул энэ талаар нэхэмжлэгчийн гомдлыг хангах боломжгүй.

3.2021.04.09-ний өдөр Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны тогтоолоор хяналтын журмаар гаргасан нэхэмжлэгчийн гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан.

Албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах тухай

4.2022.02.18-ны өдрийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

**Нэхэмжлэгч Д
Хариуцагч НШШГГ**

Хэргийн талаар

2020.10.29-нд анхны албадан дуудлага худалдаанд худалдан борлогдоогүй. 2020.12.17-нд шүүгчийн захирамжаар ажиллагааг түдгэлзүүлсэн. Ажиллагааг үргэлжлүүлэн 2021.09.14-ний өдөр хоёр дахь албадан дуудлага худалдааг явуулахаар тогтоол гарган 2021.09.16-нд мэдэгдэн, 2021.10.01-нд хуулийн дагуу зохион байгуулж, 225 сая төгрөгөөр борлогдсон болохыг талуудад 2021.10.06-нд мэдэгдсэн. 2021.10.13-нд өмчлөх эрх шилжсэн. 2021.10.27-ны өдөр нэхэмжлэлийг шүүх хүлээн авсан.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Хуульд заасан журмыг зөрчөөгүй тул нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

5.2022.05.09-нд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.

Жич: Ялагчид өмчлөх эрх шилжсэн. Султган чөлөөлсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт

71.10.Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсэн эсэх тухай дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэрийг тогтоосон хугацаанд танилцуулна. Энэ хугацаа нь 14 хоногоос хэтрэхгүй байна.

71.13.Энэ хуулийн 71.10-т заасан товлон тогтоосон хугацаанаас өмнө төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд дуудлага худалдааны ялагчид өмчлөх эрх үүсэхгүй.

71.14.Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно.

44.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.

44.4.Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Хураасан тогтоол	Үнэлгээг хүчингүй болгуулах, анхны албадан дуудлага худалдаа явуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн
--------------------------	------------------	--------------------------------	------------------	--

2019.01.22	2019.03.22	2020.03.03	2020.08.25	2020.10.05-нд үнэлгээг хүчингүй болгохоор, 2021 оны 10 сарын 27-нд албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэл тус тус шүүхэд гаргаж, 2022 оны 05 сарын 09- нд эцэслэн шийдвэрлэгдсэн.
------------	------------	------------	------------	--

ДҮГНЭЛТ

■ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан дуудлага худалдааг хүчингүйд тооцох гомдлыг тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид, мөн хуулийн 44.4 дэх хэсэгт заасны дагуу ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор хянаж, тогтоол гаргах бөгөөд тогтоолыг хүлээн зөвшөөрөөгүй бол хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргахаар байгаа ч ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хандалгүй өмчлөх эрх шилжсэний дараа 14 хоногийн дотор шүүхэд албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулахаар хандсан байна. Иймд албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг ямар үндэслэлээр, хэзээ гаргах талаар нарийвчлан зохицуулах.

■ Албадан дуудлага худалдаа болж, ялагч тодорсон ч тодорхой хугацаанд буюу 14 хоног хүртэлх хугацаанд төлбөрийг төлөх боломжийг төлбөр төлөгчид дагаж мөрдөж байгаа хуульд олгосон. Энэ хугацааг авсан бол албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах эрхгүй байх.

6. Үнэлгээ хүчингүй болгуулах тухай

1. 2020.06.03-ны СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч М ХХК, И ХК, иргэн Э болон Э
Хариуцагч Х банк

Хэргийн талаар

2019.05.29-ний өдрийн үндсэн хэргийг шийдвэрлэсэн шийдвэртэй, 2019.09.05-ны өдрийн гүйцэтгэх хуудас бүхий хариуцагчаас 8 тэрбум 203 сая, 24259 төгрөг гаргуулах, үүргийн гүйцэтгэлд барьцаалсан ҮХЭХ-ийг албадан гаргуулах

2019.09.18-ны өдөр ажиллагааг эхлүүлсэн, 2019.12.12-ны өдөр ҮХЭХ-ийг битүүмжилж, 2020.01.14-нд хураасан. 2020.02.12-ны өдөр үнэлгээний тайланг мэдэгдсэн.

2021.09.14-нд үнэлгээний талаарх хяналтын гомдлыг хангахгүй орхисон байна.

Дахин үнэлгээ тогтоосон 2022.01.12-ны үнэлгээний тайланг эс зөвшөөрч дахин шүүхэд гомдол гаргасан байна.

2022.12.19-ний өдрийн СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Үнэлгээг хүчингүй болгуулах тухай

Нэхэмжлэгч М ХХК, И ХК, иргэн Э болон Э
Хариуцагч Х банк

Шийдвэрийн үндэслэл

Нэхэмжлэлээсээ татгалзсан. Нэхэмжлэлтийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

2023.03.01-ний өдөр ажиллагааг түдгэлзүүлсэн. Учир нь 2022.01.12-ны өдрийн үнэлгээг хүчингүй болгуулахаар нэхэмжлэгч И ХК-ийн төлөөлөгч Б-ийн гаргасан гомдлыг шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлжээ.

Хоёр дахь дуудлага худалдаагаа хийх гээд түдгэлзсэн тул ажиллагаа зогссон байна.

Жич: 2019.09.08-нд эхэлсэн ажиллагаа 2023 оны 3 сарын байдлаар буюу 3 жил 6 сар түдгэлзсэн хоёр дахь дуудлага худалдааг явуулж чадахгүй байна. Учир нь төлбөр төлөгч нар ээлж дараалан үнэлгээ хүчингүй болгуулах, дахин үнэлгээг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан. Үндсэн шийдвэр гарснаас хойш 4 жил өнгөрсөн байхад хоёр дахь дуудлага худалдаанд орж чадахгүй байна.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Хураасан тогтоол	Үнэлгээг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн
2019.09.05	2019.09.18	2019.12.12	2020.01.14	2019.05.29-нд үнэлгээг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг анхан шатны шүүхээс хэрэгсэхгүй болгож, 2021.09.14-нд хяналтын гомдлыг хангахгүй орхисон. Дахин үнэлгээний 2022.01.12-ны тайланг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргасан тул 2023.03.01-нд ажиллагаа түдгэлзсэн байна. Хоёр дахь дуудлага худалдаанд орж чадахгүй байгаа.

7. Үнэлгээг хүчингүй болгуулах тухай

1. 2019.03.07-ны өдрийн БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч Т, Д

Хариуцагч НШШГГ

Үнэлгээг 2018.10.28-нд хийсэн бөгөөд 2018.10.31-нд талуудад мэдэгдсэн. 2018.12.18-нд үнэлгээний талаар гомдлыг шүүхэд гаргасан.

Нэхэмжлэлийн шаардлага

Зах зээлийн ханшаас доогуур үнэлсэн.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55.7 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор шүүхэд хандах боловч хугацааг хэтрүүлсэн болохыг дурдах нь зүйтэй гэж шүүхээс шийдвэртээ бичсэн.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан гомдлыг шүүх хэлэлцэнэ. Хуулийн дээрх зохицуулалтын дагуу хариуцагч НШШГГ-ын шийдвэр гүйцэтгэгч болон холбогдох албан тушаалтны үйл ажиллагаанд гаргасан гомдлоор шүүх хэргийг хүлээн авч шийдвэрлэх журамтайб Хариуцагчийн шинжээч томилохтой холбоотойгоор хийж гүйцэтгэсэн ажиллагаа төлбөр төлөгч нарын эрхийг зөрчсөн гэх үндэслэл хэрэгт авагдаагүй байна. Шинжээчээс үнэлгээний тайланг 2018.10.26-ны өдөр ШГБ-д хүлээлгэн өгч, шийдвэр гүйцэтгэгчээс 2018 оны 10 сарын 31-нд төлбөр төлөгчид мэдэгдсэн үйл баримт тогтоогдож байна.

2. 2019.06.08-ны Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Магадлалын үндэслэл

Шийдвэр гүйцэтгэгч ажиллагааг явуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2, 55.3 дахь хэсэгт заасан журмыг зөрчөөгүй гэж үзнэ. Мөн нэхэмжлэгч нар эд хөрөнгийг зах зээлийн ханшаас доогуур үнэлсэн гэх гомдлын үндэслэлээ нотлох баримтаа шүүхэд гарган өгөөгүй тул тэдгээрийг нотлох үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзсэн анхан шатны шүүхийн дүгнэлтийг буруутгах боломжгүй. Мөн нэхэмжлэгч нарыг ШШГТХ-ын 55.7-д заасан нэхэмжлэл гаргах хугацааг хэтрүүлсэн гэж анхан шаты шүүх дүгнэсэн нь зөв байна.

Жич: 2019 оны 11.12-нд хоёр дахь албадан дуудлага худалдааг зохион байгуулж худалдсан.

3. 2020.10.22-ны өдрийн БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

Нэхэмжлэгч А (хамтран өмчлөгч)

Хариуцагч НШШГГ

Нэхэмжлэлийн шаардлага

Үнэлгээг хүчингүй болгуулах тухай (дундын өмч тул өмчлөх эрх зөрчсөн гэх)

Хамтран өмчлөгч нь 2018 оны 10 сард 17 настай хүүхэд байсан бөгөөд Иргэний хуулийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн үед түүний ашиг сонирхлыг эцэг, эх Д, Т нь бүрэн талаалж ажиллагаанд оролцсон. Тус хөрөнгийг үндсэн гэрээний барьцаа болгон барьцаалуулсан байсан. 2018 оны 10 сард үнэлгээ тогтоосон.

Жич: 2018 оны 5 сард гүйцэтгэх хуудас бичигдэж, 2018 оны 6 сарын 18-нд ажиллагаа үүсгэж, 8 сарын 8-нд битүүмжлэн, 10 сарын 2-нд хураасан.

Хэрэгсэхгүй болгосон.

4.2020.12.28-ны өдрийн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.4 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлохгүй. Түүнчлэн дээрх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах үед нэхэмжлэгч А насанд хүрээгүй байсан тул эд хөрөнгийн үнэлгээг хүчингүй болгуулахаар гомдол гаргах эрхгүй.

5.2021.09.07-нд Улсын Дээд шүүхийн тогтоолоор гомдлыг хангахгүй орхисон.

Жич: 2021 оны 10 сарын 15-нд БЗД-ийн шүүхийн шүүгчийн захирамжаар нэхэмжлэгч А дуудлага худалдаанд оруулах тухай тогтоолыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасантай холбогдуулан ажиллагааг түдгэлзүүлсэн.

6.2022.05.05 БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хоёр дахь албадан дуудлага худалдааны тогтоолыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг 2022.04.05-нд гаргасан байна.

Нэхэмжлэгч А-ын эрхийг зөрчиж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулаагүй байна.

7.2022.07.30-ны Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Давж заалдах гомдлын хүрээнд хянаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

8.2022.10.10-нд Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны тогтоолоор нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан.

Гүйцэтгэх хуудас олгосон	Ажиллагаа үүссэн	Барьцаа хөрөнгийг битүүмжилсэн	Хураасан тогтоол	Үнэлгээг хүчингүй болгуулах талаар гаргасан төлөгчийн болон хамтран өмчлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн
2018.05	2018.06.18	2018.08.08	2018.10.02	2018.12.18-нд 2018.10.28-нд хийж, 10.31-нд талуудад мэдэгдсэн үнэлгээг хүчингүй болгуулах гомдол гаргаж, 2019.06.08-нд ДЗШШ-ийн магадлалаар эцэслэгдсэн. 2019.11.12-нд хоёр дахь АДХ-аар

				хөрөнгийг худалдсан. Хамтран өмчлөгч А-ын 2 удаагийн нэхэмжлэлээр (үнэлгээ, АДХ-г хүчингүй болгуулах) 2022.10.10-нд УДШ-ийн шийдвэрээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Ялагч тодорсноос хойш 2 жил өмчлөх эрх ялагчид шилжээгүй, төлбөр аваг төлбөрөө авч чадахгүй байсан.
--	--	--	--	--

ДҮГНЭЛТ

- Шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээчин томилсон шийдвэр, эсхүл үнэлгээг танилцуулах талаарх ажиллагаанд гомдол гаргах боломжтой байх, харин үнэлгээ өөрөө зөв, буруу эсэх дээр Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу дахин, нэмэлт үнэлгээ хийлгэх хүсэлт гаргах, энэ дагуу дахин, нэмэлт шинжилгээ хийлгэх гэж зааглах хэрэгтэй байна;
- Үнэлгээний хүсэлт гаргах болон шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээчин томилсон шийдвэр, үйл ажиллагаанд шүүхэд гомдол гаргах хугацаа хэтрүүлбэл гомдлыг хүлээж авахгүй байхаар зохицуулах;
- Хэд хэдэн төлбөр төлөгч байх тохиолдолд нэг нэгээрээ нэг асуудлаар гомдол гаргах боломжгүй болгох, гомдлыг нэгтгэх, түүнээс дарааллаж нэг нэгээрээ гаргахгүй байх;
- Барьцаатай тохиолдолд хамтран өмчлөгчийн хувийг тогтоохгүй, барьцаагүй тохиолдолд хувийг эхэлж тогтоох;
- Анхны албадан дуудлага худалдаа болсноос хойш гомдол гаргах үндэслэл, хугацаа, хоёр дахь дуудлага худалдаа болсноос хойш гомдол гаргах үндэслэл, хугацаа (барьцаагүй бол хамтран өмчлөгчид мэдэгдэх, барьцаатай бол хамтран өмчлөгчид мэдэгдэх шаардлагагүй. Энэ зарчмаар барьцаатай бол гомдол гаргах эрх хамтран өмчлөгчид байхгүй,)
- Албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах гомдол гаргах үндэслэлийг хуульчлах (мэдэгдээгүй, нийтэд зарлаагүй)

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Өмчлөгч гомдлыг аль ч үе шатанд гаргах байдлыг хязгаарлах
2. Барьцаатай бол, барьцаагүй бол хэрхэх гэдгээр ялгах. Өөрөөр хэлбэл, барьцаатай бол битүүмжлэх, хураах асуудал байхгүй шууд үнэлгээ хийлгэж, албадан дуудлага худалдаагаар худалддаг болох;
3. Барьцаагүй бол битүүмжлэх, эсхүл хураах, үүний дараа үнэлэх, дуудлага худалдаа зохион байгуулах гэж зохицуулах. Битүүмжлэх, хураах нь англи хэл дээр sieze байх ба үүний дараа шууд дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэр гаргадаг олон улсын зохицуулалт байна.

4. Судалгаанд орсон дээрх 7 шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас үзэхэд, битүүмжлэх ажиллагааг хийсний дараа битүүмжлэх тогтоолд гомдол гаргаж, ажиллагаа түдгэлзэж, гомдлыг хянаж дууссаны дараа буюу 2 жилийн дараа хураах ажиллагааг хийсэн байхад бусад тохиолдолд битүүмжилснээс хойш 2-8 сарын дараа хураах ажиллагаа хийсэн байна. Иймд барьцаагүй бол шууд хураах ажиллагаа явуулах.
5. Албадан дуудлага худалдаа явуулсны дараа үнэлгээчин томилсон шийдвэрийг хүчингүй болгохоор гомдол гаргах, дахин үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргахгүй байх
6. Үнэлгээний хүсэлт гаргаж дахин, эсхүл нэмэлт шинжилгээ хийлгэх шинжээчийг Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэгч томилох, харин үнэлгээчин, эсхүл шинжээч томилсон шийдвэрт шүүхэд гомдол гаргах (хугацааг нь тодорхой заах, хугацааг хэтрүүлсэн бол гомдлыг хүлээж авахгүй байх.)
7. Ажиллагаатай холбоотой гомдол гаргах үндэслэл, хуулийн хугацааг нарийвчлан заах, хугацаа хэтрүүлбэл гомдол гаргах эрхээ алдах, түүнчлэн мэдэгдсэн бол мэдэгдээгүй гэж гомдол гаргахгүй байх
8. Үндэслэлгүйгээр ажиллагаа удаашруулснаас төлбөр авагчид учирсан хохирлыг төлбөр төлөгч төлөх
9. Хураах хугацаа, үнэлгээ гаргах хугацааг тодорхой болгох
10. Ялагчид өмчлөх эрх шилжих, үүнээс хойш гомдол гаргахгүй байх, үүнээс өмнө холбогдох гомдлыг холбогдох хугацаанд гаргах.
11. Албадан дуудлага худалдаа болж, ялагч тодорсон ч тодорхой хугацаанд буюу 14 хоног хүртэлх хугацаанд төлбөрийг төлөх боломжийг төлбөр төлөгчид дагаж мөрдөж байгаа хуульд олгосон. Энэ хугацааг авсан бол албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах эрхгүй байх.
12. Хэд хэдэн төлбөр төлөгч байх тохиолдолд нэг нэгээрээ нэг асуудлаар гомдол гаргах боломжгүй болгох, гомдлыг нэгтгэх, түүнээс дарааллаж нэг нэгээрээ гаргахгүй байх;
13. Барьцаатай тохиолдолд хамтран өмчлөгчийн хувийг тогтоохгүй, барьцаагүй тохиолдолд хувийг эхэлж тогтоох;

---o0o---



European
Union



European Bank
for Reconstruction and Development

Холбоо барих мэдээлэл:

Veronica Bradautanu

vbradaut@ebrd.com

© Европын Сэргээн Босголт ба Хөгжлийн Банк

5 Банк Ст

Лондон

E14 4BG

Их Британи

Вэб сайт: ebrd.com

Бүх эрх хамгаалагдсан. Энэ тайланд агуулагдсан материалыг боловсролын болон арилжааны бус зорилгоор хуулбарлах, тараахыг зохиогчийн эрхийг эзэмшигчээс урьдчилан бичгээр зөвшөөрөлгүйгээр эх сурвалжийг нь бүрэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд зөвшөөрнө.

Энэ тайлангийн агуулга нь зохиогчдын үзэл бодлыг тусгасан бөгөөд ЕБРР-ийн үзэл бодлыг тусгасан байх албагүй.

Энэ тайланд газар зүйн болон бусад нутаг дэвсгэр, улс төр, эдийн засгийн бүлэглэл, нэгжүүдийг нэрлэхэд хэрэглэсэн нэр томьёо, нэр нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон түүний гишүүдийн аль нэг улсын байр суурийн талаар шууд буюу далд утгатай байр суурь, дэмжлэг, хүлээн зөвшөөрөл эсвэл санал бодлоо илэрхийлж байна гэж ойлгогдох ёсгүй. нутаг дэвсгэр, бүлэглэл ба нэгж, эсвэл хил хязгаарыг тогтоох, хэмжээгүй эрх мэдлийг.

Энэхүү тайланг боловсруулсан бөгөөд IDLO-г сонгох болон IDLO-гийн ажлын чанартай холбоотой аливаа хариуцлагаас чөлөөлсөн. IDLO-г сонгох, оролцуулах, хянах ЕБРР-ийн үүрэгтэй холбоотой эсвэл IDLO-гийн үйлчилгээг ашигласан эсвэл түүнд найдсанаас үүдэлтэй аливаа алдагдал, зардал, хохирол, хариуцлагын төлөө ямар ч хариуцлага хүлээхгүй. ЕБРР энэ тайланд тусгасан мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлын талаар шууд болон далд утгаар ямар ч баталгаа өгдөггүй. ЕБРР тайланд агуулагдсан аливаа мэдээллийг бие даан шалгаагүй бөгөөд Харьцуулсан судалгаанд агуулагдсан аливаа мэдээлэл, буруу ташаа эсвэл хайхрамжгүй байдлын төлөө ЕБРР